



# МОНГОЛ БАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2012



---

## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮГ



Эрхэмсэг хатагтай, ноёд оо!

Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдсэн, бус нутгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын орчин эрс муудсан, Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл 2011 оны сүүлийн улирлаас эхлэн муудаж эхэлсэн, эдийн засагт орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт 2012 онд буурсан, дотоодын хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчинд сөрөг өөрчлөлт гарсан зэргээр эдийн засаг, санхүүгийн зах зээлийн гадаад, дотоод орчинд тодорхой бус байдал, эрсдэлүүд бий болсон орчин нөхцөлд Монголбанкнаас төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, инфляцийг нэг оронтой тоонд байлгах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх үндсэн зорилт тавин ажиллалаа.

Улсын төсвийн урсгал зардлын 2011-2012 онууд дахь огцом тэлэлт болон Хүний хөгжил сангаас олгосон их хэмжээний бэлэн мөнгөний нийлүүлэлтээр өдөөгдсөн эрэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгаж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Монголбанк 2012 оны эхний хагаст мөнгөний бодлогыг чангруулах, банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг нэмэгдүүлэх шийдвэрүүдийг гарган, эрэлтийн гаралтай инфляцийн дарамтыг бууруулж хязгаарлав. Үүний зэрэгцээ Монголбанкнаас нийлүүлэлтийн гаралтай инфляцийг бууруулах, иргэдийн хэрэглээний суурь бараа, бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн зах зээлийн зарчимд сууриссан, байнгын тогтолцоог бий болгох зорилгоор Засгийн газартай хамтран “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг УИХ-ын холбогдох тогтоол шийдвэр, Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн хүрээнд батлан, хэрэгжүүлж эхлээд байна. Үүний үр дүнд олон жилийн турш өндөр инфляцийн гол шалтгаан нь болж байсан нийлүүлэлтийн гаралтай буюу зардлын шалтгаантай инфляцийн дарамтыг эрс бууруулан, инфляцийг зорилтот түвшинд нь хүргэж, улмаар нам, тогтвортой түвшинд байлгах, нийгмийн дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх харилцан уялдаатай, цогц бодлого хэрэгжүүлэх замаар эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах нөхцөлийг бий болгоно.

Ийнхүү 2012 онд Монголбанкнаас эрэлтийн болон нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийг бууруулах бодлогын арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлснээр 2012 оны 11-12 дугаар саруудад инфляци улсын хэмжээнд 1%, Улаанбаатар хотод 0.5% болж, 2011 оны мөн үеэс харгалзан 2.3 нэгж хувь, 1.5 нэгж хувиар тус тус буурсан юм. Улмаар инфляцийн дарамт цаашид буурах, төсөөлөл нь 2013 оны болон дунд хугацааны зорилтот түвшинтэй нийцтэй байх боломж ийнхүү бүрдэв.

Монголбанк санхүүгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд банкны салбарын эрсдэл

даах чадварыг дээшлүүлэн, банкуудын төлбөрийн чадварыг сайжруулан ажиллаа. Түүнчлэн, банкны харилцагчдыг хамгаалж, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх боллогын хүрээнд хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын нэгдсэн тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчинг бүрдүүлж байна.

2012 онд Монголбанк төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг ханган ажиллаж, бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэн, Төлбөр тооцооны системийн шинэчлэлийг дунд хугацаанд эрчимжүүлэх зорилт тавин ажилласан болно.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бүрэн агуулгаараа хэрэгжиж эхлээгүй, төсвийн сахилга бат хангагдаагүй орчноос гадна 2011-2012 оны мөчлөг дагасан, хавтгайрсан халамжийн бодлого нь дотоодын эдийн засаг дахь үрэлгэн хэрэглээг дэмжиж, төлбөрийн тэнцлийн дарамтыг нэмэгдүүлэн, макро эдийн засгийн суурийг эмзэг болгоход нөлөөлж, нийт эдийн засгийн эрсдэлийг огцом нэмэгдүүлсэн бөгөөд энэхүү алдаатай боллогын сөрөг үр дагавар нь 2012 онд Монголбанкинд мөнгөний бодлогоор эдийн засгийн бодит секторыг дэмжих боломж, орон зай олгоогүй юм.


Харин 2013 оноос эхлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бүрэн утгаараа хэрэгжиж эхлэх бөгөөд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг бууруулах мөнгөний уламжлалт бус бодлого үргэлжлэх, Монгол Улсын Засгийн газраас олон улсын зах зээлд анх удаа 1.5 тэрбум ам.долларын үнэт цаасыг 2012 оны 12 дугаар сард амжилттай арилжаалж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлсэн зэрэг зерэг өөрчлөлтүүд гараад байна. Эдгээр нь 2013 онд гадаад орчны сөрөг өөрчлөлтийн дотоодын эдийн засаг дахь нөлөөллийг бууруулах, мөчлөг сөрсөн макро бодлого хэрэгжүүлэх замаар эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг зөвлүүлэн нийт эдийн засгийг тогтвржуулах, санхүүгийн салбарыг болзошгүй эрсдэл, аюулаас сэргийлэх, мах, гурил, шатахуун зэрэг иргэдийн суурь хэрэглээний барааны үнийн өсөлтийг сааруулах болон ДНБ-ий бодит өсөлтийг тогтвржуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлж өглөө.

Иймд, ирэх оны мөнгөний бодлого нь эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөл болсон макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засаг, санхүүгийн салбарыг болзошгүй эрсдэлээс сэргийлэх, дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэхэд тус тус чиглэх болно.



Н.ЗОЛЖАРГАЛ  
Монголбанкны Ерөнхийлөгч

## МОНГОЛБАНКНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



## ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ	
1.1 Бодит сектор	7
1.2 Гадаад сектор	9
1.3 Мөнгө, санхүүгийн сектор	13
1.4 Улсын төсөв	21
2. ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ	
2.1 Мөнгөний бодлогын үндсэн зорилт, арга хэмжээ, үр дүн	25
2.2 Санхүүгийн тогтвортой байдал	30
2.3 Валютын ханшийн бодлого	36
2.4 Гадаад валютын улсын нөөцийн удирдлага	38
2.5 Монгол Улсын төлбөр тооцооны систем	40
2.6 Банк, санхүүгийн салбарын хууль эрх зүйн шинэчлэл	42
3. НЭЭЛТТЭЙ ЗАХ ДАХЬ МОНГОЛБАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА	
3.1 Төвбанкны үнэт цаас	45
3.2 Төвбанкны санхүүжилт	45
3.3 Засгийн газрын үнэт цаас	46
3.4 Гадаад валютын дуудлага худалдаа	47
3.5 Дотоод зах зээлээс алт худалдан авалт	47
4. МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАН	
4.1 Монголбанкны бүтэц, зохион байгуулалт	49
4.2 Гадаад харилцаа	49
4.3 Олон нийттэй харилцах харилцаа	51
4.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ	52
4.5 Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага	53
4.6 Бэлэн мөнгөний хангарт	54
4.7 Мэдээллийн технологи	55
4.8 Монголбанкаас 2012 онд баталсан баримт бичгүүд	56
5. АУДИТЫН ТАЙЛАН	61
6. ХАВСРАЛТУУД	121

## 1.1 Бодит сектор

### *ДНБ-ий бодит өсөлт*

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий бодит өсөлт 2012 онд 12.3 хувьтай гарлаа. Оны эхний улиралд Монгол Улсын эдийн засгийн өсөлт жилийн 17.8 хувь буюу сүүлийн 20 гаруй жилийн хамгийн өндөр түвшинд гарсан ч, дараагийн улирлуудад өсөлтийн хурд нь бага зэрэг саарав. Европын улсуудад үүссэн өрийн хямрал, Хятадын эдийн засгийн өсөлт 8.9 хувиас 2012 оны эцэс гэхэд 7.9 хувь болж саарсан нөхцөл байдал, дэлхийн зах зээлд зэсийн үнэ буурч, нүүрсний үнэ төдийлөн нэмэгдээгүй /Зураг 1/ төлөв байдал, гадаад худалдааны нөхцөл 2011 оны 4 дүгээр улирлаас эхлэн муудсан, Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт 2012 оны эхнээс буурсан хандлагууд нь манай улсын ДНБ-ий бодит өсөлт ийнхүү саарахад нөлөөллөө.



Монгол Улсын ДНБ-ийг худалдаалагддаг болон худалдаалагдаггүй салбараар нь ангилан авч үзвэл уул уурхайн салбарын үйлдвэрлэл эрчимтэй байсан жилүүдэд үйлчилгээний салбар, тэр дундаа нийтийн хоол, зочид буудлын үйлчилгээний салбарын өсөлт өндөр байжээ /Зураг 2/. Харин 2012 онд экспортын түүхий эдийн үнэ буурсан, эдийн засагт цэвэр дүнгээр орж ирэх валютын ургсал багассан зэргээс шалтгаалж, уул уурхайн салбарын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл бага зэрэг буурсан нь ажиглагдаж байна.


Салбарын ангиллаар нь авч үзвэл үйлчилгээний салбар ДНБ-ий өсөлтийн дийлэнх хэсгийг эзэлж байгаа хэдий ч, оны эцэстээ буурах хандлагатай болсон бол нийт өсөлтөд хөдөө аж ахуй (ХАА)-н салбарын эзлэх хувь хэмжээ нэмэгдсэн, харин уул уурхайн салбарынх тогтвортой байсан байна. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий задаргаанаас харахад 2009 оны хямралын үеэс бусад үед гадаад худалдааны алдагдал ихэссээр 2012 оны байдлаар ДНБ-ий 50 хувьд хүрсэн бөгөөд эдийн засаг дахь хуримтлал бага, хэрэглээ зонхилсон зохицой бус бүтэцтэй байсаар байна. Энэ нь эдийн засгийн дархлаа сул байхад нөлөөлж байгаа тул үндэсний хуримтлалыг нэмэгдүүлэх нь ДНБ-ийг ург хугацаанд тогтвортой өсгөх суурь нөхцөл болох юм.

Хүснэгт 1: ДНБ-ий бодит өсөлт (үйлдвэрлэлийн аргаар)

ДНБ өсөлт	2012			
	I	II	III	IV
XAA	0.1%	1.4%	2.2%	2.9%
Үул уурхай	1.4%	1.6%	1.4%	1.4%
Аж үйлдвэр /үүл уурхайгаас бусад/	1.2%	1.4%	1.2%	0.8%
Үйлчилгээ	7.1%	6.0%	6.1%	5.7%
Бүтээгдхүүний цэвэр татвар	7.7%	7.4%	4.2%	1.1%

Эх сурвалжууд: Ундэсний статистикийн хороо


Зураг 3: ДНБ-ий задаргаа (эцсийн ашиглалтын аргаар)



### Ажиллах хүч

2011 оны эцсийн байдлаар Монгол Улсын нийт ажиллах хүч 1124.7 мянга байгаагаас 53 хувь нь эрэгтэйчүүд, 47 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажиллагсдын тоо өсч 1037.7 мянгад хүрснээр хөдөлмөр эрхлэлтийн түвшин 92.3 хувь, ажилгүйдлийн түвшин 7.7 хувь болов.

Зураг 4: Нийт ажиллах хүч



Эх сурвалж: Ундэсний статистикийн хороо

Зураг 5: Аж үйлдвэрлэлийн салбарт ажиллагсад



2012 оны эцсийн байдлаар аж үйлдвэрлэлийн салбарт ажиллагсдын тоо 61.7 мянгад хүрсэн нь өмнөх оноос 7.2 хувиар өссөн үзүүлэлт болов. Боловсруулах аж үйлдвэрлэлийн салбарт хамгийн олон буюу нийт аж үйлдвэрлэлийн салбарт ажиллагсдын 45.4 хувь болох 28 мянган хүн, уул уурхай, олборлох аж үйлдвэрт 31.1 хувь болох 19.2 мянган хүн ажиллаж байна. Үлдсэн 23.5 хувь болох 14.5 мянган ажиллагсад цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн салбарт ажиллаж байна.

## Хөдөлмөрийн бүтээмжс

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2012 оны эцсийн байдлаар 3.9 их наяд төгрөгт, нэг ажилчинд ногдох үйлдвэрлэл буюу хөдөлмөрийн бүтээмж 2005 оны зэрэгцүүлэх үнээр 38 сая төгрөгт хүрчээ.

Хөдөлмөрийн бүтээмж уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хамгийн их буюу 69.8 сая төгрөгт байгаа ч, тус салбарын нэг ажилчинд ногдох үйлдвэрлэлийн хэмжээ 2011 оноос 1 хувиар буурчээ. Харин боловсруулах аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж тогтвортой байгаа бол цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын нэг ажилчинд ногдох үйлдвэрлэлийн хэмжээ 17 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 3.1 хувиар нэмэгджээ.

### Хүснэгт 2: Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж

Хөдөлмөрийн бүтээмж** /2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая.төг/	2009	2010	2011	2012*	2012/2011 (%)
Нийт аж үйлдвэрийн салбар	34.6	36.5	37.7	38.0	0.8%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	70.0	69.1	70.5	69.8	-1.0%
Боловсруулах аж үйлдвэр	23.7	25.7	26.4	26.5	0.1%
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	14.9	15.7	16.5	17.0	3.1%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо /\*- урьдчилсан гүйцэтгэл, \*\*- нэг ажилчинд ногдох нийт үйлдвэрлэл/

## 1.2 Гадаад сектор

### Төлбөрийн тэнцэл

2012 онд төлбөрийн тэнцлийн урсгал данс 3,362.3 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 4,929.5 сая ам.долларын ашигтай, төлбөрийн нийт тэнцэл 1,705.0 сая ам.долларын ашигтай гарлаа.

Зураг 6: Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл




Эх сурвалж: Монголбанк

Урсгал тэнцэл


Үргал тэнцлийн алдагдал 2012 онд 3,362.3 сая ам.долларт хүрч өмнөх оноос 22 хувиар өсчээ. Үүнд барааны гадаад худалдааны алдагдал өмнөх оноос 56 хувиар өсч 1,553.3 сая ам.долларт, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 5 хувиар буурч 1,100.3 сая ам.долларт хүрсэн нь голлон нөлөөлжээ. Бараа болон үйлчилгээний гадаад худалдааны алдагдал ийнхүү өссөнийг экспортын чулуун нүүрс, зэсийн баяжмалын биет хэмжээ болон хилийн үнэ буурсан, нефтийн бүтээгдэхүүний импорт өссөн, тээврийн үйлчилгээний алдагдал эрс нэмэгдсэн зэрэг үндсэн хүчин зүйлс тайлбарлаж байна.

Монгол Улсын урсгал тэнцлийн алдагдал 2007 он хүртэл харьцангуй тогтвортой бага түвшинд буюу дунджаар ДНБ-ий 6 хувьтай тэнцэх хэмжээнд байсан бол 2008 онд эдийн засгийн халалт, төсвийн огцом тэлэлт, импортын өсөлттэй уялдан ДНБ-ий 12 хувьд хүрч байв. Харин мөчлөг дагасан төсвийн тэлэлт, хавтгайрсан халамжаар тэтгэгдсэн хэрэглээний зээл болон хэрэглээний бараа, бүтээгдхүүний импортын огцом өсөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн тоног төхөөрөмжийн импортын өсөлт болон үйлчилгээний гадаад худалдааны алдаглаас шалтгаалж 2011 онд ДНБ-ий 32 хувьд хүрсэн бол 2012 оны гүйцэтгэлээр 33 хувьтай тэнцэх хэмжээнд байна.

Зураг 7: Урсгал тэнцлийн бүтэц



Зураг 8: Хөрөнгө ба санхүүгийн тэнцлийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк

## *Хөрөнгө ба санхүүгийн тэниэл*

Тайлант онд хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 4,929.5 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 72 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд 2011 онд 77 сая ам.доллар байсан багцын хөрөнгө оруулалт 2,325.4 сая ам.долларт хурч өссөн нь голлон нөлөөлжээ.

Тайлант онд хөрөнгө ба санхүүгийн дансанд лараах өөрчлөлтүүл оржээ.

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 4,407.8 сая ам.долларт хүрч, 2011 оноос 5 хувираа буурсан;
  - Багцын хөрөнгө оруулалтын дансны ашиг өмнөх оноос огцом өсөхөд: (i) Хөгжлийн банк 578 сая ам.долларын бондыг Засгийн газрын баталгаатайгаар арилжаалсан, (ii) Худалдаа хөгжлийн банк 300 сая ам.долларын корпорацийн бонд гаргасан, (iii) Засгийн газар 1,500 сая ам.долларын бондыг олон улсын зах зээлд анх удаа арилжаалсан нь тус тус нөлөөлсөн;
  - Бусад хөрөнгө оруулалтын дансны алдагдал 29.2 сая ам.доллараар буурахад экспорт, импортын худалдааны санхүүжилтийн өөрчлөлт голлон нөлөөлжээ.

*Гадаад хөрөнгө оруулалтын позиц*

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2012 оны гүйцэтгэлээр -14,219.4 сая ам.доллар байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 14 тэрбум ам.доллараар их гэсэн үг юм. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО), багцын болон бусад хөрөнгө оруулалт, ялангуяа ГШХО-тай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчаасаа татсан зээлийн санхүүжилтийн үлдэгдлээс голлон хамаарч байна.

**Хүснэгт 3: Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц (сая ам.доллар)**

<b>A. ГАДААД АКТИВ</b>	<b>6,380.0</b>	<b>B. ГАДААД ПАССИВ</b>	<b>20,599.5</b>
<b>1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)</b>	<b>1,191.4</b>	<b>6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)</b>	<b>13,458.2</b>
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин оруулалт	1,190.6	6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин оруулалт	5,100.9
1.2 Бусад хөрөнгө	0.8	6.2 Бусад хөрөнгө	8,357.4
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>105.6</b>	<b>7. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>2,689.4</b>
2.1 Хөрөнгийн хувьцаа	100.9	7.1 Хөрөнгийн хувьцаа	112.9
2.2 Өрийн бичиг	4.7	7.2 Өрийн бичиг	2,576.5
<b>3. Санхүүгийн дериватив</b>	<b>0.0</b>	<b>8. Санхүүгийн дериватив</b>	<b>0.0</b>
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>956.9</b>	<b>9. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>4,451.8</b>
4.1 Худалдааны зээл	383.5	9.1 Худалдааны зээл	252.1
4.2 Зээл	14.9	9.2 Зээл	3,621.5
4.2.1 Төв банк	0.0	9.2.1 Төв банк	77.9
4.2.2 Засгийн газар	0.0	9.2.2 Засгийн газар	2,184.1
4.2.3 Банк санхүүгийн байгууллага	14.9	9.2.3 Банк санхүүгийн байгууллага	336.8
4.2.4 Аж ахуйн нэгж	0.0	9.2.4 Аж ахуйн нэгж	1,022.7
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	558.5	9.3 Бэлэн мөнгө ба харилцах	142.3
4.4 Бусад актив	0.0	9.4 Бусад пассив	436.0
<b>5. Нөөц актив</b>	<b>4,126.1</b>	<b>B. ПОЗИЦ</b>	<b>(14,219.4)</b>
5.1 Мөнгөжсөн алт	195.3		
5.2 Зээлжих тусгай эрх	68.0	10. Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	(12,266.8)
5.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө (цэвэр)	0.2	11. Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	(2,583.7)
5.4 Бэлэн валют ба харилцах	2,303.2	12. Санхүүгийн дериватив (цэвэр)	0.0
5.5 Үнэт цаас	1,559.3	13. Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	(3,494.9)
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)	0.0	14. Нөөц актив	4,126.1
5.7 Бусад нөөц актив	0.0		

Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсаас эдийн засгийн харьятад буст оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 6,380.0 сая ам.доллар байна. Үүний 65 хувийг гадаад шууд хөрөнгө оруулалт, 15 хувийг бусад хөрөнгө оруулалтын актив, 19 хувийг шууд хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьятад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 20,599.5 сая ам.долларт хүрсэн байна. Үүний 65 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 22 хувийг бусад хөрөнгө оруулалтын пассив, үлдсэн 13 хувийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 38 хувийг буюу 5,100.9 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 62 хувь буюу 8,357.4 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл эзэлж байна.

## Хүснэгт 4: Гадаад хөрөнгө оруулалтын позиц, данс тус бүрээр /сая ам.доллар/

	12/31/2010	12/31/2011	3/31/2012	6/30/2012	9/30/2012	12/31/2012
<b>Нийт позиц</b>	<b>(1,678.4)</b>	<b>(7,692.3)</b>	<b>(9,741.3)</b>	<b>(11,308.5)</b>	<b>(12,785.8)</b>	<b>(14,219.4)</b>
Гад. шууд хөр.оруулалтын позиц	(2,048.1)	(7,602.5)	(9,071.9)	(10,575.4)	(11,689.3)	(12,266.8)
Багцын хөр.оруулалтын позиц	(229.8)	(312.8)	(882.6)	(900.3)	(1,150.3)	(2,583.7)
Сан.үүсмэл.хэр-ийн позиц	(0.0)	(0.0)	(0.0)	(0.0)	-	-
Бусад хөр.оруулалтын позиц	(1,688.4)	(2,227.6)	(2,691.5)	(2,741.0)	(2,850.0)	(3,494.9)
ГВАН-ийн үлдэгдэл	2,288.0	2,450.6	2,904.6	2,908.2	2,903.8	4,126.1

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх 2011 оноос 85 хувиар буюу 6,527.1 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнийг:

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 18 хувиар буюу 959.8 сая ам.доллараар, гадаад пассив 51 хувиар буюу 6,951.2 сая ам.доллараар нэмэгдсэнээр,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 61 хувиар буюу 4,664.3 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалтын богино позиц 8 дахин буюу 2,270.9 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалт 57 хувиар буюу 1,267.3 сая ам.доллараар тус тус нэмэгдсэнээр тайлбарлаж болохоор байна.

*Гадаад өр*

Монгол Улсын нийт гадаад өр (улсын секторын болон хувийн хэвшлийн)-ийн үлдэгдэл 2012 оны эцэст 15,385.7 сая ам.долларт хүрч 2011 оны эцсийн гүйцэтгэлээс 60%-иар буюу 5,758.2 сая ам.доллараар өсчээ. Үүнд:

- Олон улсын санхүүгийн зах зээлд арилжаалсан 1.5 тэрбум ам.долларын “Чингис” бонд, 580 сая ам.долларын Хөгжлийн банкны бондын эх үүсвэр,
- Худалдаа хөгжлийн банкнаас гадаад зах зээлд гаргасан 300 сая ам.долларын бондын эх үүсвэр,
- Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулагчаасаа авсан зээлийн эх үүсвэр 45 хувиар буюу 2.6 тэрбум ам.доллараар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Засгийн газрын болон түүний баталгаатай гадаад зээлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2009 онд 40%, 2010 онд 29%, 2011 онд 22%, 2012 онд 41%-д байна.

## Хүснэгт 5: Монгол улсын нийт гадаад өр (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2009	12/31/2010	12/31/2011	12/31/2012	Өөрчлөлт	
					Дун	Хувь
<b>Нийт гадаад өр</b>	<b>2,985.8</b>	<b>5,928.0</b>	<b>9,627.5</b>	<b>15,385.7</b>	<b>5,758.2</b>	<b>60%</b>
I. Засгийн газар	1,818.1	1,787.6	1,950.9	4,264.1	2,313.3	119%
II. Төв банк	245.6	273.6	267.7	413.9	146.2	55%
III. Банк	341.1	505.9	709.9	1,074.4	364.5	51%
Богино хугацаат	112.7	76.9	81.7	58.2	-23.5	-29%
Урт хугацаат	228.4	429.1	628.2	1,016.1	387.9	62%
IV. Бусад сектор	361.7	645.6	948.7	1,276.0	327.3	34%

Богино хугацаат	135.5	288.6	501.6	508.2	6.7	1%
Урт хугацаат	226.2	356.9	447.2	767.7	320.6	72%
<b>V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл</b>	<b>219.3</b>	<b>2,715.3</b>	<b>5,750.4</b>	<b>8,357.4</b>	<b>2,607.0</b>	<b>45%</b>

Эх сурвалж: Засгийн газрын мэдээллийг Сангийн яам, бусад мэдээллийг Монголбанк боловсруулав

### 1.3 Мөнгө, санхүүгийн сектор

#### Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

2012 онд экспортын орлого буурч, импорт өссөнөөр гадаад худалдааны алдагдал өссөний зэрэгцээ ургал дансны алдагдлыг санхүүжүүлж байсан гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан нь гадаад цэвэр актив /ГЦА/ 24.5 хувиар буурахад нөлөөлөв (Зураг 9). Энэ нөхцөл байдал нь дотоодын мөнгө, зээлийн өсөлтийг сааруулахад нөлөөлж, улмаар зээлийн тасалдал бий болох, санхүүгийн салбар хямрах, макро тогтвортой байдлыг алдагдуулах, санхүү, эдийн засгийн болзошгүй хямралд хүргэх бодитой эрсдэлийг бий болгож байлаа.

Иймд төрөөс гадаад цэвэр актив буурсны эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг саармагжуулах зорилгоор 2012 оны 4 дүгээр улирлаас эхлэн дотоод цэвэр активыг нэмэгдүүлэх, улмаар мөнгө, зээлийн өсөлтийг тогтвржуулах шаардлага бий болсон юм.


Хөгжлийн банк, Засгийн газрын санхүүжилт, Монголбанкнаас хэрэгжүүлсэн эдийн засгийг тогтвржуулах арга хэмжээний хүрээнд нэмэгдүүлсэн дотоод эх үүсвэрийн нөлөөгөөр мөнгө, зээлийн өсөлт тогтвржиж, дотоод цэвэр актив /ДЦА/ 65.2 хувиар өсөв. Мөнгөний нийлүүлэлтийн гадаад эх үүсвэрийн бүрэлдэхүүн хэсэг нь буурсан ч, дотоод эх үүсвэр өссөнөөр M2 мөнгө 2012 онд 18.8 хувиар өслөө.

Дотоод зээлийн өрийн үлдэгдэл 2010 оны эхнээс эрчимтэй өссөөр 2011 оны 11 дүгээр сард жилийн өсөлт нь 75 хувь буюу хамгийн өндөр түвшинд хүрсэн. Үүнээс хойш өсөлтийн хурдац нь саарсаар гадаад эх үүсвэрийн бууралтаас шалтгаалан 2012 оны 12 дугаар сарын байдлаар 24 хувь болж буурчээ.

Пассив талаас нь авч үзвэл M2 мөнгөний өсөлтөд бараг мөнгө, үүний дотор валютын харилцах голлох нелеөг үзүүлсэн байна (Зураг 9). M1 мөнгөний өсөлтийн хурдац 2012 онд огцом багаслаа.

Мөнгөний нийлүүлэлтийг бүтцээр нь авч үзвэл сүүлийн жилүүдэд банкнаас гадуурх мөнгөний эзлэх хувийн жин буурч, төгрөгийн харилцах ба хадгаламжийн эзлэх хувийн жин нэмэгджээ. 2012 оныг өмнөх онтой харьцуулахад мөнгөний нийлүүлэлтэд төгрөгийн харилцахын эзлэх жин буурч, харин валютын хадгаламжийн жин өссөн байна.


Зураг 9: M2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн: актив\*, пассив



\* Засгийн газрын 1.5 тэрбум ам.долларын бондыг ГЦА, Засгийн газрын харилцахаас хассан болно.

Эх сурвалж: Монголбанк

Зураг 10: M2 мөнгөний бүтэц




Эх сурвалж: Монголбанк

### Инфляци

Хэрэглээний үнийн индексээр тооцсон жилийн инфляци 2012 оны эцэст улсын хэмжээнд 14 хувь, Улаанбаатар хотод 14.2 хувь байв. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлтийг бүлгээр нь авч үзвэл согтууруулах ундаа, тамхины үнэ 54.6 хувь, хүнсний барааны үнэ 19.9 хувь, боловсролын үйлчилгээнийх 16.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 13 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 11.7 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр өсөлттэй бүлгүүд байлаа. Хэрэглээний үнийн индекс 2011 оноос 14.2 хувиар өсөхөд 41.4 хувийг хүнсний барааны, 13.3 хувийг согтууруулах ундаа, тамхины, 12.1 хувийг хувцас, бөс бараа, гутлын, 9 хувийг орон сууц, ус, цахилгаан, түлшний, 6.8 хувийг тээврийн бүлгийн бараа, үйлчилгээний, 6.8 хувийг боловсролын үйлчилгээний үнийн өсөлт тус тус бүрдүүлсэн байна.

Улаанбаатар хотын жилийн инфляци оны эхний саруудад хурдацтай өсч 4 дүгээр сард энэ оны хамгийн өндөр түвшин болох 17.8 хувьд хүрсэн нь голчлон махны үнийн огцом өсөлтөөс шалтгаалсан. Тухайн үед үхрийн цул мах, хонины ястай махны үнэ оны эхнээс тус бүр 59.1 хувь, 59.3 хувиар өссөн байв. Харин 4 дүгээр сараас махны үнийн өсөлт саарч, 6 дугаар сараас тээврийн бүлгийн үнийн өсөлт буурсантай холбоотойгоор жилийн инфляци 2 дугаар улирлын төгсгөл рүү алгуур буурсан.



Эх сурвалж: Ундэсний статистикийн хороо

Мах болон хүнсний ногооны үнэ оны эхний хагаст хурдацтай өссөн бол улирлын нөлөөгөөр оны сүүлийн саруудад буурсан нь жилийн инфляцийн түвшин оны сүүлийн хагаст буурахад голчлон нөлөөлжээ.

Инфляцийн хүлээлт, эрэлтийн хүчин зүйлсийг илүү бодитой илэрхийлэх, түүнийг нийлүүлэлтийн огцом цочролоос ялгаж шинжлэх үүднээс улирлын хэлбэлзэл ихтэй мах, сүү, хүнсний ногоо болон богино хугацааны нөлөөллөөс шалтгаалж хэлбэлзэл ихтэй байдаг нийт 27 төрлийн барааг хэрэглээний сагснаас хасч, Улаанбаатар хотын суурь инфляцийг тооцоход 2012 оны эцсийн байдлаар 11.1 хувь байна.

#### Санхүүгийн салбарын хөгжил

##### Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд болон зохистой харьцааны үзүүлэлтүүд

Банкны салбарт тайлант оны эцсийн байдлаар 14 банк 1382 салбар, нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 264 мянгаар нэмэгдэж, 2.1 саяд, зээлдэгчдийн тоо 8.4 мянгаар нэмэгдэж, 614.6 мянгад тус тус хүрлээ.

Монголбанкаас Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байгаа дэд хөтөлбөрүүд, урт хугацаат эх үүсвэрийн татан төвлөрүүлэлт, харилцах, хадгаламжийн өсөлттэй уялдан нийт эх үүсвэрийн хэмжээ 10.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 23.1 хувь буюу 1.9 их наяд төгрөгөөр өсчээ. Эх үүсвэрийн хэмжээ ийнхүү өссөнөөр банкны салбарын нийт активын хэмжээ 11.4 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 24.2 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Нийт активын 22.3 хувийг мөнгөн хөрөнгө, 10.3 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 58.6 хувийг зээлийн өрийн үлдэгдэл, үлдэх 8.8 хувийг бусад актив бүрдүүлж байна.

Банкуудын төлбөрийн чадварын харьцааны өөрчлөлт тогтвортой байж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 38.7 хувьд хүрэв. Мөнгөн хөрөнгийн хэмжээ 2.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 24.9 хувиар буюу 508.5 тэрбум төгрөгөөр өсчээ. Банкууд төв банкин дахь нөөцөө нэмэгдүүлсэн нь мөнгөн хөрөнгийн хэмжээ нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Богино хугацаат хөрөнгө оруулалтын хэмжээ 1.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 4.4 хувиар буюу 49.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Засгийн газрын үнэт цаасанд банкуудын оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ тайлант оны эцсийн байдлаар 295.5 тэрбум төгрөгт хүрч 1.7 дахин нэмэгдсэн. Тайлант онд төв

банкны үнэт цаасны хэмжээ 762 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 14.5 хувиар буюу 129.4 тэрбум төгрөгөөр буурчээ. Ингэснээр банкуудын хөрвөх чадвар илүү өндөртэй буюу мөнгөн хөрөнгөд байршуулах хөрөнгийн хэмжээ нэмэгдэж, хөрөнгө гэнэт гадагшлах тохиолдолд үүсч болзошгүй эрсдэлийг бууруулах чадавхи нь нэмэгдсэн байна.

Тайлант онд нийт зээлийн үлдэгдэл 6.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1.4 их наяд төгрөгөөр бууюу 25.2 хувиар өсөн, дотоодын нийт бүтээгдэхүүний 50 хувьд хүрлээ. Нийт зээлийн 96.2 хувь болох 6.6 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 1.6 хувь болох 109.6 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ангилалд ангилагдсан нь өнгөрсөн оноос хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ өссөнийг харуулж байна. Зээлийг эдийн засгийн салбараар авч үзвэл бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 16.6 хувь буюу 1.1 их наяд төгрөг, үл хөдлөх хөрөнгийн салбарт 14.2 хувь буюу 0.9 их наяд төгрөг, барилгын салбарт 12.9 хувь буюу 0.8 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлд эзлэх тухайн салбарын хувь хэмжээг өмнөх онтой харьцуулахад барилгын салбар 1.2 нэгжээр өссөн бол уул уурхайн салбар 0.6 нэгжээр буурчээ.

Зээлийн чанарын үзүүлэлт болох чанаргүй зээлийн хэмжээ өнгөрсөн оноос 19.6 тэрбум төгрөгөөр бууюу 11.7 хувиар буурч 147.9 тэрбум төгрөгт хүрлээ. Чанаргүй зээлийн харьцаа 2.2 хувьд хүрч, өмнөх оноос 0.9 нэгж хувиар буурчээ. Энэ нь банкуудын зээлийн эргэн төлөлт, зээлийн чанар сайн байгааг харуулж байгаа төдийгүй зээлийн үйл ажиллагаанд тавих хяналт сайжирсныг илэрхийлнэ. Гол салбаруудад олгосон зээлийн чанарыг авч үзвэл барилгын салбарын зээлийн 3.4 хувь, уул уурхайн салбарын 2.9 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарын 2.9 хувь, боловсруулах салбарын 2.3 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбарын 0.7 хувь нь тус тус чанаргүй зээлд ангилагджээ. Хэдийгээр зээлийн чанар сайн байгаа ч, эдийн засгийн нөхцөл байдал хүндрэхэд тэр нь банкуудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, улмаар зээл чанаргүй болох үзэгдэл бий болох, банкны өөрийн хөрөнгөд сөрөг нөлөөлж болзошгүй юм. Тодруулбал Монголбанк онцгой нөхцөл байдлын шинжилгээ хийдэг бөгөөд тус шинжилгээнээс үзвэл хэвийн зээлийн 5 хувь нь чанаргүй болоход банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг 4.2 нэгжээр бууруулах сөрөг нөлөөтэй гэсэн үр дүн гарч байна.

Банкуудын татан төвлөрүүлсэн харилцахын үлдэгдэл 2.3 их наяд төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оноос 1.3 хувиар буюу 30.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Өнгөрсөн онд хөрөнгийн дотогшлох урсгал өндөр байсантай холбоотойгоор банкуудын харилцахын хэлбэлзэл өндөр байсан бол 2012 онд уг үзүүлэлт харьцангуй тогтвортой байлаа. Хувийн секторын харилцахын үлдэгдэл 9.9 хувиар буюу 123.4 тэрбум төгрөгөөр буурч, 1.1 их наяд төгрөгт хүрсэн бол иргэдийн харилцахын үлдэгдэл 464.8 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 27.5 хувиар буюу 100.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Банкны салбарын үндсэн эх үүсвэр болох хадгаламжийн үлдэгдэл тайлант оны эцсийн байдлаар 5.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 15.5 хувиар буюу 683.3 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ. Хувийн салбараас татсан хугацаатай хадгаламжийн хэмжээ 524.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 120.8 тэрбум төгрөгөөр буюу 29.9 хувиар нэмэгдсэн бол хувийн салбарын хугацаагүй хадгаламжийн хэмжээ харьцангуй тогтвортой байсан бөгөөд өнгөрсөн оноос 8.4 хувиар буюу 1.8 тэрбум төгрөгөөр өсч, 23.8 тэрбум төгрөгт хүрэв. Нийт хадгаламжийн 74.9 хувийг бүрдүүлдэг иргэдээс татсан хадгаламжийн хэмжээ 16.1 хувиар буюу 527.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 3.8 их наяд төгрөгт хүрсэн байна.

Банк хоорондын захаас татсан эх үүсвэрийн хэмжээ 33.4 хувиар буюу 84.7 тэрбум төгрөгөөр өсч 338.4 тэрбум төгрөгт хүрлээ. Монголбанк, Засгийн газрын хамтран хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүдийн нөлөөгөөр төв банкнаас банкуудын авсан зээл өмнөх оноос 2.4 дахин буюу 154.2 тэрбум төгрөгөөр өсч, 218.8 тэрбум төгрөг боловс.

Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын өөрийн хөрөнгийн хэмжээ 1.3 их наяд төгрөгт хүрч,


өмнөх оноос 33.9 хувиар буюу 320.9 тэрбум төгрөгөөр, эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ 23.4 хувиар буюу 1.5 их наяд төгрөгөөр нэмэгдэж, 7.8 их наяд төгрөгт хүрээд байна. Банкуудын ашигт ажиллагаа өндөр байсан нь өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөллөө. Тайлант оны эцэст банкны салбар нийт 193.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өмнөх оноос 12 хувиар буюу 20.6 тэрбум төгрөгөөр өсчээ. Хэдийгээр ашгийн хэмжээ нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа ч, ашигт ажиллагааны харьцааны гол үзүүлэлтүүд буурсан нь хөрөнгийн өсөлтийн хурдац өндөртэй байсантай холбоотой байна. Активын өгөөжийн үзүүлэлт 2.3 хувьд хүрч, өмнөх оноос 0.6 нэгжээр, өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт 15.2 хувьд болж өмнөх оноос 3.4 нэгжээр тус тус буурчээ.

Зураг 13: Банкны салбарын нийт актив




Эх сурвалж: Монголбанк

Зураг 14: Банкны салбарын зээлийн үзүүлэлтүүд



Эх сурвалжсууд: Монголбанк

Зураг 15: Банкны салбарын харилцах, хадгаламж



### Зохицой харьцааны үзүүлэлтүүд

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохицой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр тургэн гүйцэтгэх чадвар, гадаад валютын эрсдэлийн үзүүлэлт, зээлийн төвлөрлийн эрсдэл, үндсэн хөрөнгийн зэрэг зохицой харьцаануудыг тооцоолдог.


- Өөрийн хөрөнгийн хүрэлцээ:** Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт банкны системийн хэмжээнд оны эцсийн байдлаар 15.4 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний

үзүүлэлт 11.6 хувьд хүрлээ. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 0.8 нэгжээр, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 0.6 нэгжээр тус тус буурчээ. Энэ нь Монголбанкнаас тогтоосон нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээс 3.4 хувиар, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээс 3.6 хувиар тус тус өндөр байна. Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтүүд өмнөх оноос буурсан байгаа нь өөрийн хөрөнгийн өсөлт эрсдэлээр жигнэсэн активын өсөлтөөс бага байсантай холбоотой юм. Монголбанкнаас банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж 16 тэрбум төгрөгт хүргэх шаардлагыг 2013 оны эхний хагас жилд хангах шаардлага тавьж байгаа бөгөөд ингэснээр банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг тэлэх зэрэгт нөлөөлөх юм.

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар:** Монголбанкны Ерөнхийлөгчийн 11 дүгээр сарын 25-ны өдрийн 691 дугаар тушаалаар банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг 2012 оны 1 дүгээр сараас эхлэн 25 хувьд хүргэх шаардлагыг тавьсан. Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 38.7 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 0.3 нэгжээр буурчээ. Банкуудын түргэн борлогдох активын хэмжээ тайлант оны эцсийн байдлаар 3.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны эцсээс 0.7 их наяд төгрөгөөр өссөн байна. Банкууд Засгийн газрын үнэт цаасанд оруулах хөрөнгө оруулалтаа ихэсгэх замаар төв банкин дахь нөөцөө нэмэгдүүлсэн нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт тогтвортой байхад нөлөөлжээ.
- Гадаад валютын зохистой харьцаа:** Банк нь гадаад валютын нээлттэй позици, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15 хувийн дотор, нийт валютын хувьд +/-40 хувийн дотор барьж байх шаардлагатай. Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт нэгж валютын хувьд -10.7 хувь, нийт валютын хувьд 17.3 хувьтай байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангаж байна.

Зураг 16: Өөрийн хөрөнгө

/тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Зураг 17: Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

/тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

### Шагтгээ 1: Мэдрэмтгий байдлын шинжилгээ (стресс тест)

Олон улсад төв банкууд мэдрэмтгий байдлын шинжилгээг микро болон макро түвшинд хийдэг. Уг шинжилгээний үндсэн зорилго нь эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэнэ. Макро мэдрэмтгий байдлын шинжилгээгээр эдийн засгийн тухайн нэг үзүүлэлт өөрчлөгдхөхөд санхүүгийн салбарын бусад үзүүлэлтүүдэд хэрхэн нөлөөлөхийг тооцдог бол микро түвшний шинжилгээгээр тухайн нэг санхүүгийн байгууллагын төлбөрийн чадвар, зохистой харьцааны үзүүлэлтүүдэд үүсч болзошгүй эрсдэл хэрхэн нөлөөлөхийг тооцдог. Мэдрэмтгий байдлын шинжилгээгээр дараах төрлийн эрсдэлийг жишигэ болгон тооцож харууллаа:


- Зээлийн эрсдэлийн мэдрэмтгий байдлын шинжилгээ
- Хөрвөх чадварын эрсдэлийн мэдрэмтгий байдлын шинжилгээ

Тухайн эрсдэлийн хувьд банкны салбарт нөлөөлж болох боломжит хувилбаруудыг (сценари) түүхэн хугацаанд үзүүлж байсан нөлөөлөл болон шууд таамаглал гэсэн үндсэн хоёр аргаар сонгон авна. Зээлийн болон зах зээлийн эрсдэлийн үнэлгээнд сонгосон сценариуд нь тухайн банк болон нийт банкны салбарын хэмжээний өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтэд үзүүлж буй нөлөөг тооцсон бол хөрвөх чадварын эрсдэлийн стресс тестээр нийт банкны салбар болон тухайн банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтэд үзүүлж буй нөлөөг тус тус тооцлоо.

Зураг 18: Зээлийн эрсдэлийн стресс тест



Зураг 19: Хөрвөх чадварын эрсдэлийн стресс тест



**Тайлбар:** Зээлийн эрсдэлийн хувьд сул, дунд болон хүчтэй сценариудыг сонгохдоо одоогийн ангилалд бүртгэлтэй байгаа зээлийн үлдэгдэл нь 10, 20 болон 30 хувиар нэг ангиллаар буурах (муу зээлийн ангилалд байгаа зээл ангилал шилжихгүй) тохиолдлуудыг сонголоо. Хөрвөх чадварын эрсдэлийн хувьд нийт эх үүсвэрийн 5, 10 болон 15 хувь нь системээс гадагшлах тохиолдолд банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаанд орох өөрчлөлтүүдийг харуулав.

Нийт зээлийн үлдэгдлийн 10 хувь нь одоо байгаа ангиллаас нэг шатлал буурахад сул сценариар банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 0.5 нэгж, дунд сценариар 0.9 нэгж, хүчтэй сценариар 1.4 нэгж хувиар тус тус буурахаар байна. Өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд нь дээрх сценариийн дараах байдлаар зөвшөөрөгдхөд доод хязгаараас 2.7-3.6 нэгж хувиар өндөр байна. Харин системийн нөлөө бүхий банкуудад тавигдаж буй өөрийн хөрөнгийн хүрэлцээний хамгийн бага шаардлагаас 1.7-2.6 нэгжээр илүү байна. Нийт эх үүсвэрийн 5, 10 болон 15 хувь гадагшлахад банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт 3.2-10.8 нэгж хувиар буурах төсөөлөл гарч байна. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны хамгийн бага шаардлагыг аль ч хувилбар нь бүрэн хангахаар байна.

### *Хөрөнгийн захын хөгжил*

Монголын Хөрөнгийн Бирж 2012 онд үнэт цаасны 250 удаагийн арилжаа явуулж, 149 компанийн 133.7 сая ширхэг хувьцааг 144.7 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын бондыг 5 удаад нийт 525 мянган төгрөгөөр, 30.9 мянган ширхэг компанийн бондыг 309.7 сая төгрөгөөр арилжиж, нийт 145.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийжээ. Хувьцааны арилжаа 35.6 тэрбум төгрөг буюу 32.6 хувиар нэмэгдсэн байна. Нийт зах зээлийн үнэлгээ 1800 тэрбум төгрөг байгаа нь ДНБ-ий 12.9 хувьтай тэнцэж байна. Таван толгой, АПУ, Шивээ овоо, Бэрх уул, Багануур, Шарын гол зэрэг компаниуд нь зах зээлийн үнэлгээ ёндөртэй компаниудад тооцогдож байна.

Хүснэгт 6: Арилжааны гүйлгээ /тербум төгрөг/

	Арилжааны үнийн дүн 2011	2012	Өөрчлөлт Үнийн дүнгээр	Хувиар
ЗГ-ын бонд	236.7	0.0005	-236.7	-100
Хувьцаа	109.1	144.7	35.6	32.6
Компанийн бонд	4.4	0.3	-4.1	-93.0

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТОП-20 үнийн индексийн үзүүлэлт оны эцэст 17714.51 болж, өмнөх оноос 18.3 хувиар буурсан байна. Багануур, Могойн гол, Шивээ овоо, УИД, Монголын цахилгаан холбоо, Шарын гол, Таван толгой зэрэг ХК-иудын үнэт цаасны үнэ буурсан нь ТОП-20 индекс ийнхүү буурахад нелөөлжээ. ТОП-20 үнийн индескийн 2012 оны дундаж 19071.87 байв.

Зураг 20: ТОП 20 индекс, 2012 онд



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Засгийн газрын бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 1 жилийн хугацаатай, жилийн 7.5 хувийн хүүтэй, 100 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5 ширхэг бондыг 525 мянган төгрөгөөр арилжжээ.

Компанийн бондын анхдагч зах зээлийн арилжаагаар “Жаст агро” компанийн 10 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй 500 ширхэг “Монгол мах” бондыг 5 сая төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 30.5 мянган ширхэг бондыг 304.7 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 309.7 сая төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

*Тайлант хугацаанд 150 компанийн үнэт цаас арилжсигдсанаас 102 компанийн үнэт цаасны үнэ өсч, 45 компанийн үнэт цаасны үнэ буурч, 3 компанийн үнэт цаасны үнэ тогтмол байв. Хувьцааны арилжааны өдрийн дундаж нь хувьцааны тоо ширхэгээр 535.2 мянга, үнийн дүнгээр 579 сая төгрөг байлаа.*

Хүснэгт 7: Идэвхтэй арилжигдсан үнэт цаас (тоо ширхэгээр)

Д/д	Үнэт цаасны компани	Тоо ширхэг сая ширхэг/
1	Женко тур бюро	30.6
2	Хөх ган	19.5
3	Э-транс ложистикс	11.8
4	Бэрх уул	10.8
5	Нако түлш	8.9
6	Ремикон	7.8

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Хүснэгт 8: Идэвхтэй арилжигдсан үнэт цаас (үнийн дүнгээр)

Д/д	Үнэт цаасны компани	Үнийн дүн /тэрбум төгрөг/
1	Шарын гол	54.3
2	Бэрх уул	26.9
3	Шивээ овоо	9.7
4	Багануур	9.2
5	БиДиСек	8.1

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

#### 1.4 Улсын төсөв

##### Засгийн газрын санхүү

Монгол Улсын нийт тэнцвэржүүлсэн төсвийн орлого, тусламжийн дүн 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4968.2 тэрбум төгрөг (ДНБ-ий 35.6 хувь), нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 6043.9 тэрбум төгрөг (ДНБ-ий 43.3 хувь) болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1163.0 тэрбум төгрөгийн алдагдалтай, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 250.3 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

##### Төсвийн орлого

Нийт орлого, тусламжийн дүн 4968.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 13.1 хувь буюу 745.8 тэрбум төгрөгөөр бага, өмнөх оноос 11.2 хувь буюу 500 тэрбум төгрөгөөр их байна. Төсвийн нийт орлого ба тусламжийн 97.4 хувийг бүрдүүлсэн урсгал орлого өмнөх оны мөн үеэс 14.9 хувь буюу 627.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нийт орлого ба тусламжийн дүн өмнөх оноос өсөхөд нөлөөлжээ.

Урсгал орлогын 86.8 хувийг бүрдүүлсэн татварын орлого өмнөх оны мөн үеэс 14.5 хувь буюу 533.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 4201.7 тэрбум төгрөгт хүрсэн нь дотоодын бараа, үйлчилгээний татвар 13.9 хувь буюу 198.8 тэрбум төгрөг, орлогын албан татвар 4.3 хувь буюу 36.2 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн орлого 45 хувь буюу 212.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Харин гадаад худалдааны орлого 3 хувь буюу 10 тэрбум төгрөгөөр багассан нь импортын барааны гаалийн албан татвар буурснаас шалтгаалжээ. Татварын бус орлого (урсгал орлогын 13.2%) өмнөх оны мөн үеэс 17.2 хувь буюу 93.7 тэрбум төгрөгөөр өсч, 639.1 тэрбум төгрөгт хүрсэн нь хувьцааны ногдол ашиг (татварын бус орлогын 25.5%) 66.8 тэрбум төгрөг, газрын тосны орлого (татварын бус орлогын 16.8%) 42.8 хувь буюу 32.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Хүснэгт 9: 2012 оны улсын нэгдсэн төсвийн орлого /тэрбум төгрөгөөр/**

Төсвийн орлого	2011 оны гүйцэтгэл	2012 оны урьдчилсан гүйцэтгэл		Жилийн өөрчлөлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
<b>Нийт орлого ба тусlamжийн дүн</b>	4,468.2	5,714.0	4,968.3	11.2
<b>Тогтвортжуулалтын сан</b>	241.0	101.4	87.4	(63.7)
<b>Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусlamжийн дүн</b>	4,227.2	5,612.7	4,880.9	15.5
<b>Ургал орлого</b>	4,213.7	5,596.8	4,840.8	14.9
<b>Татварын орлого</b>	3,668.3	4,979.1	4,201.7	14.5
Орлогын албан татвар	833.7	987.0	870.0	4.3
Нийгмийн даатгалын шимтгэл хураамж	473.4	567.8	686.3	45.0
Өмчийн татвар	17.2	19.2	21.6	26.2
Дотоод бараа, үйлчилгээний татвар	1,434.7	2,142.6	1,633.6	13.9
Гадаад худалдааны орлого	337.4	566.0	327.4	(3.0)
Бусад татвар	571.9	696.5	662.9	15.9
<b>Татварын бус орлого</b>	<b>545.4</b>	<b>617.7</b>	<b>639.1</b>	<b>17.2</b>
<b>Хөрөнгийн орлого</b>	<b>12.0</b>	<b>14.8</b>	<b>15.4</b>	<b>28.7</b>
<b>Тусlamжийн орлого</b>	<b>1.5</b>	<b>1.0</b>	<b>24.7</b>	<b>16.0*</b>

\* дахин

Эх сурвалж: Сангийн яам

**Төсвийн зарлага**

2012 онд төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн төлөвлөсөн хэмжээнээс 429.8 тэрбум төгрөг буюу 6.6 хувиар бага, өмнөх оныхоос 1046.9 тэрбум төгрөг буюу 20.9 хувиар өсч 6043.9 тэрбум төгрөгт хүрчээ. Ургал зардал (нийт зарлага ба цэвэр зээлийн 75.9 хувь) жилийн хугацаанд 1353.7 тэрбум төгрөг буюу 41.8 хувь, хөрөнгийн зардал (нийт зарлага ба цэвэр зээлийн 22.9 хувь) 103.5 тэрбум төгрөг буюу 8.1 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл (нийт зарлага ба цэвэр зээлийн 1.2 хувь) 410.3 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

**Хүснэгт 10: 2012 оны улсын төсвийн зарлага /тэрбум төгрөгөөр/**

Төсвийн зарлага	2011 оны гүйцэтгэл	2012 оны урьдчилсан гүйцэтгэл		Жилийн өөрчлөлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
<b>Нийт зарлага ба цэвэр зээл</b>	<b>4,997.0</b>	<b>6,473.7</b>	<b>6,043.9</b>	<b>20.9</b>
<b>Ургал зардал</b>	<b>3,236.4</b>	<b>4,675.9</b>	<b>4,590.1</b>	<b>41.8</b>
Бараа ба үйлчилгээний зардал	1,504.5	2,195.6	2,209.7	46.9
Зээлийн үйлчилгээний төлбөр	37.3	151.6	126.4	238.7
Татаас ба ургал шилжүүлэг	1,694.6	2,328.7	2,254.0	33.0
<b>Хөрөнгийн зардал</b>	<b>1,280.9</b>	<b>1,812.6</b>	<b>1,384.4</b>	<b>8.1</b>
Эргэж төлөгдөх цэвэр зээл	479.7	-14.8	69.4	(85.5)
Тэнцвэржүүлсэн ургал тэнцэл	977.3	921.0	250.6	(74.4)
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-769.9	-861.0	-1,163.0	

Эх сурвалж: Сангийн яам

Ургал зардлыг бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь авч үзвэл, бараа ба үйлчилгээний зардал (ургала зардлын 48.1 хувь) өмнөх оны мөн үеэс 705.2 тэрбум төгрөг буюу 46.9 хувь, татаас ба шилжүүлэг (49.1 хувь) 559.4 тэрбум төгрөг буюу 33 хувь, зээлийн үйлчилгээний төлбөр (2.8 хувь) 89.1 тэрбум төгрөг буюу 3.4 дахин нэмэгджээ. Мөн цалин, хөлс (бараа үйлчилгээний зардлын 56.5 хувь) 705.2 тэрбум төгрөг буюу 46.9 хувиар нэмэгдсэн байна.

Ургал зардлын 49.1 хувийг бүрдүүлсэн татаас ба шилжүүлгийн өсөлтөд бусад ургал шилжүүлгийн

зардал 463.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ. Бусад урсгал шилжүүлэгт нийгмийн даатгалын зардал 311.5 тэрбум төгрөг, халамжийн сангийн зардал 50.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хөрөнгийн зардал (нийт зарлага, цэвэр зээлийн 22.9 хувь) 8.1 хувь буюу 103.5 тэрбум төгрөгөөр өсч, 1280 тэрбум төгрөгт хүрсэн нь хөрөнгө оруулалт 103.1 тэрбум төгрөг, улсын нөөц бүрдүүлэх зардал 10.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### **Шигтгээ 2: Орон нутаг дахь банкны салбарын гол үзүүлэлтүүд**

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын нийт актив 2012 оны эцэст 1711.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 16.3% буюу 239.5 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Зээлийн үлдэгдэл нийт активын 98.1%-ийг бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оноос 16.3% буюу 239.5 тэрбум төгрөгөөр өсч, 1540.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Банк тус бүрээр авч үзвэл, нийт зээлийн 49.1% нь ХААН банк, 19.6% нь Хадгаламж банк, 13.8% нь Хас банк, 7.4% нь Худалдаа хөгжлийн банк, 5.8% нь Голомт, 4.4% нь бусад банкуудын зээл байна. Харин аймгуудаар авч үзвэл Орхон аймагт нийт зээлийн 9.2%, Дархан-Уул аймагт 9%, Сэлэнгэ аймагт 7.5%, Дорноговь аймагт 6.7%, Өмнөговь аймагт 6.2%, Хөвсгөл аймагт 5.5%, бусад аймгуудад 56.1% нь тус тус ногдож байна.

Зураг 21. Нийт актив



Зураг 22. Нийт зээлийн өрийн үлдэгдэл




Эх сурвалжсууд: Монголбанк

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нь авч үзвэл, 18.2%-ийг худалдаа, засвар үйлчилгээ, 5%-ийг ХАА, 4.8%-ийг үл хөдлөх хөрөнгө, 4%-ийг барилга, 2.7%-ийг боловсруулах үйлдвэрлэл, 58.2%-ийг бусад салбарт олгосон зээл бүрдүүлж байна. Орон нутаг дахь банкуудын зээлийн өрийн үлдэгдлийн 98.1% нь хэвийн зээл, 1.4% нь хугацаа хэтэрсэн зээл, 0.6% нь чанаргүй зээл байна. Орон нутаг дахь банкуудын нийт пассив 1589.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 17.2% буюу 233.4 тэрбум төгрөгөөр өсчээ. Нийт хадгаламжийн үлдэгдэл оны эцсээр 786.3 тэрбум төгрөг, нийт харилцах дансны үлдэгдэл 297 тэрбум төгрөг байна.

Орон нутаг дахь банкуудын харилцахын үлдэгдэл болон хадгаламж банкны салбарын нийт харилцах болон хадгаламжийн 14.5%, 16%-ийг тус тус эзэлж байна. Харилцахын 88.4 хувь нь төгрөгийн, 11.6 хувь нь валютынх, хадгаламжийн 69.4% хугацаатай, 30.6% нь хугацаагүй хадгаламж бөгөөд хугацаатай хадгаламжийн 96% нь төгрөгийнх, 4% нь валютынх байна.

Зураг 23. Нийт зээлийн ангилал



Эх сурвалж: Монголбанк

Зураг 24. Нийт харилцах



Эх сурвалж: Монголбанк

Зураг 25. Нийт хадгаламж



Эх сурвалж: Монголбанк

## 2.1 Мөнгөний бодлогын үндсэн зорилт, арга хэмжээ, үр дүн

Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдсэн, бус нутгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын орчин эрс муудсан, Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан, дотоодын хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчинд сөрөг өөрчлөлт гарсан, улс төрийн сонгуультай уялдан хүлээлт бий болсон зэргээр эдийн засаг, санхүүгийн зах зээлийн гадаад, дотоод орчин бүхэлдээ тодорхой бус, эгзэгтэй, эрсдэлтэй бөгөөд хэлбэлзэл өндөртэй байсан орчин нөхцөлд Монголбанк төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүллээ.

Монголбанкны үндсэн зорилт нь дотоодын инфляциар хэмжигдэх төгрөгийн тогтвортой байдал буюу төгрөгөөр илэрхийлэгдсэн үнийн тогтвортой байдлыг хангах юм. Инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгаж, санхүүгийн зуучлалыг идэвхижүүлэн, санхүүгийн тогтвортой байдлыг хангаснаар бодит секторын худалдан авах чадвар буурахгүй байх, эдийн засгийн тогтвортой өсөлт хадгалагдах, дундаж давхаргын хуримтлал нэмэгдэх, зээлийн хүү буурах зэрэг нөхцөлийг бүрдүүлнэ.

2012 оны эхний хагаст Улаанбаатар хотын жилийн инфляцийн түвшин огцом өсч, 4 дүгээр сард 17.8 хувьд хүрсэн нь 2009 оны 1 дүгээр улирлаас хойш ажиглагдаагүй өндөр түвшин байлаа. Харин 6 дугаар сард үнийн өсөлт бага зэрэг саарч 15.1 хувьд хүрсэн. Энэхүү инфляцийн дийлэнх хувийг мах, махан бүтээгдэхүүний үнэ (7.4%), төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ (0.9%), орон сууцны бодит түрээсийн үнэ (0.8%) тус тус бүрдүүлжээ. Түүнчлэн УИХ-н сонгуулийн өмнө төрийн албан хаагчдын цалинг 80,000 төгрөг, 23 хувиар тус тус нэмэгдүүлсэн, Хүний хөгжил сангаас өндөр насттан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 660,000 төгрөгийг олгосон нь эрэлтийн шалтгаантай инфляцийг нэмэгдүүлэв.

Тайлант оны сүүлийн хагаст инфляцийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байсан мах, махан бүтээгдэхүүний үнэ тогтвожиж, инфляцийн түвшин аажмаар буурсаар оны эцэст 14.2 хувь гарсан нь инфляцийн зорилтот түвшнээс<sup>1</sup> 4.2 нэгж хувиар өндөр байв. Инфляци ийнхүү зорилтот түвшнээс хэтрэхэд мөнгөний бодлогоор зохицуулах боломжгүй хүчин зүйлсийн нөлөө, үүний дотор нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөлүүд, мах, согтууруулах ундаа, тамхи, төреөс үнийг нь зохицуулдаг бараа, үйлчилгээний үнэ өссөн зэрэг нь голлон нөлөөлсөн юм.

Тайлант онд Монголбанк үнийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэхэд шаардлагатай бодлогын арга хэмжээг авч ажиллалаа.

Монголбанк төсвийн урсгал зардлын тэлэлт, Хүний хөгжил сангаас олгосон бэлэн мөнгөний нийлүүлэлтээр өдөөгдсөн эрэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгаж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор 2012 оны эхний хагаст мөнгөний бодлогыг чангаруулж, бодлогын хүүг 0.5 нэгж хувиар 2 удаа өсгөн 13.25 хувьд хүргэж, арилжааны банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 1 нэгж хувиар нэмэгдүүлэн 12 хувьд хүргэсэн болно. Ингэснээр эрэлтийн гаралтай инфляцийн дарамтыг бууруулж, хязгаарлалаа.

Оны сүүлийн хагаст Монголбанк нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийг бууруулах, иргэдийн хэрэглээний суурь бараа, бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн зах зээлийн зарчимд суурилсан, байнгын тогтолцоог бий болгох зорилгоор Засгийн газартай хамтран “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвожуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг УИХ-ын 57 дугаар тогтоол, Төреөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд баталж, амжилттай хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрт 2012 онд “Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтвожуулах”, “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвожуулах”, “Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний өргтгийг бууруулах”, “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтвожуулах” гэсэн дөрвөн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэллээ. Хөтөлбөрийн хүрээнд зөвхөн 2012 онд нийт 194 тэрбум төгрөгийн зээлийг оролцогч банкуудаар дамжуулан Засгийн газартай гэрээ байгуулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээдүүдэд олгосон байна.

<sup>1</sup> Төреөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэл

Ийнхүү 2012 онд Монголбанкнаас эрэлтийн болон нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийг бууруулах бодлогын арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлсэнээр 2012 оны 11-12 дугаар саруудад инфляци улсын хэмжээнд 1.0%, Улаанбаатар хотод 0.5% болж, 2011 оны мөн үеэс харгалзан 2.3 нэгж хувь, 1.5 нэгж хувиар тус тус буурсан юм. Улмаар инфляцийн дарамт цаашид буурах, төсөөлөл нь 2013 оны зорилтолт түвшинтэй нийцтэй байх боломж бүрдэв.

Монгол Улсын Засгийн газраас олон улсын зах зээлд анх удаа 1.5 тэрбум ам.долларын үнэт цаасыг 2012 оны 12 дугаар сард амжилттай арилжаалж, гадаад валютын улсын нөөцийг нэмргүүлсэн нь 2013 онд гадаад орчны сөрөг өөрчлөлтийн дотоодын эдийн засаг дахь нөлөөллийг бууруулах, мөчлөг сөрсөн макро бодлого хэрэгжүүлэх замаар эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг зөөлрүүлэн нийт эдийн засгийг тогтвортжуулах, мах, гурил, шатахуун зэрэг иргэдийн суурь хэрэглээний үнийн өсөлтийг сааруулах болон ДНБ-ий бодит өсөлтийг тогтвортжуулахад чиглэсэн мөнгөний бодлого хэрэгжүүлэх гол нөхцөлийг бүрдүүлж өглеө.

#### **Шигтгээ 4: “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийн танилцуулга**

Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд 4 дэд хөтөлбөрийг холбогдох байгууллагуудтай хамтран баталж хэрэгжүүлж байна. Энэ нь Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тасалдлыг арилгах, улмаар нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгах, бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн зах зээлийн зарчимд суурилсан, байнгын тогтолцоог дунд хугацаанд бүрдүүлэх зорилготой юм. Тус хөтөлбөрүүд нь 2 үе шаттайгаар хэрэгжинэ. Үүнд:

- Эхний шат:** Харьяа яамдтай дэд хөтөлбөрийг батлах, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийг тухайн яамд сонгон шалгаруулах, Монголбанк оролцогч банкуудтай гэрээ байгуулж, санхүүгийн эх үүсвэрийг банкуудад олgon зээлийн шугамыг нээх,
- Хоёрдугаар шат:** Оролцогч банкууд хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн эрсдэлийг бие даан, хараат бусаар үнэлж, зээл олгох боломжтой гэж үзсэн нөхцөлд зээлийг олгох.

#### **1. Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортжуулах (SIFS) дэд хөтөлбөр**

Монголбанкнаас жижиглэнгийн нефтийн бүтээгдэхүүнийг хамгийн бага зардлаар санхүүжүүлэхийн зэрэгцээ хил дээрх өргтийн ханшаас хамаарах нөлөөллийг бууруулж, жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүлэхээр “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортжуулах (SIFS) дэд хөтөлбөр”-ийг Уул уурхайн яамтай хамтран 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна.

Тус хөтөлбөрийн зорилго нь жижиглэнгийн газрын тосны бүтээгдэхүүний импортыг Монголбанкнаас тогтоосон хүүгээр санхүүжүүлэх, валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах нөлөөллийг бууруулах замаар шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгахад орших бөгөөд дараах үр дүнд хүрэхээр төлөвлөж байна.

1. Шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ тогтвортой болно.
  - Санхүүжилтийн зардал буурна,
  - Ханшийн эрсдэлийг бууруулна.

## 2. Бусад үр дүн

- Шатахууны импортын татварыг хилийн үнэтэй уялдуулан тогтоодог болно.
- Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг хадгалах савыг барьсан байна.
- Газрын тосны бүтээгдэхүүний нөөц нэмэгдсэн байна.
- Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн эх үүсвэр төрөлжино.

### *Хүснэгт 11: Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ*

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ
Шатахууны биет нөөцийг хадгалах савыг барих ажлыг эхлүүлнэ.	Шатахууны биет нөөц бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгох, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх
Шатахууны биет нөөцийг нэмэгдүүлнэ.	Хувийн хэвшлийн компаниудын шатахууны нөөцийг бүрдүүлэх
Шатахууны нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	ОХУ-аас бусад улсаас, тухайлбал БНСҮ, БНХАУ-аас авч буй шатахууны импортод учирч буй саад бэрхшээлийг судалж, холбогдох газраар шийдвэрлүүлэх, импортын эх үүсвэрийн хувьд нэг улсаас хэт хараат байдлыг багасгах
Татварын зохицуулалтыг сэргээнэ.	Шатахууны импортын татварыг хилийн үнийн бууралттай уялдуулан сэргээж, татварын зохицуулалтын орон зайнг нэмэгдүүлэх

Эх сурвалж: Монголбанк

### *Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал*

Дэд хөтөлбөрийн үр дүн, зорилтот ажлуудын биелэлтийг 3 сар тутам дүгнэхээр заасан бөгөөд 2013 оны 1 сарын 26-ны өдрийн байдлаар дүгнэвэл дараах байдалтай байна.

- Дэд хөтөлбөрийн хүрээнд нийт 93.7 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 3.8% хүйтэйгээр хэрэгжүүлэгч компаниудад олгож, 82.5 сая ам.долларын форвард хэлцлийг хамгийн бага зардлаар гүйцэтгэснээр валютын ханшийн эрсдэлийг бууруулсан.
- Засгийн газрын 126 дугаар тогтоолын үр дүнд компаниудын газрын тосны бүтээгдэхүүний нөөц 2012 оны эцсийн байдлаар хөтөлбөрийг эхлүүлсэн 2012.10.23-ны өдөртэй харьцуулахад 2 дахин нэмэгдэж, нийлүүлэлтийн тасралтгүй байдал хангагдсан.
- Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор импортолсон автобензин, дизелийн түлшинд татвар ногдуулах эрхзүйн орчинг бүрдүүлсэн.
- “Аж ахуйн үйл ажиллагааны тусламжийн тухай хууль” болон “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж, жижиглэнгийн худалдааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн.
- Шатахуун борлуулагч аж ахуйн нэгжүүд болон төрийн байгуулага хоорондын ажлын уялдаа сайжирсан.
- Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх ажлын хүрээнд гадаад худалдан авалтыг эрчимжүүлснээр гадаадын хэд хэдэн компаниудтай хөнгөлөлттэй нөхцөл бүхий гэрээ байгуулж, нийтдээ 20 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон.
- Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан олон нийтийн зүгээс шатахууны үнэ, нөөц, боловсруулах үйлдвэр зэрэг асуудалд тавих хяналт эрс сайжирсан.

Хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хаягаар орж үзнэ үү.

<http://www.mongolbank.mn/pricestability.aspx#>

## **2. Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах (TLF) дэд хөтөлбөр**

Тээвэр, логистикийн хүчин чадал, үр ашиг нь аливаа эдийн засгийн бүхий л харилцааны суурь нөхцөлүүдийн нэг бөгөөд бараа, үйлчилгээний үнэ, өртөг, өрсөлдөх чадварт шууд нөлөө үзүүлдэг.

Тухайлбал, манай улсын төмөр замын тээвэрлэлт хязгаарлагдмал хүчин чадалтай байдаг, хилийн боомт дээр ачаа бараа тээвэрлэгдэхгүй гашдагаас шалтгаалан дотоодод бараа бүтээгдэхүүний хомдол үүсэх, бизнесийн эрсдэл, зардал өсөх, улмаар үнийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх хандлага өнгөрсөн жилүүдэд ажиглагдаар ирсэн.

Тиймээс Монголбанк, Зам, тээврийн яамтай хамтран 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдөр “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөр”-ийг баталж, хэрэгжүүлж эхлээд байна. Тус дэд хөтөлбөрийн үндсэн зорилго нь гадаад худалдааны тээвэр логистикийн дэд бүтцийг сайжруулах замаар өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн жигд тасралтгүй байдлыг хангах, үнийн өсөлтийг хязгаарлахад орших бөгөөд дунд хугацаанд дараах үр дүнд хүрэхээр тусгасан.

#### *Хүснэгт 12: TLF дэд хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, үр дүн*

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүн	Зээлийн шугамын дүн
1.	Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний ачаа эргэлтийг нэмэгдүүлж, хурдаасана (Замын Үүд-УБ чиглэл)	Тусгай зориулалтын 2 галт төргийг хатуу зурмагаар аялуулах.	Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтэд зориулан өдөрт 100-с доошигүй вагоноор хангаж, 9000 тонн ачааг Замын Үүд-УБ хооронд 24 цагийн дотор тээвэрлэх.	-
		Сэлгээний ажил болон ачаа ачиж, буулгах үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулан хурдаасах.	Aчааллыг зохицуулсан тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх.	-
		Шинэ жисл, цагаан сарын баяр зэрэг улирлын чанартай ачааллыг бууруулахад чиглэсэн тусгайлсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Aчааллыг зохицуулсан тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх.	-
2.	Ачаа тээвэрлэлтийн өртгийг бууруулана.	Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн өртгийг бууруулах.	Aчаа тээвэрлэлтийн өртөг буурсан байх.	-
		Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн шатахууны эргэлтийн хөрөнгөд зориулан зээлийн шугам нээх.	Шатахууны зардал 17% хүртэл буурах.	22 хүртэл тэрбум төгрөг
		Тарифын бус зардлыг бууруулахад чиглэсэн зохион байгуулалт, хяналтыг сайжруулах.	Холбогдох байгууллагуудтай хамтран арга хэмжээг авсан байх.	-
3.	Тянъжин-Замын-Үүд чиглэлийн ачаа тээвэрлэлтийг хөнгөвчлилнэ.	Тянъжин боомтын шилжүүлэн ачилт болон бусад үйл ажиллагааг хурдаасах.	Зам, тээврийн яамнаас холбогдох арга хэмжээг авсан байх.	-
		Ачаа тээвэрлэлтийн хугацааг багасгах.		
4.	Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлнэ.	Төмөр замын салбарын ачааны вагон паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.	1000 вагоноор нэмэгдсэн байх.	136 хүртэл тэрбум төгрөг
		Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн зүтгүүрийн паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.	20 зүтгүүрээр нэмэгдсэн байх.	95 хүртэл тэрбум төгрөг
5.	Ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	• Замын-Үүд боомтын төмөр зам, авто замын ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэх;	• ТЭЗҮ-г боловсруулж, батлуулсан байх.	-
		• Улаанбаатар хот дахь ачааны терминалын ачаа боловсруулах чадварыг нэмэгдүүлэх.	• Улаанбаатар, Замын-Үүдийн төмөр зам, авто замын ачаа тээврийн нэгдсэн терминалыг батлаадсан ТЭЗҮ-ийн дэдүүрээр орлогтгосон байх;	50 хүртэл тэрбум төгрөг

Эх сурвалж: Монголбанк

### *Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал*

TLF дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар дүгнэвэл дараах байдалтай байна:

1. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний ачаа эргэлтийг нэмэгдүүлж хурдасгах зорилт бүрэн хэрэгжиж байна:

- Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтийг тогтсон хуваарийн дагуу тусгайлсан галт тэргээр гүйцэтгэж, ачаа эргэлтийг хурдасгалаа. Энэ үйлчилгээг 2012.10.29-ний 09:00 цагаас эхлүүлж, 2013.01.31-ний өдрийн байдлаар нийтдээ 189 галт тэрэг, 10,554 вагоноор нийт 611,444 тонн ачааг тээвэрлээд байна.
- Импортын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлэх төмөр замын үйлчилгээг сайжруулж хэвшиүүллээ. Энэ хүрээнд авто зам, төмөр замаар орж ирсэн ачааг сааталгүй сэлгэн ачих, ачилтын бригадын зохион байгуулалтыг сайжруулах, хэрэглэгчдэд зөвлөгөө өгөх, УБ хотод ирсэн ачааг гар утасны мессежээр хэрэглэгчдэд мэдэгдэх, “хаалганаас хаалганд” ачаа хүргэх үйлчилгээг нэвтрүүлэх, ачаалтай өдруүдэд нэмэлт галт тэргийг аялуулах зэрэг ажлыг зохион байгуулаа.

2. Төмөр замын тээвэрлэлтийн өргтийг бууруулах зорилтын хүрээнд төмөр замын хэрэгцээнд зориулан шатахуун импортлох, уг зардлыг санхүүжүүлэх зорилгоор дотоодын банкаар дамжуулан 22 тэрбум төгрөгийн зээлийг Монголбанкнаас авах асуудлыг нийгмэлэгийн ерөнхий хорооны 2013.01.29-ний өдрийн хурлаар шийдвэрлүүлж, шатахууны импортын худалдааны гэрээг ОХУ-ын Роснеть компанийтай байгуулах ажлыг хийж байна.

3. Тяньжин-Замын Ууд чиглэлийн тээврийг хөнгөвчлөх, төмөр замын салбарын хөдлөх бүрэлдэхүүний парк болон ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг үлдсэн 3 зорилт хуваарийн дагуу хэрэгжилтийн эхний шатандaa байна.

Хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хаягаар орж үзнэ үү.

<http://www.mongolbank.mn/pricestability.aspx#>

### **3. “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах” дэд хөтөлбөр**

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Монголбанк хамтран хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг сааруулж тогтвортой байлгах, агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэх, бараа бүтээгдэхүүний хангамжийн зах зээлд суурилсан байнгын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор тус дэд хөтөлбөрийг 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Дэд хөтөлбөрийн бүрэлдэхүүнд дараах хөтөлбөрүүд багтана. Үүнд:

1) Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтвортжуулах хөтөлбөр:

Махны нөөцийн менежерт эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл олгож, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах замаар махны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортжуулах нөхцөлийг тогтмол хангах зорилгоор тус хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна. Эхний шатанд ҮХААЯА-наас Улаанбаатар хотод (Жаст-Агро групп) 14 мянган тонн, Дархан (Баатарууд тэнгэр ХХК), Эрдэнэт (Эрдмийт ХХК) хотуудад тус бүр 1 мянган тонн махыг хүлээн авч, хадгалах, жижиглэн савлах, худалдан борлуулах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий “Нөөцийн махны менежер”-ийг сонгон шалгаруулах ажлыг нээлттэй зохион байгуулав. Шалгарсан нөөцийн менежерт Монголбанкнаас батлагдсан хөтөлбөрийн дагуу 87 тэрбум төгрөгийн зээлийг оролцогч банкууд зээлийн гэрээ байгуулан бүрэн олгоод байна. Харин хоёр дахь шатанд оролцогч банкууд хэрэгжүүлэгч компаниудын зээлийн судалгааг хийж, гэрээ байгуулах ажлуудыг тус тус гүйцэтгэснээр зээлийн шугамыг ашиглах нөхцөлийг бүрэн бүрдүүллээ. 2012 оны сүүлийн байдлаар нийт олгохоор төсөвлөсөн зээлийг банкууд бүрэн олгож дууссан байна.

2)“Гурилын үнийг тогтвржуулах” хөтөлбөр:

Гурилын үйлдвэрүүдэд шинэ ургацын хүнсний буудай худалдан авахад нь зориулж хөнгөлөлттэй зээл олгох замаар гурилын жижиглэнгийн худалдааны үнийг тогтвржуулах нөхцөлийг хангах зорилгоор тус дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Тус хөтөлбөрийн хувьд “Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтвржуулах хөтөлбөр”-тэй ижил зарчмаар хэрэгжиж байгаа бөгөөд УХААЯ-наас сонгон шалгаруулсан гурилын 35 үйлдвэрүүдэд Монголбанкнаас батлагдсан хөтөлбөрийн дагуу 61 хүртэл тэрбум төгрөгийн санхүүжилтийг оролцогч банкууд олгож эхлээд байна. 2012 оны сүүлийн байдлаар нийт төсөвлөсөн санхүүжилтийн 39.3 хувийг банкууд олгожээ.

3)“Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр

Хүнсний зориулалттай зоорь, агуулах барих сонирхолтой хувийн хэвшилд хөнгөлөлттэй зээл олгох замаар стандартын шаардлага хангасан олон тооны зоорь, агуулах барих нөхцөлийг бүрдүүлэх зорилготой тус хөтөлбөрийн хүрээнд УХААЯ-наас Улаанбаатар хот орчимд хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулах, төрөлжсөн бөөний болон жижиглэн худалдааны төв, мах, махсүүний чиглэлийн үхрийн, махны чиглэлийн хонь, гахай, тахианы цогцолбор аж ахуйг шинээр байгуулах, өргөжүүлэх төслүүдийг сонгон шалгаруулах баримт бичгийг боловсруулж байна.

**4. “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтвржуулах” дэд хөтөлбөр**

Орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн уялдааг хангах замаар орон сууцны үнэ болон орон сууцны түрээсийн үнийг тогтвржуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчин дахь орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх, барилгын материалын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах замаар үнийг тогтвржуулах нөхцөлийг бүрдүүлэх, ипотекийн хоёрдогч захыг санхүүгийн эх үүсвэрээр хангаж, орон сууцны эрэлтийг дэмжих замаар Орон сууцны ипотекийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох зорилготой энэхүү дэд хөтөлбөрийг БХБЯ-тай хамтран боловсруулж байна. Дэд хөтөлбөрийг 2013 оны 1 дүгээр сард баталж хэрэгжүүлэхээр төлөвлөв.

## 2.2 Санхүүгийн тогтвортой байдал

### Банкны салбарын хөгжил

#### Банкны салбарын өнөөгийн байдал, хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ

Санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, банкны салбарын эрсдэл даах чадварыг дээшлүүлэх үндсэн зорилтын хүрээнд банкуудын төлбөрийн чадварыг сайжруулах арга хэмжээг Монголбанкнаас тайлант онд тогтмол авч хэрэгжүүлсээр ирлээ. Тухайлбал, банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод шаардлагыг олон улсын жишгийн дагуу 2011-2013 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд хагас жилийн давтамжтайгаар тогтмол нэмэгдүүлэхээр тогтоосон нь банкуудын үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөлгүйгээр эрсдэл даах чадвараа нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой арга хэмжээ боллоо. Банкны системд нөлөө бүхий буюу банкны нийт актив хөрөнгийн 5-аас дээш хувийг эзэлж буй банкийг 2012 оноос эхлэн системийн нөлөө бүхий банкаар тодорхойлон, өөрийн хөрөнгийн зохистой харьцааны нэмэлт шаардлагыг хагас жилийн давтамжтайгаар бусад банкуудаас ялгаатайгаар тогтоож, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тодруулбал 2012 оны 6 дугаар сарын эцэст системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг 0.5 хувиар нэмэгдүүлж, тайлант оны эцэст 13 хувьд хүргэж өсгөсөн бол 2013 оны эхний хагас жилд багтаан уг харьцааг 14 хувьд хүргэнэ. Энэ нь Базелийн хорооноос тавьдаг хамгийн бага шаардлагаас даруй 6 нэгжээр өндөр юм.

Төв банкнаас банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2013 оны 5 дугаар сард багтаан 16 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэхээр тогтоосноос 2012 оны эцсийн байдлаар нийт 8 банк дээрхи шаардлагыг хангаж, үлдэх банкуудаас хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хэрхэн хангах

талаарх нэгдсэн төлөвлөгөөг гаргуулан хяналт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, нийт 4 дэд хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд хөтөлбөрт хамрагдсан банкуудын өөрийн хөрөнгөд тавигдах шаардлагыг уян хатан болгох буюу “Банкны өөрийн хөрөнгөд дэмжлэг үзүүлэх түр журам”-ыг баталсны дагуу өөрийн хөрөнгөд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлээд байна.

Төрөөс банкин дахь мөнгөн хадгаламжид гаргах баталгааны үйлчлэх 4 жилийн хугацаа 2012 оны 11 дүгээр сард дуусгавар болсонтой холбогдуулж Монголбанкнаас цаашид банкны харилцагчдыг хамгаалж, салбарын тогтвортой байдлыг илүү үр ашигтайгаар бэхжүүлэх бодлогын хүрээнд хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгох хуулийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн барьсан. Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилго бүхий хадгаламжийн даатгалын нэгдсэн тогтолцоог олон улсын жишиг, суурь зарчим, үндсэн зохицуулалтуудад тулгуурлан өөрийн орны онцлогт тохируулан хуулийн төслийг боловсруулсан. Улсын Их Хурлын 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн чуулганаар “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийг баталснаар Монгол Улсад хадгаламжийн даатгалын тогтолцооны эрх зүйн орчин бүрдлээ.

Банкны салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлж, хүүгийн түвшинг бууруулах зэрэг салбарын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд гадаадын банкууд дотоодын зах зээлд нэвтрэн санхүүгийн үйл ажиллагаа явуулах нь ихээхэн нөлөөтэй байдаг. Одоогоор манай улсад албан ёсны банкны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан гадаадын банкны салбар, тооцооны төв байхгүй бөгөөд 2012 оны эцсийн байдлаар гадаадын гурван банкны төлөөлөгчийн газар үйл ажиллагаагаа явуулж байна. Монголбанкнаас энэ чиглэлээр эрх зүйн орчинг бий болгох зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн А-80 дугаар тушаалаар “Банкны зөвшөөрлийн журам”, А-99 дугаар тушаалаар “Банкны нэгжийн журам”-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна.

Банкуудын мөрдөж буй “Банкны нягтлан бodoх бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн журам”-ыг шинэчлэн боловсруулах шаардлага бий болсонтой холбоотойгоор нягтлан бodoх бүртгэлийн багц материалыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартыг нийцүүлэн шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлсэн.

Банкны салбарын зээлийг эрсдэлийг бууруулах зорилгоор Төв банк зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг явуулж байна. Улсын Их Хурлаас 2011 оны 1 дүгээр сард “Зээлийн мэдээллийн тухай хуул”-ийг баталж, 2012 оны 12 дугаар сард “Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ыг гаргаснаар аливаа хуулийн этгээд нь зээлийн мэдээллийн нэгдсэн үйлчилгээг үзүүлэх, хуулийн этгээдийг байгуулж, үйлчилгээг үзүүлэх боломжтой боллоо.

### Шигтгээ 5: Хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоо

Монгол Улсын Их Хурлаас 2008 оны 11 дүгээр сарын 25-нд "Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль"-ийг баталсан бөгөөд банкны салбараас гадагшлах эх үүсвэрийн урсгалыг бууруулж, банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн. Уг хуулийн үйлчлэх хугацаа 4 жил бөгөөд 2012 онд дууссан болно. Гэвч уг хуулийн үйлчлэх хугацаа дууссанаар цаашид банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хэрхэн хамгаалах зэрэг асуудлууд тулгарсан юм. Банк, санхүүгийн байгууллагын онцлогоос хамааран төрийн зүгээс тэдгээрт хяналт тавих, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх шаардлага гардаг. Банк, санхүүгийн салбар тогтвортой оршин тогтоно, банкны харилцах, хадгаламж эзэмшигчдийг хамгаалах төрийн үндсэн гурван үүрэг байдал:

1. Хяналт шалгалт болон зохицуулалт,
2. Эцсийн зээлдүүлэгч,
3. Хадгаламжийн даатгал.

Монголбанк, Сангийн яам, Хууль зүйн яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран 2010 оны 11 дүгээр сард "Хадгаламжийн даатгалын тухай хууль"-ийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Хуулийн төслийг боловсруулан 2012 оны Улсын Их Хурлын намрын чуулганд дахин өргөн барьж (өмнөх УИХ-уудад өргөн барьж байсан) 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын чуулганаар баталлаа. Уг хууль батлагдсанаар Монгол Улсад хадгаламжийг даатгах эрх зүйн үндэс тавигдаж байгаа бөгөөд банкны салбарын тогтвортой байдал, иргэдийн банкинд итгэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй алхам болсон.

Хадгаламжийн даатгалын систем нь хоёр үндсэн зорилготой:

- *Банкны жисжиг харилцагчдыг хамгаалах: Банкны харилцагчид нь банкны олон нийтэд хүргэж буй санхүүгийн тайлан мэдээнд шинжилгээ хийсний үндсэн дээр үйлчлүүлэх банкаа сонгох замаар зах зээлийн сахилга батыг хангахад чухал нөлөөтэй боловч жисжиг харилцагчдын хувьд ийм чадвар хомс байдгаас хадгаламжийн даатгалаар тэдгээр харилцагчдыг хамгаалах шаардлагатай.*
- *Санхүүгийн тогтвортой байдлыг хангах: Банк нь харьцангуй богино хугацаатай эх үүсвэр татаан төвлөрүүлж, харьцангуй урт хугацаатай зээлд байришуулан, эдгээрийн хүүний зөрүүнээс ашиг олох үндсэн үйл ажиллагаа явуулдаг. Банкны энэхүү мөн чанар нь актив, пассивын хугацааны зөрүүгийн эрсдэлд оруулдаг бөгөөд банкны талаар бодитой болон бодитой бус сөрөг мэдээлэл тархвал олон харилцагч харилцах, хадгаламжсаа зэрэг татааж, улмаар банк төлбөрийн чадваргүй болж дамжуурах эрсдэлтэй. Мөн нэг банк хүндрэлд ороход энэ нь бусад банкинд хүндрэл учруулах эрсдэл бий. Хадгаламжийн даатгал нь харилцагчдын хөрөнгийг хамгаалнаар банкнаас харилцах, хадгаламж хурдацтай гадагшлах урсгалаас сэргийлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөтэй.*

Хадгаламжийн даатгалын хуульд дараах зарчим тусгагдсан болно:

**Хадгаламжийн даатгалын байгууллагын эрх, үүрэг:**

- Банкны харилцагчдад нөхөн олговор олгох.
- Даатгалын хураамжийн хувийг тооцох, нэмэгдүүлэх.
- Банкны эрсдэлийг үнэлэх.
- Банкны эрсдэлийг хянах.
- Хураамжийн хувийг банкны санхүүгийн чадвараас хамааруулан тогтоох.

**Хадгаламжийн даатгалын хамрах цар хүрээ:**

- о Банк бүрийн харилцагч бүрийг хамарна.
- о Иргэд, аж ахуйн нэгж, гадаадын оршин суугч, оршин суугч бус, банк санхүүгийн байгууллага
- о Төгрөг болон валютын харилцах, хадгаламж хамрагдана.
- о Даатгах хадгаламжийн дээд хэмжээг 20 сая төгрөгөөр тогтоосон.
- о Харилцах, хадгаламжийг тавьж олгоходо банкинд өглөгдэж иштээвэл тогтолцоо болно.

**Гишүүнчлэл:**

- о Заавал даатгах нэг хадгаламжийн даатгалын байгууллагатай байна.
- о Зөвхөн банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй банкууд гишүүн болно.

**Хадгаламжийн даатгалын тогтолцоо:**

Хадгаламжийн даатгалын системийн (цаашид ХДС гэх) мандат нь улс орнуудад янз бүрийн цар хүрээтэй байдаг. Хамгийн энгийн хэлбэр нь paybox буюу банк хаагдсан үед харилцагчдын мөнгийг тавьж олгох үүрэгтэй байдаг бол хамгийн өргөн нь risk minimizer буюу ХДС-д орох гарах эсэхийг шийдэх, өөрийн эрсдэлээ үнэлж удирдах, банкинд шалгалт хийж буюу шалгалт хийж хүсэлт гаргах, хүндрэлд орсон банкны асуудлыг шийдвэрлэх зэрэг эрх, үүргийг агуулсан байдаг. Мөн ХДС-ийн эрх, үүрэг paybox болон risk-minimizer-н хооронд янз бүр байж болдог. Дэлхийд цөөхөн байдаг risk minimizer-н үүрэгтэй хадгаламжийн даатгалын байгууллагууд нь эхнээсээ бий болоогүй, олон жилийн шалгарлын дунд ингэж тогтсон байдаг.

<b>Paybox</b>	<b>Paybox - plus</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Даатгагдсан хадгаламжийг зөвхөн нөхөн олгох үүрэгтэй</li> <li>- Нийт 32 орон уг системийг хэрэглэж байна           <ul style="list-style-type: none"> <li>• Ази -4</li> <li>• Карибийн - 1</li> <li>• ЕвроАзи - 2</li> <li>• Европ - 19</li> <li>• Латин америк - 4</li> <li>• Хойд америк - 2</li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бусад нэмэлт үүргүүдийг хүлээндэг. Жишээ нь эрсдэлийг үнэлэх, удирдах гэх мэт</li> <li>- Нийт 33 орон уг системийг хэрэглэж байна           <ul style="list-style-type: none"> <li>• Африк - 2</li> <li>• Ази -6</li> <li>• Евро Ази - 2</li> <li>• Европ - 14</li> <li>• Латин америк - 7</li> <li>• Бусад - 3</li> </ul> </li> </ul>
<b>Loss-minimizer</b>	<b>Risk minimizer</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Зардлыг хамгийн бага байлгах стратегийг боловсруулж үйл ажиллагаа явуулдаг</li> <li>- Энэхүү системтэй зөвхөн 1 орон Европт байдал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрсдэлийг хамгийн бага байлгах зорилготой. Бүхий л үүрэг, эрх мэдэл, зохицтой харьцааны шалгуур хамаардаг</li> <li>- Нийт 20 орон уг системийг хэрэглэж байна           <ul style="list-style-type: none"> <li>• Африк - 2</li> <li>• Ази -5</li> <li>• Карибийн - 2</li> <li>• Европ - 3</li> <li>• Хойд, өмнөд америк - 8</li> <li>• Бусад - 3</li> </ul> </li> </ul>

Эх сурвалж: ОУХДК 2012 оны судалгаа

### Хадгаламжийн даатгалын сангийн гишүүд

Олон улсын стандартад хадгаламжийн даатгалд хамрагдахын тулд хүчтэй хяналт шалгала болон зохицуулалтын орчинтой байх, санхүүгийн хүндрэлийг урьдчилан таньж мэдэн арга хэмжээ авах (prompt corrective action) боломжтой байх, дампуурлыг шийдэх зохистой орчин бүрэлдсэн байх (problem financial institution resolution) зэрэг урьдаач нөхцөлийг бүрдүүлсэн байхыг зөвлөдөг. Банк бүрийн харилцагч бүрийг хамрах зарчим баримталдаг.

Даатгах хадгаламжийн хэмжээг харилцагч бүрээр тогтоох нь ёс зүйн гажуудлаас (moral hazard) сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Гэвч харилцагч нэг болон хэд хэдэн банкинд хүссэнээрээ данс нээлгэх боломжтой манай орны тохиолдолд даатгах хадгаламжийн хэмжээг харилцагч бүрээр тогтоох нь харилцагч бүрийн мэдээллийг цуглуулах нүсэр ажил хийх шаардлага бий болгохын зэрэгцээ тооцооллын бусад хүндрэлийг ч учруулна. Demirgöz-Kunt, Karacaovali, Laeven (2005) нарын хийсэн судалгаанд хамрагдсан орнуудын 79 хувьд нь даатгах хадгаламжийн хэмжээг хадгаламж эзэмшигч тус бүрээр тогтоосон байдаг байна.

### Нөхөн олговрын хязгаарлалт

Даатгах харилцах, хадгаламжийн хэмжээнд хязгаар тогтоох нь харилцагчид өндөр хүү амласан банкинд мөнгөө хадгалуулахаас сэргийлж, харилцагчид банкны төлбөрийн чадварт тодорхой хэмжээгээр хяналт тавих сэдлийг төрүүлэх нөлөөтэй юм. Даатгах хадгаламжийн хэмжээг тогтоохдоо санхүүгийн тогтвортой байдлыг хангах, жижиг харилцах, хадгаламж эзэмшигчдийг хамгаалах гэсэн зорилгуудыг харгалзаж үзэх шаардлагатай.

Улс орнуудын хадгаламжийн даатгалын тогтолцоог харьцуулахдаа даатгах хадгаламжийн хэмжээг нэг хүнд ногдох ДНБ-тэй харьцуулснаа авч үзэх нь түгээмэл байдаг. Энэ жишгээр энгийн үед даатгах хадгаламжийн хэмжээг нэг хүнд ногдох ДНБ-ээс ойролцоогоор 2 дахин их байхаар тогтоохыг зарим олон улсын байгууллага зөвлөдөг бөгөөд үүнийг дагавал Монголд даатгах хадгаламжийн хэмжээг 5 сая төгрөгөөр тогтоохоор байгаа юм. Гэхдээ үүнд мөн харилцах, хадгаламжийн тархалтыг харгалзаж үзэх шаардлагатай. Хадгаламжийн даатгалын олон улсын стандартад даатгах хадгаламжийн дээд хэмжээ аль болох бага боловч мөн итгэл төрүүлэхүйц байхыг зөвлөсөн байдаг. Олон улсын хадгаламжийн даатгалын байгууллагуудын холбооноос жижиг харилцагчдыг хамгаалах зорилготой, хадгаламж нь том харилцагчдад ихэхэн төвлөрсөн оронд харилцагчдын 80 хувийг бүрэн хамарсан, нийт харилцах, хадгаламжийн дор хаяж 20 хувийг хамарсан байдлаар даатгах хадгаламжийн дээд хэмжээг тогтоохыг зөвлөсөн байдаг (IADI DP 2009). Олон улсын санхүүгийн зах зээлийн өнгөрсөн 2009 оны хямралын явцад улс орнууд нөхөн олговрын хэмжээгээ нэмэгдүүлсэн.

Хэрэв хадгаламжийн даатгалыг сайн дурын байхаар тогтоовол эрсдэл өндөртэй банкууд хадгаламжийн даатгалд хамрагдах, эрсдэл багатай банкууд хадгаламжийн даатгалд хамрагдахгүй байх хандлагыг бий болгох бөгөөд энэ нь хадгаламжийн даатгалын ач холбогдлыг бууруулж, ХДС-д эрсдэл учруулах аюултай. Demirgöz-Kunt, Karacaovali, Laeven (2005) нарын судалгаанд хамрагдсан 82 орны 75 нь хадгаламжийг заавал даатгах тогтолцоотой байна.

### Банкны салбарын хяналт шалгала

#### Газар дээрх хяналт шалгала

Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан “Монголбанкнаас 2012 онд банкуудад газар дээрх ээлжит шалгала хийх хуваары”-ийн дагуу хийсэн газар дээрх, иж бүрэн шалгалтанд бүх банкууд хамрагдсанаас, Төрийн банк, Капитрон, Худалдаа хөгжлийн банкуудад нэмэлт шалгала хийлээ. Тайлант онд нийт 17 удаагийн газар дээрх шалгала хийсний 13 шалгалтын тайланг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулав. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 726 дугаар тушаалын дагуу нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцааны

үзүүлэлтийн байвал зохих доод түвшинг 2 нэгжээр нэмэгдүүлэн 8 хувь, банкны системд нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтийн байвал зохих доод түвшинг 1 нэгжээр нэмэгдүүлэн 13 хувьд тус тус хүргэх шаардлагуудын биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.

Мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн дагуу ХААН, Голомт, Чингис хаан, Тээвэр хөгжлийн банкуудад “Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд, ХААН банкны үнэт цасны төлбөр тооцооны үйл ажиллагаанд болон Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар баталсан удирдамжийн дагуу нэр бүхий 8 банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын үйл ажиллагаанд тус тус шалгалт хийллээ.

Дээрх шалгалтуудаар банкууд актив болон түүнтэй адилтган тооцох хөрөнгийн ангиллыг зохих журмын дагуу хийгээгүй, активын эрсдэлийн санг дутуу байгуулсан, зээлийн хүүгийн авлагыг зохих журмын дагуу хуримтлуулан тооцоогүй, зохистой харьцааны үзүүлэлтүүдийг зөрчсөн, зээлийн мэдээллийн санд мэдээлэл буруу оруулсан, тайлан мэдээ буруу гаргасан, нягтлан бодох бүртгэлийн заавар, олон улсын бүртгэлийн стандартыг зөрчсөн, зээл олгоходоо банкны бусад бүтээгдэхүүн, үйлчилгээгээр үйлчлүүлэхийг зээлдэгчид гэрээний нөхцөл байдлаар шаарддаг, аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд нийтэд мэдээлээгүй, чанаргүй актив төлүүлэх үйл ажиллагаа хангальгүй, Монголбанкинд бүртгүүлэх эрх зүйн баримт бичгийг бүртгүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрснийг тогтоов.

Эдгээр зөрчлийг арилгуулах зорилгоор банкнаас боловсруулсан өөрийн хөрөнгийн хүрэлцээг ханган ажиллах төлөвлөгөөг Монголбанкаар хянуулсны үндсэн дээр хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд харилцах, хадгаламж болон бусад эх үүсвэр нэмж татахыг хориглох, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламжийн дансдыг барьцаалж зээл авах, баталгаа гаргах зэргээр хөрвөх чадварыг хязгаарлах аливаа үйлдэл хийхгүй байх, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, активын өсөлттэй уялдуулан нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэхийг хориглох, чанаргүй активыг бууруулах, нэг зээлдэгч болон банкны холбогдох этгээдэд олгох зээлийн хязгаарлалтыг ханган ажиллах, зээлийн мэдээллийн санд нийлүүлэх мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв мэдээлж байх, зээлийн төвлөрлийг бууруулах, зохистой харьцаануудыг ханган ажиллах, ТҮЗ-ыг 5 ба түүнээс дээш гишүүнтэй болгох, мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэн ажиллах, зээл олгох үйл ажиллагааг хязгаарлах зэрэг арга хэмжээг банкуудад авч хэрэгжүүлэн, тушаалаар өгөгдсөн ҮҮРГҮҮДИЙН биелэлтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Орон нутаг дахь Монголбанкны салбаруудаас банкны салбар, нэгжүүдэд нийт 553 удаагийн газар дээрх шалгалт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайланг банкны салбар, нэгжээс гаргуулан танилцаж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллалаа.

Түүнчлэн Хяналт шалгалтын газрын захирлын томилолтоор З удаагийн шалгалт хийсний зэрэгцээ зарим банкуудтай холбоотой асуудалд шинжээчээр томилогдон ажилласан. Банкуудад хийсэн шалгалтын акт, материал болон банкуудын хяналт шалгалттай холбоотой бусад асуудлыг яаралтай хэлэлцэх шаардлагатай үед түргэн, шуурхай шийдвэрлэх зорилгоор “Монголбанкны Ерөнхийлөгчийн дэргэдэх Хяналт шалгалтын зөвлөлийн ажлын журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлуулан, журмын дагуу ажиллаж байна.

### *Зайнаас хяналт тавих ажлын хүрээнд*

Тайлант жилд банкуудаас сар бүр Хяналт шалгалтын газарт ирүүлэх санхүүгийн тайлан мэдээ,

Газар дээрх шалгалтын дунд үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар өгсөн үүргийн биелэлт зэргийг шалгаж, татан буугдсан банкуудын үйл ажиллагааг дуусгавар болгох хүртэл хяналт тавих тусгай нэгжийг байгуулан ажиллаж байна.

Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлийн дагуу санхүүгийн тайлан болон бусад холбогдох мэдээллийг нийтэд ил тод болгох шаардлагын хангалтанд банкуудад тогтмол хяналт тавьж, цаашид уг хуулийн хэрэгжилтийг тодорхой загварт оруулах тал дээр ажиллаж байна.

Зайнаас хийгдсэн хяналтын хүрээнд активыг зохих журмын дагуу ангилаагүй, эрсдэлийн санг дутуу байгуулсан, нягтлан бодох бүртгэлийн холбогдох заалтуудыг биелүүлээгүй, тайлан мэдээг буруу гаргасан зэрэг зөрчилд улсын байцаагчийн акт, шийтгэвэр тогтоож, холбогдох гүйлгээ, залруулга хийлгэх, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллалаа.

## 2.3 Валютын ханшийн бодлого

Төгрөгийн валюттай харьцах ханшийн уян хатан бодлого нь макро эдийн засгийн өрөнхий тэнцвэрийг зах зээлийн зарчмаар хангах, гадаад зах зээлийн серөг өөрчлөлтийн нөлөөллийг төгрөгийн валюттай харьцах ханшаар дамжуулан шингээх замаар эдийн засгийн дунд ба урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах, хямраалаас урьдчилан сэргийлэх суурь нөхцөл болдог билээ. Ийм ч учраас Төреөс мөнгөний бодлогын талаар суулийн жилүүдэд баримталсан үндсэн чиглэлд “Төгрөгийн валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлөөр тодорхойлогдон уян хатан тогтоож байх”-аар заасан бөгөөд Монголбанк уг бодлого зарчмыг тууштай хэрэгжүүлсээр ирлээ.

Монгол Улсын эдийн засаг 2012 онд 12.3 хувиар өсч, банкуудын зээлийн үлдэгдэл 24 хувиар нэмэгдэхийн зэрэгцээ улсын төсөв 42 хувиар тэлсэн байна. Эдийн засаг ийнхүү тэлсэн нь бараа бүтээгдэхүүний үнэ өсөх дарамтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ дотоодын хэрэглээг 20 хувиар нэмэгдүүлж, төгрөгийн валюттай харьцах ханшийг 2012 оны 6 дугаар сараас эхлэн сулруулах чиглэлд нөлөөлсөн дотоод суурь нөхцөл болжээ.

Нөгөө талаар, 2012 онд Монгол Улсын урсгал тэнцлийн алдагдал 3.4 тэрбум ам.долларт хүрч 2011 оноос 1.2 дахин өссөн, бараа, үйлчилгээний худалдааны алдагдал 2.7 тэрбум ам.долларт хүрч 1.2 дахин өссөн бол эдийн засагт цэвэр дүнгээр орж ирсэн валютын хэмжээ 2011 оноос 388 сая ам.доллараар буюу 2 дахин бууруч 429 сая ам.доллартай тэнцэх хэмжээнд хүрсэн байна. Макро эдийн засгийн суурь нөхцөл ийнхүү төгрөгийн валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд үйлчилсэн байна.

Зураг 29: Урсгал дансны алдагдал ба төгрөгийн ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Монголбанк

Ийнхүү улсын төсвийн огцом тэлэлтээр өдөөгдсөн дотоодын эрэлт, бараа бүтээгдэхүүний импорт, үйлчилгээний тэнцлийн алдагдлын өсөлтөөс шалтгаалсан ургал тэнцлийн алдагдлын огцом өсөлт буюу макро эдийн засгийн суурь нөхцөл, гадаад эдийн засгийн орчны сөрөг өөрчлөлт буюу гадаад худалдааны нөхцөлийн бууралт<sup>2</sup>, гадаадын хөрөнгө оруулалт буурсан нөхцлүүд нь төгрөгийн валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд үйлчилсэн суурь шалтгаанууд болсон юм.

Зах зээлийн тогтвортой, үр ашигтай, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, валютын захын тогтвортой байдлыг хангах замаар макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголбанк нь төгрөгийн валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг зөвлүүлэх чиглэлээр шаардлагатай үед нь валютын захад оролцон зохицуулалт хийсээр ирсэн. Тухайлбал 2012 оны эхний хагас жилд төгрөгийн валюттай харьцах ханшийн огцом чангаралтыг сааруулах зорилгоор валютын захад оролцон, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж байсан бол эдийн засгийн суурь нөхцөл нь төгрөгийн валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд үйлчилсэн үед ханшид огцом савлагаа үүсгэхгүй байлгах зорилгоор 2012 оны 10 дугаар сараас эхлэн дотоодын захад валют нийлүүлж, богино хугацааны эрэлт, нийлүүлэлтийн зөрүүгээс шалтгаалсан ханшийн огцом хэлбэлзлийг зөвлүүлэн зах зээлд үүсээд байсан хүлээлтийн гажилтыг арилгасан. Ингэснээр тайлант онд валютын захын тогтвортой байдлыг хангаж ажилласан болно.


Монголбанк, Хятадын Ардын банк хооронд 2011 онд 5 тэрбум юаньтай тэнцэх хэмжээний үндэсний мөнгөн тэмдэгтийн своп хэлцэл хийх гэрээ байгуулсныг 2012 онд 10 тэрбум хүргэл нэмэгдүүлснээр шаардлагатай үед нь юанийг түргэн шуурхай бүрдүүлж, валютын дотоодын захад тогтвортгуй байдал үүсэх эрсдэлтэй үед юанийг валютын захад нийлүүлэх замаар валютын захын болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зэрэгт чухал ач холбогдолтой болсон билээ.

УИХ-aас 2012 оны аравдугаар сард Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай УИХ-ын тогтоолыг баталсны дагуу Засгийн газар эхний ээлжинд 1.5 тэрбум ам.долларын “Чингис бонд”-ыг олон улсын зах зээлд амжилттай арилжаалснаар Монгол Улсын гадаад валютын нөөц түүхэн дээд түвшин болох 4.1 тэрбум ам.долларт хүрсэн болно.

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкаас зарласан ханш 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдааар оны эхнээс 0.4 хувиар чангарч 1392.10 төгрөгт хүрсэн бөгөөд тайлант хугацаанд ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.14 хувь, чангаралт болон сулралтын дундаж хэмжээ харгалзан 0.16 хувь, 0.13 хувь байв. 2012 онд төгрөгийн валюттай харьцах ханшийн хэлбэлзэл жилийн нийт хоногийн 75 хувьд нь 0.2 хувиас хэтрээгүй байна. Нэгээс дээш хувийн ханшийн хэлбэлзэл жилийн туршид зөвхөн 2 өдөрт л ажиглагдажээ.

<sup>2</sup> Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2012 оны эцэст 1.355 байсан нь жилийн 23%-иар буурсан үзүүлэлт.

Зураг 30: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өдөр тутмын хэлбэлзлийн давтамж



Эх сурвалж: Монголбанк

## 2.4 Гадаад валютын улсын нөөцийн удирдлага

Монголбанк гадаад валютын улсын нөөцийг удирдахдаа түүний найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, дээрх нөхцлүүд бүрэн хангагдсан тохиолдолд нөөцийн үр өгөөжийг нэмэгдүүлэх гэсэн зарчмаар ажилладаг.

Тайлант онд Монголбанкны эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд гадаад валютын улсын нөөцийн бүтцийг батлан, түүний хүрээнд ажиллалаа. Ерөнхий бүтцийн хүрээнд гадаад валютын улсын нөөцийн активын бүтэц, гадаад валютын бүтэц, хөрөнгө оруулалтын зохистой хугацаа, хөрөнгө оруулалтын боломжит хэрэгслүүдийг тус тус тодорхойлов. Мөн гадаад валютын улсын нөөцийн хөрөнгө оруулалтуудын зах зээлийн үнэлгээг тогтмол хийж, зах зээлийн эрсдэлүүдийг тооцох, зээлийн эрсдэл болон холбогдох лимитүүдэд хяналт тавих, дэлхийн зах зээлийн байдлыг байнга ажиглан холбогдох мэдээ тайлан бэлтгэх зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ. 2012 онд Евро-бүсийн өрийн хямрал гүнзгийрэх магадлал өндөр, АНУ, Их Британи зэрэг бусад хөгжингүй орнуудын эдийн засаг тогтвортогоогүй хэвээр байсан тул нөөцийн найдвартай байдлыг хангах зорилгоор бэлэн валют, биет ба биет бус хэлбэрээр байршуулсан мөнгөжсөн алт, Төв банкуудад байршуулсан харилцах данс болон хадгаламж, Олон улсын санхүүгийн байгууллагуудын хадгаламж зэрэг хэрэгслүүдэд хөрөнгө орууллаа. Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудад зэрэглэл харгалзахгүйгээр баталгаагүй хөрөнгө байршуулаагүй болно.

АНУ-ын Холбооны нөөцийн банк, Европын холбооны төв банк зэрэг Төв банкуудын өөрийн орнуудад тулгараад буй хүндрэлүүдийг даван туулахын тулд баримталж буй мөнгөний тэлэх бодлогын нөлөөнд гол валютуудын хүү түүхэн нам түвшинд хүрсэн тул хүүний эрсдэлээс хамгаалж хөрөнгө оруулалтын зохистой хугацааг богино хугацаа буюу нэг ба түүнээс доош жилийн хугацаагаар тодорхойлж ажилласан.

Гадаад валютын улсын нөөцийн удирдлагыг сайжруулах, туршилага судлах зорилгоор бусад орны Төв банкууд болон Дэлхийн банктай хамтран ажиллав.

ГВУН-ийн хөрөнгө оруулалтын үргэлжлэх хугацааг 2012 онд Евро бүсийн өрийн хямрал, АНУ-ын эдийн засгийн өсөлт удаашралтай байгаа зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан 0-1 жилийн богино

хугацаатайгаар баталж, хүүгийн эрсдэлийг бууруулж ажилласан. Харин валютын бүтцийн хувьд Евро бүсийн өрийн хямралаас шалтгаалан европийн ханшийн нөөцөд эзлэх хувь хэмжээг бууруулж, ханшийн эрсдэлийг багасгах бодлого баримтлав.

“Төв банк /Монголбанк/-ны тухай хууль”-д заасны дагуу нөөцийн найдвартай байдлыг хангах зорилгоор ГВУН-ийг зээлийн эрсдэл харьцангуй бага дэлхийн эдийн засагт тэргүүлэгч орнуудын төв банкууд болох АНУ, Япон, Франц, Олон улсын төлбөр тооцооны банкинд (BIS) харилцах, хадгаламж хэлбэрээр байршуулж ажиллав.

2012 онд дэлхийн эдийн засагт голлох орнуудын төв банкууд бодлогын хүүг өмнөх оны мөн адил доод түвшинд барьсан. Евро бүсийн эдийн засгийн таатай бус байдал хэвээр үргэлжилж, өрийн хямрал ихэссэн нь тухайн бүс нутгийн ихэнх орнуудын зээлжих зэрэглэл буурахад нөлөөлсөн, улмаар европийн мөнгөний зах зээл дээрх богино хугацааны хүү буурахад нөлөөлж тайлант улирлын сүүлээр хүүгийн түвшин сөрөг болсон байна. Эдгээр нь ГВУН-ийн өгөөжийн түвшин 2012 онд буурахад нөлөөлсөн.

ГВУН 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 4,121.8 сая ам.долларт хүрч оны эхнээс 1,274.4 сая ам.доллараар нэмэгджээ. Энэ нь олон улсын жишиг доод түвшин болох импортын 12 долоо хоногийн хэрэгцээг дараах байдлаар бүрэн хангасан үзүүлэлт юм.

- *Валютын төлбөртэй импортын 2012 оны 12 дугаар сарын гүйцэтгэлээр авч үзэхэд 37.45 долоо хоног,*
- *Валютын төлбөртэй импортын сүүлийн 12 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 32.74 долоо хоног,*
- *Төлбөрийн тэнцлийн 2013 оны жилийн төсөөллиөр авч үзэхэд 25.91 долоо хоногийн импортын төлбөрийг тус тус гүйцэтгэх хэмжээнд байна.*

ГВУН-ийн 46%-ийг буюу 1,884.9 сая ам.долларыг бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэр бүрдүүлж байна. Энэ нь оны эхнээс 1,409.5 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Гадаад валютаар татан төвлөрүүлсэн эх үүсвэр ийнхүү өсөхөд банкуудын харилцах, хадгаламжийн үлдэгдэл 109.4 сая ам.доллар өссөн болон Засгийн газрын харилцах дансдын үлдэгдэл 1,492.8 сая ам.доллараар өссөн нь нөлөөлжээ.

### Зураг 31: Гадаад валютын улсын нөөц



Эх сурвалж: Монголбанк

Тайлант хугацаанд арилжааны банкууд Монголбанкин дахь харилцах дансаараа дамжуулан 2,744.7 сая ам.долларын эх үүсвэр татаж, 2,495.7 сая ам.долларын эх үүсвэрээр ностро дансаа зузаатгасан байна.

2012 онд засгийн газрын гадаад гүйлгээгээр нийт 1536.1 сая ам.доллар ГВУН-д орж ирсэн бол 124.0 сая ам.доллар гадаад төлбөрт шилжүүлсэн байна. Нийт орж ирсэн дүнгийн 1,500,0 сая ам.долларыг Засгийн газраас олон улсын захад арилжаалсан үнэт цаасны эх үүсвэр эзэлж байна.

ГВУН-ийн удирдлагын хүрээнд Монголбанк харилцах, хадгаламжийн хүүгийн орлого, богино хугацаат үнэт цаас, гадаад валютын арилжааны орлогоос 3.8 сая ам.доллар, гадаад валют, үнэт металлын арилжаанаас 0.6 сая ам.долларын ашиг олж, ГВУН-ийг нийт 4.4 сая ам.доллараар нэмэгдүүллээ.

## 2.5 Монгол Улсын Төлбөр тооцооны систем

### *Төлбөрийн систем*

Төв банк нь Монгол Улсын санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих, төлбөр тооцооны системийн үр ашигтай, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, бэлэн бус төлбөр тооцоог хөгжүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

Төлбөрийн системийн хууль эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор Олон улсын төлбөр тооцооны банкны Төлбөр тооцооны хороо, Үнэт цаасны хорооны олон улсын байгууллагын зөвлөлөөс хамтран 2012 онд шинэчлэн баталж мөрдүүлж байгаа Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмуудад нийцүүлэн “Төв банкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлого”-ыг шинэчилсэн. Түүнчлэн, ХБНГУ-ын төв банктай хамтран энэхүү шинэчлэгдсэн зарчим, стандартын талаарх сургалт, семинарыг зохион байгуулж, түүнд Төлбөр тооцооны үндэсний зөвлөл (PTY3)-ийн бүх гишүүн байгууллагыг оролцуулсан.

Төлбөр тооцооны үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай ажиллагааг сайжруулах зорилгоор “Төлбөрийн системийн оролцогчийн нөөц төв, түүний техникийн зохистой үзүүлэлт”-ийг батлан гаргалаа.

Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийг хөгжүүлэх, эрх зүйн орчинг төлөвшүүлэх, төлбөрийн системийн оролцогчдын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Хувьсан шинэчлэгдэх дэвшилтээт мобайл банкны үйлчилгээ” төслийн хүрээнд банк, санхүү, мэдээллийн технологийн болон төрийн бусад байгууллагатай хамтран ажиллаж, “Хөдөлгөөнт банк, цахим мөнгөний үйлчилгээний талаар баримтлах бодлого”-ыг боловсруулж, PTY3-өөр хэлэлцүүлж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооны хамтарсан тушаалаар батлуулсан.

### Хүснэгт 13: 2008-2012 оны банк хоорондын гүйлгээний тоо, дүн


	(мянган ширихэгээр, их наяд төгрөгөөр)									
	2008 он		2009 он		2010 он		2011 он		2012 он	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
I улирал	499.9	2.4	502.0	1.7	693.8	2.2	798.6	3.7	914.9	5.7
өсөлт (%)	32.0	70.4	0.4	-29.1	38.2	25.8	15.1	68.2	14.6	53.8
II улирал	633.6	2.8	715.9	1.8	908.9	3.0	1 077.5	5.4	1 249.4	7.5
өсөлт (%)	31.2	49.6	13.0	-35.6	27.0	69.6	18.5	80.0	16.0	38.5
III улирал	494.3	2.6	626.2	1.9	801.9	3.4	903.6	6.0	1 018.5	8.4
өсөлт (%)	20.0	47.0	26.7	-24.4	28.1	74.2	12.7	73.5	12.7	40.2
IV улирал	624.2	2.9	800.3	2.5	983.1	4.7	1 139.3	8.3	3 954.9	9.0
өсөлт (%)	14.2	-0.4	28.2	-13.6	22.8	86.2	15.9	76.6	247.1	8.4
Нийт	2 252.0	10.7	2 644.4	7.9	3 387.7	13.2	3 919.3	23.4	7 137.8	30.6
өсөлт (%)	23.6	34.4	17.4	-25.4	28.1	66.5	15.7	77.3	82.1	30.7

Эх үүсвэр: Монголбанк

Банк хоорондын гүйлгээний тоо, дунг өмнөх оныхтой харьцуулахад 2009 онд гүйлгээний тоо 17.4 хувиар өссөн бол гүйлгээний дүн 25.4 хувиар буурч, харин 2010 онд 28.1 ба 66.5 хувь, 2011 онд 15.7 ба 77.3 хувь, 2012 онд 82.1 ба 30.7 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Гүйлгээний тоо, дүн 2009 оноос хойш тогтмол өсч, 2011 оны сүүлчээс гүйлгээний дүн огцом нэмэгдсэн бол гүйлгээний тоо 2012 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлынхаас 3.8 дахин, өмнөх оны мөн үеэс 3.5 дахин нэмэгдсэн байна.

Зураг 32: 2008-2012 оны банк хоорондын гүйлгээний тоо, дүн



Эх сурвалж: Монголбанк

### Төлбөрийн карт

Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг бэлэгдэн нэрлэсэн үндэсний брэнд “F карт”-ыг банкуудтай хамтран гаргах ажлыг амжилттай зохион байгуулж, зах зээлд нэвтрүүлэв. Тус картыг гаргаснаар иргэдэд бэлэн мөнгөөр үйлчилгээ үзүүлдэг иргэний болон үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, гааль болон татвар, хураамж зэрэг төрийн үйлчилгээг “F карт”-аар хийх, түүнчлэн, цалин тэтгэвэр, халамж, хувь хишиг зэрэг төрөөс олгож буй үйлчилгээг энэхүү төлбөрийн картаар дамжуулан бэлэн

бусаар олгож, төрийн санхүүгийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх боломжийг бүрдүүлсэн юм.

Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв нь Монгол Улсын Засгийн газрын тогтооолоор Хүний хөгжил сангаас хүүхдэд олгож буй мөнгийг банкууд дахь тухайн хүүхдийн дансанд байршуулах ажиллагааг гүйцэтгэж байна. Хүний хөгжил сангаас хүүхдэд олгож буй энэхүү мөнгийг иргэд хүүхдийн “Ирээдүй” картыар авах боломжтой юм.

Төлбөрийн картын хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд БНХАУ-ын Юнион пэй интернэйшил компанитай хамтран ажиллах гэрээг байгуулснаар картын нэгдсэн сүлжээний гишүүн банкууд олон улсын Юнион пэй интернэйшил картыг төлбөр тооцоонд хүлээн авч эхлээд байна.

Картын хэрэглээний үзүүлэлтийг авч үзэхэд ПОБ төхөөрөмжөөр буюу банкин дээр очиж картаар хийсэн гүйлгээний тооноос бусад үзүүлэлтүүд жил тутамд өссөн байна. Энэ нь иргэдийн бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээ улам бүр нэмэгдэж байгаатай холбоотой.

#### Хүснэгт 14: Төлбөрийн картын хэрэглээ

<b>Картын хэрэглэгчийн тоо</b>					<i>Өөрчлөлт (%) 2012/2011</i>					
	2010	2011	2012	Орон нутаг						
Карт эзэмшигч	1 538 336	2 169 838	2 855 378	1 162 657	31.6					
Карт идэвхтэй ашиглагч	670 887	440 177	1 123 041	373 781	155					
<b>Төхөөрөмжийн тоо</b>										
	2009	2010	2011	2012	<i>Өөрчлөлт (%) 2012/2011</i>					
ПОС	3754	4418	5624	7210	28.2					
ПОБ	1186	1576	2354	2384	1.3					
АТМ	292	367	634	915	44.3					
Бусад	417	412	373	316	-15.3					
<b>Гүйлгээний тоо, дун төхөөрөмж тус бүрээр (сая ширхэг, тэрбум төгрөг)</b>										
	2009	2010	2011	2012	<i>Өөрчлөлт (%) 2012/2011</i>					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
ПОС	1.4	100.3	2.7	233.8	5.9	448.8	10.3	735.1	74.8	63.8
ПОБ	3.2	453.5	2.2	376.5	2.2	515.5	1.7	557	-21.1	11.9
АТМ	15.3	874.9	22.1	1541.5	36.7	2603.8	57.4	3993.2	56.4	53.4
Нийт	19.8	1428.7	26.9	2151.8	44.8	3568.1	69.5	5305.3	55	48.7

Эх сурвалж: Монголбанк

## 2.6 Банк, санхүүгийн салбарын хууль эрх зүйн шинэчлэл

УИХ-аас “Зээлийн батлан даалтын сангийн тухай” хуулийг 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр батлан гаргажээ. Энэ хуульд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан байна. Энэ хууль батлагдсанаар зээлийн батлан даалтын сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалт гаргах, улмаар жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, ажилгүйдлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой юм.

Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг Улсын Их Хурлаас 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр батлав. Үндэсний аюулгүй байдлыг хангахад стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид хөрөнгө оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулагч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээдийн хөрөнгө оруулалтыг зохицуулах, тэдгээрт зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахаар тусгажээ.

Энэ хууль батлагдсанаар эрдэс баялаг, банк, санхүү, хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид хөрөнгө оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулагч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээдийн Засгийн газраас зөвшөөрөл авах хэлцлүүдийг тодорхойлжээ.

**Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд** 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдөр **нэмэлт оруулж**, мөнгөн хадгаламжийн нийт хэмжээ нь 100 сая төгрөгөөс дээш нэг жил ба түүнээс бага хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн хүүгийн орлогоос татвар авах бөгөөд Монгол Улсын бусад иргэний мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогыг 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд албан татвараас чөлөөлөхөөр тусгасан байна.




## НЭЭЛТТЭЙ ЗАХ ДАХЬ МОНГОЛБАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 3.1 Төв банкны үнэт цаас

Монголбанкаас банкны системийн нөөцийг удирдах гол хэрэгсэл нь Төв банкны үнэт цаас юм. Монголбанк банкны нөөцийн эрэлт, нийлүүлэлт дээр үндэслэн ТБҮЦ-ыг арилжаалж байгаа ба энэ нь зах зээлийн хүүнд нөлөө үзүүлдэг. ТБҮЦ 1, 12, 28 долоо хоногтой байх ба 7 хоногтой үнэт цаасны арилжаа нь тогтмол хүүтэй, харин 12 болон 28 долоо хоногтой үнэт цаасны арилжаа нь хүүгээр өрсөлдүүлэх хэлбэртэй байна. Монголбанк 2012 онд нийт 8.58 их наяд төгрөгийн ТБҮЦ борлуулсан нь 2011 оны дүнгээс 3.4 дахин бага дун юм (Зураг-33). Өмнөх онтой харьцуулахад 12, 28 долоо хоногийн хугацаатай үнэт цаасны эзлэх хувь өсчээ (Зураг-34). 2012 оны эцэст ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү 15.47 хувь байгаагийн 12 долоо хоногтой нь 16.45 хувь, 28 долоо хоногтой нь 16.82 хувь байжээ.


Зураг 33: Банкуудын эзэмшиж буй ТБҮЦ ба ЗГҮЦ



(Зураг-36). 2012 онд банкны нөөцийн эх үүсвэр буурсан тул Монголбанкнаас авах санхүүжилтийн хэмжээ өссөн учир Репо санхүүжилтийн дүн нийт үнэт цаасны<sup>3</sup> 32.7<sup>4</sup> хувтай тэнцэж байжээ (Зураг-33).

### 3.3 Засгийн газрын үнэт цаас

Зураг 37: 12 долоо хоногтой ЗГҮЦ-ны арилжааны ЖДХүү, ирүүлсэн санал болон зарласан хэмжээний харьцаа




Эх сурвалж: Монголбанк

Засгийн газрын санхүүгийн удирдлагыг сайжруулах, мөнгөний бодлогын арга хэрэгслийг нэмэгдүүлэх зорилгоор Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 217/A161 дүгээр хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ыг баталсан бөгөөд энэхүү журмаар Засгийн газраас гаргасан үнэт цаасыг Монголбанк бусад этгээдэд зуучлан борлуулахад үүсэх харилцааг зохицуулах юм. Уг журмын дагуу иргэн, аж ахуй нэгж байгууллагууд арилжааны банкаар дамжуулан Засгийн газрын богино хугацаат үнэт цаас<sup>5</sup> болон Засгийн газрын бонд<sup>6</sup>-ын арилжаанд оролцох боломжтой болсон бөгөөд нэгж Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ны нэрлэсэн үнэ 1 сая төгрөг байна.

2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Монголбанкаар дамжуулан ЗГҮЦ-ны анхны арилжааг амжилттай зохион байгуулсан ба 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд нийт 7 удаагийн ЗГҮЦ-ны арилжааг зохион байгуулжээ.

Зураг 38: 28 долоо хоногтой ЗГҮЦ-ны арилжааны ЖДХүү, ирүүлсэн санал болон зарласан хэмжээний харьцаа



Эх сурвалж: Монголбанк

<sup>3</sup> ТБҮЦ болон ЗГҮЦ

<sup>4</sup> 2012 оны 3 дугаар улиралд нийт үнэт цаасны 32.7 хувийг барьцаалан ТБ-наас санхүүжилт авсан байна.

<sup>5</sup> “Засгийн газрын богино хугацаат үнэт цаас” гэж Монгол Улсын Засгийн газраас гаргасан хуанлийн нэг жил ба түүнээс богино хугацаатай өрийн бичгийг хэлнэ. ЗГБХҮЦ-ыг нэрлэсэн үнээр гаргаж, анхдагч зах дээр хямдруулсан үнээр худалдах ба нэрлэсэн үнээр буцаан төлнө.

<sup>6</sup> “Засгийн газрын бонд” гэж Монгол Улсын Засгийн газраас гаргасан хуанлийн нэг жилээс дээш хугацаатай өрийн бичгийг хэлнэ. Засгийн газрын бондыг нэрлэсэн үнээр гаргаж, анхдагч зах дээр арилжаагаар тогтоон үнээр худалдах ба нэрлэсэн үнээр буцаан төлнө. Засгийн газрын бонд нь дуусах хугацаа хүртэл хагас жил тутам төлөгдхөк купонтой байна.

ЗГҮЦ-ны арилжааны хуанлийг Сангийн яам болон Монголбанкны цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хагас жилээр бэлтгэн, тухайн оны 1 дүгээр сарын 31, 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор олон нийтэд мэдээлэх бөгөөд ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч захын арилжааны журмууд, арилжааны үр дүнг мөн цахим хуудаснаас авах боломжтой юм.

### 3.4 Гадаад валютын дуудлага худалдаа


Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцлөөр тодорхойлогдон уян хатан тогтох байх зарчмыг баримтлан, гадаад валютын дотоодын зах дахь Монголбанкны оролцоог ил тод, нээлттэй хэрэгжүүлэх зорилгоор валютын дотоодын захад гадаад валютын дуудлага худалдаагаар оролцсоор ирсэн. Монголбанк эдийн засгийн суурь нөхцөл нь төгрөгийн валюттай харьцах ханшийг супруулах чиглэлд үйлчилсэн үед 2012 онд нийт 105 удаагийн дуудлага худалдаагаар ханшид огцом савлагаа үүсгэхгүй байлгах зорилгоор дотоодын захад цэврээр 639.9 сая ам.доллар нийлүүлжээ. Ингэснээр богино хугацааны эрэлт, нийлүүлэлтийн зөрүүгээс шалтгаалсан ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэн зах зээлд үүсээд байсан хүлээлтийн гажилтыг арилгаж валютын захын тогтвортой байдлыг хангаж ажилласан болно.

Мөн 2012 онд Монголбанк дотоодын валютын зах дээр юаниар дамжиж ирдэг ам.долларын эрэлтийг бууруулах, төгрөгийн ам.доллартай харьцах ханшид ирдэг дарамтыг багасгах зорилгоор гадаад валютын дуудлага худалдаагаар юань худалдаж эхэлсэн бөгөөд дотоодын захад цэврээр 2.5 тэрбум юань нийлүүлжээ. Ингэснээр гадаад валютын дотоодын захад юанийн хомсдол үүсгээгүй болно.

### 3.5 Дотоод зах зээлээс алт худалдан авалт

Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх дотоодын эх үүсвэрүүдийн нэг нь алт худалдан авалт юм. Монголбанк нь дотоодын алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс худалдан авсан алтыг гадаадын байгууллагуудад олон улсын жишигт хүргэн цэвэршүүлэн мөнгжүүлж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа эрхэлж байна. Тайлант хугацаанд Монголбанк 88 аж ахуйн нэгж, 13 иргэнээс нийт 3.36 тонн алтыг 222.4 тэрбум төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс 0.03 тонн буюу 1.09 хувиар өссөн үзүүлэлт юм. 2012 онд Монголбанк нийт 1.87 тонн алт цэвэршүүлж, гадаад валютын улсын нөөцийг 88.98 сая ам.доллараар нэмэгдүүллээ.

Зураг 39: Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (бохир жин, кг-аар)



Эх сурвалж: Монголбанк



#### 4.1 Монголбанкны бүтэц, зохион байгуулалт

Төв банк нь удирдлага, 9 газар, 2 бие даасан алба, орон нутаг дахь Монголбанкны 17 салбар, Лондон дахь төлөөлөгчийн газар бүхий бүтэц зохион байгуулалтаар үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн зарим газар хэлтсийн үйл ажиллагаанд бүтцийн өөрчлөлт хийгдэж, Хууль, эрх зүйн газар, Мөнгөн тэмдэгт үнэт зүйлсийн газар, Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар тус тус шинээр зохион байгуулагдан ажиллаж байна.

Монголбанкинд нийт 434 ажилтан ажиллаж, үүнээс 74.7 хувь нь Төв аппаратад ажиллаж байна.

Мэргэжлийн бүтцийг авч үзвэл эдийн засагч, нягтлан бодогч, бизнесийн удирдлага, эрх зүйч мэргэжилтэй ажилтан нийт ажилтандаа 71.4 хувийг эзэлж байна. Ажилтнуудыг тогтвортруулахад анхаарч ажилласан ба хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны ажлын төлөвлөгөөнд туссаны дагуу Монголбанкны төв аппаратын захиргааны ажилтнуудаас “Мэргэжил ур чадварын шалгалт” авах ажлыг зохион байгууллаа.

Ажилтнуудын цалин хөлс, урамшууллыг ажлын үр бүтээлтэй уялдуулан улирал бүр дүгнэж ажилласан ба цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажлын байрны нөхцөлийг сайжруулах, орон байр олгох асуудлыг тухай бүр төсөв хөрөнгөтэй уялдуулан шийдвэрлэж байна.

Спорт, олон нийтийн бүх төрлийн арга хэмжээнд ажилтнуудыг татан оролцуулах бодлого баримталж ажилласан. Ажилтнуудыг шагнаж урамшуулах, банкны ахмад настанд хүндэтгэл үзүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлж ирлээ. Их эзэн Чингис хааны мэндэлсний 850 жилийн ойг тохиолдуулан ажлын амжилт гаргаж, тогтвортруулахад анхаарч ажилласан ба хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны ажлын төлөвлөгөөнд туссаны дагуу Монголбанкны төв аппаратын захиргааны ажилтнуудаас “Мэргэжил ур чадварын шалгалт” авах ажлыг зохион байгууллаа.

#### 4.2 Гадаад харилцаа

Монголбанк гадаад харилцааны бодлогын хүрээнд бүс нутгийн санхүүгийн байгууллагын гишүүнчлэлээр Азийн Төв банкуудтай хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлж тухайн бүс нутгийн санхүүгийн интеграццалд тулхүү анхааран, БНХАУ, Япон, ХБНГУ болон Английн Төв банкуудтай тогтоосон 2 талын харилцааг цаашид дэлгэрүүлэн ажиллаж, Монгол Улсын засгийн газар, дотоод, гадаадын санхүүгийн байгууллагуудтай хамтран олон улсын санхүүгийн зах зээл дээр Монгол Улсын бондыг гаргахад Монголбанкнаас дэмжин ажиллаж, улс орны санхүүгийн тогтвортой байдлыг хангахад гол хөшүүрэг болно хэмээн хоёр тал онцолж байна.

Гадаад харилцааны чиглэлээр хийгдсэн ажлуудыг тоймлон дурдвал:

- 2012 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Монголбанкны Ерөнхийлөгч Л.Пүрэвдорж, Хятаадын Ардын банкны Ерөнхийлөгч Жоу Шиао Чуан нар Бээжин хотноо үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн хэмжээг 5 тэрбумаас 10 тэрбум юань, 1 их наяд төгрөгөөс 2 их наяд төгрөг болгож нэмэгдүүлэх гэрээний нэмэлт өөрчлөлтөд гарын үсэг зурсан. Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн хэмжээг нэмэгдүүлснээр хоёр улсын Төв банк хоорондын хамтын ажиллагаанд чухал алхам болоод зогсохгүй хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, бүс нутгийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад гол хөшүүрэг болно хэмээн хоёр тал онцолж байна.
- Монголбанк нь Солонгос Улсын Активын удирдлагын корпораци (КАМКО<sup>7</sup>)-тай “чанаргүй” ангилалд бүртгэгдсэн актив хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагааны талаар түриллага

<sup>7</sup>КАМКО - Korean Asset management corporation

солицоон хамтран ажиллахаар тохиролцож 2012 оны 2 дугаар сарын 17-ны өдөр Сөүл хотноо “Харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурсан. Санамж бичигт тусгагдсан үйл ажиллагааны үндсэн чиглэл нь 2 байгууллагын ажилтан, мэргэжилтнүүдийг харилцан солицож, туршилага судлах, актив хөрөнгийн маркетингийн үйл ажиллагаанд хамтран ажиллах, мэдээллийн солицоо болон бусад зах зээлд хамтран ажиллах болно.

- Монголбанкны удирдлага 2012 онд Солонгосын санхүүгийн харилцаа холбоо, клирингийн төв “KFTC” (Korea Financial Telecommunications & Clearings Institute)-ийн үйл ажиллагаатай танилцсан бөгөөд 2013 онд тус төвийн төлөвлөгчдийг Монголбанкинд урьж туршилага солицоохор төлөвлөөд байна.
- Солонгос улсын Сөүл хотод 2012 оны 2 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан ЗӨАТБХ-ны Захирлуудын зөвлөлийн 31 дэх удаагийн уулзалтад Монголбанкны Ерөнхийлөгч Л.Пүрэвдорж төлөвлөгчдийн хамт оролцсон. Уг уулзалтын үеэр Лаосын төв банкыг тус холбоонд элсүүлсэн бөгөөд ЗӨАТБХ-нд шинээр гишүүнээр элсэх хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцсэн. Уулзалтын үеэр 2012 онд хэрэгжүүлэх сургалт, судалгааны ажлын хөтөлбөр, тус холбооны дараагийн дээд хэмжээний уулзарт, зөвлөгөөн болох газар болон хугацааг батлав.
- Монголбанк Зүүн Өмнөд Азийн Төв Банкуудын Холбоо (ЗӨАТБХ)-ны Захирлуудын Зөвлөлийн 32 дахь удаагийн уулзарт, ЗӨАТБХ-ны Ерөнхийлөгч нарын 48 дахь удаагийн хурал, дээд хэмжээний зөвлөгөөнийг Улаанбаатар хотноо 2012 оны 11 дүгээр сарын 22-24-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд ЗӨАТБХ-ны гишүүн 18 төв банк болон стратегийн түнш байгууллагууд оролцсон юм. Уг уулзaltaар Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргалыг 2013 онд Захирлуудын зөвлөлийн даргаар сонгосон бөгөөд холбооны 2012 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг дүгнэн цаашидаа мөрдөж ажиллах үйл ажиллагааны чиглэл, байгууллага, цалин урамшиуллын бүтэц болон сургалт, судалгаа, уулзалтын хөтөлбөрүүдийн тал дээр гишүүн төв банкуудын санал хүсэлтийг хүлээн авсан. Мөн ЗӨАТБХ-ны Сургалт, судалгааны төвд шинээр гишүүнээр элсэж буй төв банкуудад тавих шалгуурыг баталсан бөгөөд Энэтхэгийн нөөцийн банкыг холбоондоо 19 дэх гишүүнээр элсүүлэхээр шийдвэрлэсэн. Уулзaltaас ЗӨАТБХ-ны гишүүн төв банкуудын хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангаж, тус холбооны зохистой гишүүнчлэлийн тоог тогтоох зорилготой ажлын хэсэг томилох шийдвэр гарсан. ЗӨАТБХ-ны Захирлуудын Зөвлөлийн 33 дахь удаагийн уулзарт, ЗӨАТБХ-ны Ерөнхийлөгч нарын 49 дэх удаагийн хурал, дээд хэмжээний зөвлөгөөний Непалын Раства Төв банк 2013 онд зохион байгуулахаар боллоо.

Чуулга уулзалтын үеэр ОУВС-гийн Ази-Номхон далааны бусийг хариуцсан салбарын ахлах эдийн засагч ноён Г.Алмекиндерс “Бус нутгийн болон олон улсын хэмжээнд санхүүгийн салбарт тулгарч буй асуудлууд” сэдвээр илтгэл тавьсан. Тэрээр илтгэлдээ Европ, АНУ руу экспортлох бараа, бүтээгдэхүүний хэмжээ багассанаас Азийн бусийн өсөлт суларсныг мөн дотооддоо санхүүгийн таатай нохцэл байдал хэвээр хадгалагдаж, зээлийн өсөлт тогтвортржссон нь тухайн бус нутгийн дотоод эрэлтэд эрэгээр нөлөөлснийг онцолсон юм. Чуулга уулзалтын хүрээнд зохион байгуулагдсан дээд хэмжээний семинарт Олон улсын төлбөр тооцооны банкны Ерөнхий захирал ноён Х.Каруана “Олон улсын зах зээлийн хөрөвөх чадварыг бэхжүүлэх аргыг санхүүгийн тогтвортой байдлын зүгээс дүгнэх нь” сэдвээр илтгэл тавьсан. Тэрээр илтгэлдээ олон улсын зах зээлийн хөрөвөх чадварын өнөөгийн нохцэл байдлыг дүгнэн ярьснаас гадна олон улсын хэмжээнд олгож буй зээлийн хэмжээ өсч байгаа нь өмнөх жилүүдтэй харьцуулахад хөрөвөх чадвар хангалитай байгааг илтгэж, энэхүү таатай боломжийг ашиглан цаашидын санхүүгийн тогтвортой байдлыг хангах хэрэгтэйг онцлон тэмдэглэжсээ. Илтгэлийн дараах хэлэлцүүлэгт Солонгосын төв банкны Ерөнхийлөгч ноён Чонгсо Ким “Бус нутгийн болон олон улсын хэмжээнд хийгдэх мөнгөний нөөцийн хэлцлүүд : Гадны шокод узүүлэх хариу арга хэмжээнүүд” сэдвээр, Хятадын төв банкны Дэд Ерөнхийлөгч ноён Ий Ганг олон улсын зах зээл дээрхи мөнгөний нөөцийг багасгадаг хүчин зүйлүүд, мөнгөний нөөцийг хэмжих хэмжүүрүүдийг хөндөжс тус тус санал бодлоо хуваалцсан.

#### **4.3 Олон нийттэй харилцах харилцаа**

Монголбанкаас олон нийттэй харилцах чиглэлээр мөнгөний бодлогын зорилго, түүнд хүрэх арга замыг олон нийтэд ил тод, нээлттэй байлгаж, Төв банкны бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлэн инфляцийн хүлээлтэнд нөлөөлөх чадамжaa дээшлүүлэн, Төвбанкнаас хэрэгжүүлж буй арга хэмжээ, хүлээгдэж буй үр дүнг тогтмол тайлбарлан таниулж иргэд, олон нийтийн зүгээс түүнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилготой ажиллав. Энэхүү зорилтын хүрээнд Монголбанкнаас 2012 оны турш Төв банкны үндсэн зорилт, үйл ажиллагаа, ил тод байдал, төсөв мөнгөний бодлогын уялдаа зэрэг сэдвээр олон нийт, оюутан сурагчид, хэвлэл мэдээллийн байгууллагынханд тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулав. Үүний хүрээнд эдийн засгийн чиглэлээр бичдэг сэтгүүлчдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор сургалт зохион байгуулж, ярилцлага мэдээлэл өгөх, оюутан сурагчид, санхүүгийн захын оролцогчдод сургалт семинар зохион байгуулах, лекц унших зэрэг ажлыг оны турш зохион байгуулсан болно. Түүнчлэн оюутан сурагчдад чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд Монголбанкинд зочил экспурс хөтөлбөрийг санаачлан эхлүүлээд байна.

#### **“Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төсөл”-ийг сурталчлах, тайлбарлах**

Монголбанк “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл”-ийг УИХ, Засгийн газар, хэвлэл мэдээллийн байгууллагууд, санхүүгийн зах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав. Үүний хүрээнд Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран сургалт семинарыг зохион байгуулсан төдийгүй хэвлэл мэдээллийн хэрэгслээр тайлбарлан таниулах ажлыг гүйцэтгэв. Мөн үндсэн чиглэлийн төсөлтэй холбогдуулж Монголбанкны Ерөнхийлөгчийн хэлсэн үг болон удирдлагуудын ярилцлагыг томоохон сонин хэвлэлээр тогтмол нийтлэн нийтлэн олон нийтийн хүртээл болгов.

#### **“Мөнгөний бодлогын шийдвэр гаргалт ба хэвлэлийн хурал“**

Монголбанк 2012 оны 10 дугаар сард Мөнгөний бодлогын зөвлөлийг шинээр, Захирлуудын зөвлөлөөсөө тусад нь байгуулж, зөвлөл дэх хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэн, шинэ бүтэц, зохион байгуулалт, журмаар мөнгөний бодлогын шийдвэрийн төслийг 3 үе шаттайгаар, өргөн хүрээнд нухацтай хэлэлцэн, шийдвэр гаргадаг боллоо. Ийнхүү асуудлыг тал бүрээс нь нухацтай хэлэлцсэний үндсэн дээр гаргасан шийдвэрээ албан ёсны хэвлэлийн хурлаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тогтмол тайлбарлаж байна.

Монголбанк 2012 онд оны эхэнд баталсан хэвлэлийн хурлын товын дагуу хэвлэлийн хурал зохион байгуулж ажиллав. Хэвлэлийн хурлын товыг Монголбанкнаас урьдчилан зарласан нь Төв банкны үйл хөдлөлийг таамаглагдахуйц болгох ач холбогдолтой төдийгүй банк, санхүүгийн захын шийдвэр гаргалтад ч мөн эерэгээр нөлөөлж байна. Мөнгөний бодлогын асуудлаар болон цаг үеийн сэдвээр хийсэн хэвлэлийн хурлаар Монголбанкны удирдлагууд сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулт өгөх, мөнгөний бодлогын шийдвэр гаргалт, түүний үндэслэл, шалтгаан, бодлогын хэрэгжилт, хүлээлт зэрэг сэдвээр зохих тайлбар, тодруулга өгч ажиллав. Монголбанк “Мөнгөний бодлогын мэдэгдэл”-ийг тухай бүр цахим хуудастаа байршуулан мөнгөний бодлогын хүү, бусад хэрэгсэлд өөрчлөлт орсон эсэх асуудлаарх мэдээллийг олон нийтэд өгч ажиллав. Үүний зэрэгцээ хэвлэлийн хурлын протоколуудыг хэвлэлийн хурал зохион байгуулагдсанаас хойш хоёр цагийн дотор цахим хуудсанд байршуулан ажилласан.

#### **“Монголбанкны хэвлэмэл бүтээгдэхүүн”**

Монголбанкны уламжлалт хэвлэмэл бүтээгдэхүүн болох Жилийн тайлан, Төрөөс мөнгөний

бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монголбанкны судалгааны ажил зэргийг хэвлүүлэн УИХ, Засгийн газрын гишүүд, төрийн байгууллагууд, арилжааны банкууд болон их дээд сургууль, номын сангруудад хүргүүлэв. Түүнчлэн Монголбанкны цахим хуудсанд байршуулан олны хүртээл болгов.

### **“Цахим хуудсыг боловсронгуй болгох”**

Монголбанк өөрийн цахим хуудасны үйл ажиллагааг боловсронгуй болгоход онцгой анхаарал хандуулан ажиллалаа. Төв банкны цахим хуудсанд “Үнийн тогтвортой байдал”, “Мөнгөний бодлогын зөвлөл”, “Засгийн газрын үнэт цаас” зэрэг дэд цэсүүдийг шинээр үүсгэж, шаардлагатай мэдээллийг тухай бүр шинэчилж байна. Мөн “Мөнгөний бодлого” цэсийн агуулга, бүтцэд анхааран, бодлогын үндсэн зорилт, арга хэлбэр, шилжих механизмыг шийдвэр гаргалт зэрэг мэдээг шинээр оруулах, шинэчлэн найруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Төв банкны хараат бус байдал, хариуцлага, ил тод байдал, Төв банкинд итгэх итгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэхэд онцгойлон анхаарч ажиллалаа. Монголбанкны удирдлагуудын ярилцлага мэдээллийг тухай бүр цахим хуудсанд байршуулж олны хүртээл болгов. Монголбанкнаас цахим хуудсаараа дамжуулан судалгаа, шинжилгээ, статистик мэдээллийг олон нийтэд танилцуулах ажлыг үргэлжлүүлж байна.

### **4.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх олон улсын бодлогыг боловсруулах чиг үүрэгтэй Олон Улсын Санхүүгийн Гэмт Хэрэгтэй Тэмцэх Бүлэг буюу ФАТФ-аас манай улсад тавьж байгаа хяналтын хүрээнд Монголбанк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Монгол Улсын хууль тогтоомжийг ФАТФ-ын 40 стандартад нийцүүлэхтэй холбоотой хуулийн төсөл боловсруулах ажлуудыг Хууль зүйн яам, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хийж ажиллалаа.

ФАТФ-тай тохирсон төлөвлөгөөний дагуу Монгол Улс нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Терроризмын эсрэг хуулиудад “мөнгө угаах”, “терроризмыг санхүүжүүлэх” гэмт хэргийн хамрах хүрээг өргөтгөх, дээрх гэмт хэргүүдээр хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах, хөрөнгө хураах, битүүмжлэх тухай хуулийн зүйл, заалтыг НҮБ-ын холбогдох конвенцид нийцүүлэн 2013 оны 6 дугаар сараас өмнө УИХ-аар батлах амлалтыг ФАТФ-т өгөөд байгаа юм.

Эдгээр хуулийн төслийг боловсруулахад Монголбанк нь Дэлхийн банк, Олон улсын валютын сан, НҮБ-ын терроризмын эсрэг хяналтын баг, Ази номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хяналтын бүлгийн зөвлөхүүдээс ирүүлсэн саналуудыг тусгаж боловсруулсан.

Монголбанк нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулинд орох нэмэлт өөрчлөлтийн талаар гаргаж байгаа ахиц дэвшлийг ФАТФ-т улирал бүр бичгээр болон амаар танилцуулж, тайлagnаж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Монголбанкны бүтцэд ажилладаг, санхүүгийн байгууллагуудаас мөнгө угаах, эсхүл терроризмыг санхүүжүүлэх сэжигтэй гүйлгээний тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийн, хууль сахиулах байгууллагуудад дамжуулах чиг үүрэгтэй Санхүүгийн мэдээллийн алба /СМА/-ны орон тоо, чадавхийг дээшлүүлэхтэй холбоотой ажлуудыг авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд Ази, Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаахтай тэмцэх тогтолцоонд

хийсэн 2012 оны харилцан үнэлгээний дагуух үнэлгээ (mutual evaluation follow up)-гээр СМА-ны үйл ажиллагааг, ялангуяа түүний дүн шинжилгээ хийх, орон тоо нэмэгдүүлэх, чадавхийг сайжруулах, хяналт шалгалтын чиглэлээр хийсэн ажлуудыг “хангалттай” төвшинд хүрсэн гэж үнэлсэн байна. Түүнчлэн, СМА-ны ажилтнуудын чадавхийг сайжруулах арга хэмжээний хүрээнд тэдгээрийн мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамрууллаа.

2012 онд санхүүгийн байгууллагуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдлийг үнэлэх, эрсдэлд суурисан зайнаас болон газар дээрх хяналт шалгалтын хөтөлбөр, журам боловсруулахад Олон улсын валютын сангаас Техникийн туслалцаа авч энэ талаарх Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албаны хяналт шалгалтын чадавхийг сайжруулах ажлуудыг зохион байгууллаа.

Тайлант хугацаанд Монголбанкны СМА нь дотоодын хууль сахиулах байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад гэмт хэргээс олсон орлогыг илрүүлэх үйл ажиллагаанд үзүүлэх зорилгоор санхүүгийн мэдээлэл солилцох үр ашигтай суваг, харилцааг бий болгож ажиллалаа.

Дэлхийн санхүүгийн мэдээллийн албадын холбоо Эгмонт бүлгийн гишүүний хувьд Монголбанк дахь Санхүүгийн мэдээллийн алба нь бусад орны санхүүгийн мэдээллийн албадтай санхүүгийн мэдээлэл солилцох Санамж бичиг байгуулах, тэдгээртэй үр дүнтэй хамтран ажиллах олон сувгийг үүсгэсний үр дүнд Монгол Улсаас гадаад руу гарсан, эсхүл гадаад орноос Монгол улс руу орж ирсэн бохир мөнгөний урсгалыг олж илрүүлэх хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллав.

2012 онд Ази номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэгт Монгол улсыг төлөөлж Монголбанк өөрийн орны ахиц дэвшилийг тогтмол тайлагнаж хамтран ажиллалаа.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд заасан чиг үүргийн хүрээнд 2012 онд Монголбанк нь Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа банк, санхүүгийн бусад байгууллагуудын ажилтнуудад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтуудыг зохион байгууллаа.

#### 4.5 Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Бүтэц, орон тооны өөрчлөлтөөр ДАГ (Дотоот аудитын газар)-ыг ДХҮАЭГ (Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар) болгон өөрчилсөн. ДХҮАЭГ нь ДХШХ (Дотоод хяналт, шалгалтын хэлтэс), ҮАЭХ (Үйл ажиллагааны эрсдэлийн хэлтэс) гэсэн хоёр хэлтэстэйгээр ажиллаж байна. ДХШХ нь Монголбанкны бүтцийн нэгжүүдэд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулж буй эсэхд хяналт тавьж, аливаа зөрчлийг илрүүлэн холбогдох арга хэмжээг авах, үүрэг даалгавар өгөх, удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг, ҮАЭХ нь Монголбанкны үйл ажиллагаанд учирч болзошгүй аливаа эрсдэлийг тогтоох, хянах, урьдчилан сэргийлэх, энэ талаар баримтлах заавар, журам боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, санал боловруулах чиг үүргийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дотоод хяналт шалгалтын 2011-2015 оны урт хугацааны төлөвлөгөөний хүрээнд тайлант онд газар дээрх шалгалтыг Монголбанкны бүх газар, хэлтэс, алба, орон нутаг дахь 17 салбарыг бүрэн хамруулан хийж ирлээ. Зайны хяналт, газар дээрх шалгалтын дүнг улирал бүр нэгтгэн Захирлуудын зөвлөл, Хяналтын зөвлөлд тайлагнаж ажилласан.

Цаашид ДХҮАЭГ-ын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг улам боловсронгуй болгох, үйл ажиллагааны үе шат бүрт анхан шатны болон дараалсан хяналтыг тогтмол, тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бий болгох, ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, шинэлэг арга барил, хэлбэрээр ажиллах зэрэг ажлуудыг тодорхой төлөвлөгөөтэй, үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

#### 4.6 Бэлэн мөнгөний хангарт

Монголбанкнаас 2012 онд мөнгөн тэмдэгтэй холбоотой дараах үйл ажиллагааг эрхлэв.

Өнгөрсөн онд аравт, хорьт, тавьтийн дэвсгэртийг Франц улсын Овертур Федюшир компани, 500-т, 1000-т ийн мөнгөн дэвсгэртийг Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Де Ла Руе компани болон 5000-т, 20000-т ийн дэвсгэртийг ХБНГУ-ын Гийзеке Девриент компаниар тус тус хэвлүүлэхээр гэрээ байгуулсан.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 826.1 тэрбум төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 115.4 тэрбум төгрөг буюу 16.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 15

№	Дэвсгэрт	2011 оны 12-р сарын 31				2012 оны 12-р сарын 31			
		Үлдэгдэл- Дэвсгэрт / сая төгрөг/	хувь	Ширхэг/ мянга	хувь	Үлдэгдэл- Дэвсгэрт /сая төгрөг/	хувь	Ширхэг / мянга	хувь
1	1	21	0%	21 052	9%	26	0.0%	26 437	9.0%
2	5	90	0%	18 020	8%	12	0.0%	23 481	8.0%
3	10	443	0%	44 369	19%	527	0.1%	52 729	18.0%
4	20	582	0%	29 145	12%	736	0.1%	36 804	12.6%
5	50	1 302	0%	26 051	11%	1 676	0.2%	33 516	11.5%
6	100	2 617	0%	26 178	11%	3 375	0.4%	33 753	11.5%
7	200	33	0%	165	0%	68	0.0%	338	0.1%
8	500	3 328	0%	6 656	3%	5 200	0.6%	10 400	3.6%
9	1000	13 114	2%	13 114	6%	13 727	1.7%	13 727	4.7%
10	5000	59 174	8%	11 834	5%	64 394	7.8%	12 878	4.4%
11	10000	190 952	27%	19 095	8%	234 702	28.4%	23 470	8.0%
12	20000	439 034	62%	21 951	9%	501 525	60.7%	25 076	8.6%
		710 696	100%	237 637	100	826 074.3	100.0%	292 615	100.0%

Эх сурвалж: Монголбанк

Дээрх хүснэгтээс харахад 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх жилийхтэй харьцуулахад дэвсгэртийн тоогоор 54.9 сая ширхэгээр буюу 23.2 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь том дэвсгэрт буюу 10000 болон 20000-тын дэвсгэртийн тоо ширхэг гүйлгээнд өссөнтэй холбоотой байна.

Сүүлийн 5 жилд Монголбанк банкуудаас хүлээн авсан болон банкинд олгосон бэлэн мөнгөний тоо, үнийн дүнгийн динамикийг доорхи хүснэгтээс /Хүснэгт 18/ харж болно.

Хүснэгт 16

Он	Банкинд олгосон		Банкнаас хүлээн авсан	
	Банкинд олгосон үнийн дүн/тэрбум төгрөг	Банкинд олгосон (мянган ширхэг)	Банкнаас хүлээн авсан үнийн дүн/тэрбум төгрөг	Банкнаас хүлээн авсан (мянган ширхэг)
2008	823.4	139250	966.4	151271
2009	630.5	111489	761.4	117774
2010	827.9	131954	862.5	123713
2011	1246.4	181258	1310.6	170460
2012	1564.2	224471	1663.3	198521
	4682.7	727119	4719	664864

Эх сурвалж: Монголбанк

#### 4.7 Мэдээллийн технологи

Монголбанк нь тайлант онд байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн технологийн системүүдийн найдвартай, аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллалаа.

Банк хоорондын мөнгөний захын үйл ажиллагаанд ашиглагдаж буй программ хангамжийн системийг өргөтгөн засгийн газрын үнэт цаасны арилжааг гүйцэтгэх программ хангамжийг боловсруулан ашиглаж эхэллээ. Түүнчлэн дотоод үйл ажиллагаанд ашиглагдах шинэ программ хангамжуудыг боловсруулах, ашиглаж буй программ хангамжийн системүүдийг өргөтгөх, сайжруулах ажлууд хийж гүйцэтгэлээ.

Моннолбанкинд ашиглагдаж буй мэдээллийн технологийн системүүдэд тохиолдож болзошгүй эрсдэлийг бууруулахад чиглэгдсэн цахим мэдээллийн системүүдийн нууцлал, аюулгүй байдал, тасралтгүй ажиллагааг хангах чиглэлд тодорхой ажлууд хийлээ.

#### 4.8 Монголбанкаас 2012 онд баталсан баримт бичгүүд

№	Огноо	Дугаар	Нэр	Агуулга
1	2012.01.23	A-9	Гадаад валютын дуудлага худалдааны журам, Гадаад валютын дуудлага худалдаа явуулах заавар	“Гадаад валютын дуудлага худалдаанд оролцох саналын маягт, “Гадаад валютын дуудлага худалдаа явуулах заавар”-ын 1 дүгээр хавсралтыг, Гүйлгээний шийдвэрийн маягтыг шинэчлэв.
2	2012.02.09	A-21	Гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг солих журам	Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу хүчинтэй боловч гэмтэлтэй гадаадын мөнгөн тэмдэгтийг банк хүлээж авах, солих үйл ажиллагааг журамлав.
3	2012.03.05	A-26	Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тооцож зарлах журам	Монголбанкаас төгрөгийн ам.доллартай харьцах ханшиг тооцож зарлах аргачлалыг тодорхойлох, хяналт тавих үйл ажиллагааг зохицуулсан.
4	2012.03.16	17/A-35	"Сонгуулийн зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, түүнийг зарцуулсан тухай тайлангийн загвар болон данс нээх, хаах, бүртгэл, тайлан хөтлөх журам"	Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцоо илэрхийлж Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл болон тойргийн хороонд бүртгүүлсэн нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансыг нээх, хаах, уг дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулах бүртгэл хөтлөх, зардлын тайлан гаргах үйл ажиллагааг журамлав.
5	2012.03.30	A-42	Банкны орон нутаг дахь нэгжийн хувийн хэргийг хөтлөх, шилжүүлэх, танилцах заавар	Банкны нэгжийн үйл ажиллагаанд зайнлас тавих хяналтыг хэрэгжүүлэх, санхүүгийн тайлан мэдээ, банкны нэгжийн талаарх албан баримт бичиг, судалгааны баримт зэргийг цуглуулан хувийн хэргийг бүрдүүлж, үнэн зөв, бүрэн системчлэн хатлах, хувийн хэрэг шилжүүлэх, танилцах зэргийг зохицуулж, ханган ажиллах талаар тусгажээ.
6	2012.04.17	A-52	Төв банкны бодлогын хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай	Монголбанк инфляцийг хязгаарлах, гадаад валюттай харьцах төгрөгийн ханшид ирэх дарамтыг бууруулах, маクロ эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор Төв банкны бодлогын хүүгийн хувь хэмжээг 12.75 байсныг 13.25 болгон шинэчлэн тогтоов.
7	2012.04.17	A-53	Заавал байлгах нөөцийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах тухай	Банкны төгрөгийн болон валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 1 нэгж хувиар өсгөн 12 болгон шинэчлэн тогтоов.

8	2012.06.07	A-80	Банкны зөвшөөрлийн журам	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 08 дугаар сарын 07-ны 375 дугаар тушаалаар батлагдсан “Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ыг Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль шинэчлэн батлагдсантай уялдуулан шинэчлэн найруулав. Уг журам нь банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг Монголбанк хүлээн авах, хүсэлт болон холбогдох баримт бичгийг хянах, тэдгээр хүсэлтийн дагуу хүсэлт гаргагч этгээдэд зөвшөөрөл олгох, олгосон зөвшөөрлийг хүчингүй болгох талаарх харилцааг зохицуулсан.
9	2012.07.04	A-99	Банкны нэгжийн журам	Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийг үндэслэн банкны нэгж байгуулаад зөвшөөрөл олгох, баримт бичгийг хянах, олгосон зөвшөөрлийг хүчингүй болгох харилцааг зохицуулжээ. “Банкны нэгжийн журам”-аар Монгол улсад бүртгэлтэй банк гадаад улсад банкны нэгж байгуулах зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, татгалзах хүчингүй болгох харилцааг шинээр оруулж өгсөн бөгөөд гадаадын банкны төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, татгалзах хүчингүй болгохтой холбоотой асуудлыг илүү тодорхой дэлгэрэнгүй тусгасан.
10	2012.10.26	A-149	"Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн зардлын данс нээх, хаах, дансанд мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, бүртгэл тайлан хөтлөх журам"	Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцохоо илэрхийлж аймаг, сум, дүүргийн сонгуулийн хороонд бүртгүүлсэн нам, эвслийн нэр дэвшигч болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансыг нээх, хаах, уг дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулах бүртгэл хөтлөх, зардлын тайлан гаргах үйл ажиллагааг журамлав.
11	2012.10.25	217/A-161	Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам /Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаал/	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хуулийн 8.1.10 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 17.2 дахь заалтын дагуу Монголбанк Засгийн газраас гаргасан үнэт цаасыг бусад этгээдэд зуучлан борлуулаад үүсэх харилцааг зохицуулсан.

12	2012.10.26	A-166/ A/24	“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах” дэд хөтөлбөр / Монголбанкны Ерөнхийлөгч, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаал/	Дэд хөтөлбөрийг хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах ойрын зорилттой, хүнсний бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэн, хүнсний бараа, бүтээгдэхүүний хангамжийн зах зээлд суурисан байнгын тогтолцоо бүрдүүлэх хэтийн зорилгоор хамтран баталжээ.
13	2012.10.26	A-167/57	“Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах” дэд хөтөлбөр /Монголбанкны Ерөнхийлөгч, Зам, тээврийн сайдын хамтарсан тушаал/	Гадаад худалдааны тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулах замаар өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн жигд тасралтгүй байдлыг хангах, үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор батлав.
14	2012.10.26	A-169	Мөнгөний бодлогын зөвлөлийн ажиллах журам	Монголбанкны бие даасан байдлыг бэхжүүлэх, мөнгөний бодлогыг боловсруулах үйл ажиллагаанд гадны төлөөллийг оруулах, мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл явцыг Мөнгөний бодлогын зөвлөлөөр дамжуулан оновчтой болгох, олон нийтэд хүргэхэд үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулсан.
15	2012.10.26	A-171/46	“Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортжуулах” дэд хөтөлбөр / Монголбанкны Ерөнхийлөгч, Уул уурхайн сайдын хамтарсан тушаал/	Дэд хөтөлбөрийн зорилго нь Жижиглэнгийн газрын тосны бүтээгдэхүүний импортыг Монголбанкаас тогтоосон хүүгээр санхүүжүүлэх, валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах нөлөөллийг бууруулах замаар шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгахад чиглэх болно.
16	2012.12.24	A-197	Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тухай зөвшөөрлийн журам	Монголбанкаас зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох, олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих харилцааг журамлажээ.

## ХАВСРАЛТ:

Огноо	Хэрэглээний сагсан дахь бүлгийн (хувийн жин) сарын өсөлтийн хувь	Инфляцийн өөрчлөлтийн шалтгаанууд...	Тайлбар
2012 оны 1 сар	- Хүнсний бараа, согтууруулах бус ундаа (30%) 5.9 хувь	- 1-р сарын дунд үеэс эхлэн асар бага хэмжээгээр бэлтгэсэн нөөцийн махыг худалдаалж эхэлсэн ч мах, махан бүтээгдэхүүний үнэ 12.2%-аар өссөн. Мөн сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 4.7%, жимс, жимсгэнийн үнэ 8.1%-аар тус тус өсчээ.	
2012 оны 2 сар	- Тээвэр (12.6%) 4.6 хувь	- Тээврийн хэрэгслийн шатах (шатахуун), тослох материалын үнэ 11.3%-аар нэмэгдэв.	
2012 оны 3 сар	- Хүнсний бараа, согтууруулах бус ундаа (30%) 6.7 хувь	-Мах, махан бүтээгдэхүүний үнэ 15.5%, хүнсний ногооны үнэ 3.3%-аар өсчээ.	
2012 оны 4 сар	- Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ (3.6%) 11.8 хувь	-Цайны газрын хоолны үнэ 10.4%-аар өсөв.	
2012 оны 5 сар	- Хүнсний бараа, согтууруулах бус ундаа (30%) 7.9 хувь	-Мах, махан бүтээгдэхүүний үнэ 17.1%-аар нэмэгдэж жилийн нийт инфляцийн 42.9%-ийг дангаараа тайлбарлаж байв.	
2012 оны 6 сар	- Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ (3.0%) 3.3 хувь	-Амбулаторын үйлчилгээний үнэ 12.4%-аар өсчээ.	
2012 оны 7 сар	- Хувцас, бөс бараа (12.2%) 2.1 хувь	-Эмэгтэй бэлэн хувцас 3.7%, гутал 3% өсөв.	
	- Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ (3.6%) 1.7 хувь	-Нийтийн хоол 1.7%, зочид буудлын ор хоногийн хөлс 5%-аар өссөн.	
	- Тээвэр (12.6%) -2.8 хувь	-Автомашиний үнэ 5.6%-аар буурсан.	
	- Хүнсний бараа ба согтууруулах бус ундаа (30%) 1.2 хувь	- Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2.4%-аар өсч жилийн инфляцийн түвшинг 7.3 нэгж хувиар өсгөжээ. Мөн жимс жимсгэнэ 3.9%, хүнсний ногоо 1.4%-аар өсөв. Харин сүү, сүүн бүтээгдэхүүн 2.3%-аар буурчээ.	
	- Орон сууц, ус, цахилгаан, түлш (14.7%) 3.1 хувь	- Орон сууцны түрээс 19.5%-аар өсөв.	
	- Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ (3.6%) 3.4 хувь.	- Нийтийн хоолны үйлчилгээний үнэ 3.4%-аар өсөв.	
	- Хүнсний бараа, согтууруулах бус ундаа (30%) 0.3 хувь	- Хүнсний ногооны үнэ 5.9%-аар өсч сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 7.3%-аар буурчээ.	
	- Орон сууц, ус, цахилгаан, түлш (14.1%) 1.5 хувь	-Орон сууцны түрээсийн үнэ 7.4%-аар өсөв.	
	- Хүнсний бараа, согтууруулах бус ундаа (30%) 1.9 хувь	- Мах, махан бүтээгдэхүүний үнэ 3.0%-аар өсч жилийн инфляцийн 50.7%-ийг дангаараа бүрдүүлжээ. Мөн хүнсний ногооны үнэ 4.9%-аар өсөв.	



## ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн тайланг бэлтгэх нь Монголбанк Захирлуудын Зөвлөлийн үүрэг байна.

Монголбанк (цаашид “Банк”)-ны санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн болно. Захирлуудын зөвлөл нь 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк үйл ажиллагаа, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үр дүн ба мөнгөн гүйлгээг эдгээр санхүүгийн тайлангуудад үнэн зөвөөр илэрхийлэгдсэнийг баталгаажуулах үүрэгтэй.

Захирлуудын зөвлөл нь Банкны санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлэх болон нягтлан бодох бүртгэлийг зөв зохист ой хөтөлж явуулдаг эсэх болон санхүүгийн тайлангууд нь Тодруулга 2-т тусгагдсан шаардлагуудад нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Үүнээс гадна, Банк хөрөнгийг хамгаалах, залилан, бусад зөрчил, дутагдлаас сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг авах нь Захирлуудын Зөвлөлийн үндсэн үүрэг байdag.

Санхүүгийн тайланг (1-58 дугаар хуудсанд үзүүлсэн) бэлтгэхдээ зохимжтой бодлогыг туштай баримталж, үндэслэлтэй бөгөөд оновчтой үнэлэлт, тооцооллыг ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн бүхий л холбогдох стандартуудыг дагаж мөрдсөн гэж Захирлуудын Зөвлөл үзэж байна.

Захирлуудын Зөвлөлийг төлөөлөн гарын үсэг зурсан:



Н.ЗОЛЖАРГАЛ

Монголбанкны Ерөнхийлөгч

Улаанбаатар



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Монголбанкны Захирлуудын зөвлөл болон Хяналтын зөвлөлд

Бид Монголбанк (цаашид “Банк” гэх)-ны 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодотголуудаас бүрдсэн хавсралтаарх санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

### *Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх үргэг хариуцлага*

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах, мөн залилан эсвэл алдаанаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэхэд шаардлагатай гэж үзэж буй дотоод хяналтыг бүрдүүлэх хариуцлагыг Банкны удирдлага хүлээнэ.

### *Аудиторын хариуцлага*

Өөрсдийн хийж гүйцэтгэсэн аудит дээр үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх нь бидний хариуцлага болно. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөх, мөн санхүүгийн тайлангууд материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаажуулалтыг олж авахууцаар аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудит нь санхүүгийн тайлан дахь дун болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг агуулдаг. Сонгосон горимууд нь залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд материаллаг алдаатай байх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор бус, харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг төлөвлөх үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудаа бэлтгэн үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг харгалzan үздэг. Мөн аудитын ажил нь даган мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолтуудын үндэслэлтэй байдал, түүнчлэн санхүүгийн тайлангуудыг толилуулсан өрөнхий байдлын талаарх үнэлгээг агуулдаг. Бидний олж авсан аудитын нотолгоо нь хязгаарлалттай аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэж байна.

### *Хязгаарлалттай дүгнэлт гаргах болсон үндэслэл*

Санхүүгийн тайлангийн Тодруулга 3-т тусгасны дагуу 2008 оноос хойш Банкны Бүрэн эрхт төлөөлөгчийн хяналтанд байгаа Анод банкинд холбогдох нийт 89,400 сая төгрөгийн (2011 оны 12 дугаар сарын 31-нээр 102,000 сая төгрөг)-ийн дүнтэй зээлийн үнэ цэнийн бууралтын нөөц болон тодруулгад харуулсан боди т үнэ цэнийг тооцоолох зорилгоор тухайн зээлтэй холбоотой ирээдүйн мөнгөн урсгалыг бодитойгоор тооцоолох боломжгүй байна. Өнгөрсөн тайлант хугацаанд (2011 онд) Банкны удирдлага нь Анод банкнаас авах авлагыг Монгол улсын Засгийн газрын бондоор эргүүлэн төлүүлэх замаар энххүү

*Прайсуутерхаус Куперс Аудит ХХК, Сэнтрал Тауэр, 6 давхар, 601  
Сүхбаатарын талбай СБД-8, Улаанбаатар 14200, Монгол Улс  
У: +976 (11)329088, +976 (11)329089 Ф: +976 (11)322068, www.pwc.com/mn*

зээлийг барагдуулна гэсэн дүгнэлттэй байсан тул 2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үнэ цэнийн бууралтын нөөц санг байгуулаагүй байсан. Гэсэн хэдий ч, Засгийн газрын бонд гаргалт нь Монгол Улсын Их Хурлаар хэлцэгдэн, эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

Иймд тухайн зээлтэй холбогдон бий болох ирээдүйн мөнгөн урсгалын дүн болон цаг хугацааны тодорхой бус байдлаас шалтгаалан Банк нь Анод банкны зээлийн үлдэгдэлд үнэ цэнийн бууралтын нөөц санг 100 хувиар байгуулсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-39 “Санхүүгийн хэрэгслүүд” (НББОУС 39)-ийн дагуу, Анод банкны үнэ цэнийн бууралтанд орсон зээлийн хүрээнд Банкны Бүрэн эрх хүлээн авагчаар дамжуулан эсвэл Засгийн газрын бонд гаргалтаас хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгал буй бол зээлийн бүртгэлийн дүнг “тэг” хүртэл бууруулах боломжгүй юм. Удирдлагын зүгээс энэхүү мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг НББОУС 39-ийн шаардлагын дагуу тооцоолох боломжгүй тохиолдолд бид 2012 оны 12 дугаар сарын 31-нээрх дотоодын банкуудын зээлийн бүртгэлийн дүн (мөн Тодруулга 29-д буй бодит үнэ цэнийн дун)-г өсгөх болон тухайн өдрөөр тасалбар болгосон дэлгэрэнгүй орлогын тайлан дахь дотоодын банкуудын зээлийн үнэ цэнийн бууралтын нөөц санг бууруулах залруулгын дүнг тооцоолох боломжгүй байна.

Үүнээс гадна, өнгөрсөн оны санхүүгийн тайланд 2012 оны 6 дугаар сарын 7-ний өдөр бидний өгсөн хязгаарлалттай дүгнэлтэнд дурьдсаны дагуу бид 2010 болон 2011 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайлан дахь дотоодын банкуудад олгосон зээл (мөн Тодруулга- 29 дахь бодит үнэ цэнэ) болон тухайн өдрөөрх дэлгэрэнгүй орлогын тайлан дахь дотоодын банкуудад олгосон зээлийн үнэ цэнийн бууралтын нөөц сангийн бүртгэлийн дүнгүүдийн талаар зохистой, хангалттай нотолгоо олж авч чадаагүй болно.


### **Хязгаарлалттай дүгнэлт**

Бидний дүгнэлтээр, “Хязгаарлалттай дүгнэлт гаргах болсон үндэслэл” хэсэгт тусгагдсан асуудлаас үүдэлтэйгээр гарч болзошгүй нөлөөг эс тооцвол, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Банкны санхүүгийн байдал, мөн тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв бодитойгоор илэрхийлсэн байна.

  
PRICEWATERHOUSE COOPERS  
Даваагийн Баярмаа

Гүйцэтгэх Захирал  
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:

  
Каролин Кларк  
Партнер  
2013 оны 4 дүгээр сарын 26


Улаанбаатар хот, Монгол Улс

<i>Сая төгрөгөөр</i>	<i>Тодруулга</i>	<b>2012 оны 12 дугаар сарын 31</b>	<b>2011 оны 12 дугаар сарын 31</b>
<b>ХӨРӨНГӨ</b>			
Бэлэн мөнгө	6	28,317	44,505
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	7	3,272,979	2,244,580
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулахад бэлэн	8	142,553	212,540
Буцаан худалдан авах хэлцэл	9	2,031,631	678,496
Алт ба үнэт металл	10	439,669	268,085
Засгийн газрын үнэт цаас	11	159,210	155,276
Дотоодын банкуудад олгосон зээл	12	294,810	340,581
Үндсэн болон биет бус хөрөнгө	13	26,631	26,003
Бусад хөрөнгө	14	7,421	6,148
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>6,403,221</b>	<b>3,976,214</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө		828,450	713,351
Төв банкны үнэт цаас	15	752,151	879,113
Төрийн байгууллагуудад өгөх өр төлбөр	16	2,959,686	1,170,890
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	17	1,371,671	1,015,230
Гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр	18	576,414	105,412
Бусад өр төлбөр	19	62,481	58,072
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>6,550,853</b>	<b>3,942,068</b>
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>			
Дүрмийн сан	20	5,000	5,000
Хуримтлагдсан алдагдал		(302,685)	(91,799)
Бусад нөөц	20	150,053	120,945
<b>НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>		<b>(147,632)</b>	<b>34,146</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>		<b>6,403,221</b>	<b>3,976,214</b>

2013 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Захирлуудын Зөвлөлийг төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрөв.



Н. Золжаргал  
Монголбанкны Ерөнхийлөгч



М. Амгалан  
Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын захирал

Хуудас 6-58-т хавсаргасан тодруулэгүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно

<i>Сая төгрөгөөр</i>	<i>Тодруулга</i>	<b>2012</b>	<b>2011</b>
Хүүгийн орлого	21	59,349	19,669
Хүүгийн зардал	21	(104,773)	(118,981)
<b>Хүүгийн цэвэр зардал</b>		<b>(45,424)</b>	<b>(99,312)</b>
Алт, үнэт металлын арилжааны цэвэр ашиг	22	20,449	43,430
Валютын ханшийн зөрүүний (цэвэр алдагдал) / ашиг	23	(23,694)	252,306
Санхүүгийн хэрэгсэл, деривативын цэвэр алдагдал		(10,267)	-
Зах зээлийн хүүгээс доогуур хүйтэй олгосон зээлийн анхлан хүлээн зөвшөөрөлтийн үеийн алдагдал	3,12	(17,895)	-
Борлуулахад бэлэн хөрөгө оруулалтын борлуулалтын болон үнэ цэнийн бууралтын алдагдал		(453)	-
Шимтгэлийн орлого		2,452	2,002
Үйл ажиллагааны бусад орлого		845	603
Үнэ цэнийн бууралтын нөөц сангийн (зардал)/буцаалт	24	(88,616)	3,536
Үдирдлагын ба үйл ажиллагааны бусад зардал	25	(18,791)	(22,933)
<b>ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ (АЛДАГДАЛ) / АШИГ</b>		<b>(181,394)</b>	<b>179,632</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого:</b>			
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр олз/ (гарз):			
-Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн (гарз) / олз		(837)	21
-Борлуулалтын үед орлогын тайланд шилжүүлсэн		453	-
<b>Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй (алдагдал) / орлого</b>		<b>(384)</b>	<b>21</b>
<b>ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ (АЛДАГДАЛ) / ОРЛОГО</b>		<b>(181,778)</b>	<b>179,653</b>

Хүудас 6-58-т хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлантгийн салшгүй хэсэг

<b>Сая төгрөгөөр</b>	<b>Тодруулга</b>	<b>Дүрмийн сан</b>	<b>Хуримтлагдсан алдагдал</b>	<b>Бусад нөөц</b>	<b>Нийт өөрийн хөрөнгө</b>
<b>2011 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл</b>		<b>5,000</b>	<b>(34,331)</b>	<b>(116,176)</b>	<b>(145,507)</b>
Тайлант жилийн ашиг		-	179,632	-	179,632
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	21	21
2011 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	179,632	21	179,653
Хуримтлагдсан ашгаас бусад нөөцөд шилжүүлсэн	23	-	(222,769)	222,769	-
Хуримтлагдсан ашгаас бусад нөөцөд шилжүүлсэн	22	-	(14,331)	14,331	-
<b>2011 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>		<b>5,000</b>	<b>(91,799)</b>	<b>120,945</b>	<b>34,146</b>
Тайлант жилийн алдагдал		-	(181,394)	-	(181,394)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	(384)	(384)
2012 оны нийт дэлгэрэнгүй алдагдал		-	(181,394)	(384)	(181,778)
Хуримтлагдсан ашгаас бусад нөөцөд шилжүүлсэн	23	-	(14,201)	14,201	-
Хуримтлагдсан ашгаас бусад нөөцөд шилжүүлсэн	22	-	(15,291)	15,291	-
<b>2012 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>		<b>5,000</b>	<b>(302,685)</b>	<b>150,053</b>	<b>(147,632)</b>

2012 болон 2011 онд хуримтлагдсан ашиг/(хуримтлагдсан алдагдал)-аас бусад нөөц руу шилжүүлсэн дүн нь хэрэгжээгүй ханшийн өөрчлөлтийн зөрүү ба алтны хэрэгжээгүй ашиг алдагдалтай холбоотой болно (Тодруулга-2).

<i>Сая төгрөгөөр</i>	<i>Тодруулга</i>	<i>2012</i>	<i>2011</i>
<b>Тайлант жилийн (алдагдал) / ашиг:</b>		<b>(181,394)</b>	<b>179,632</b>
<b>Тохицуулгууд:</b>			
Алтны дахин үнэлгээний бодит бус олз	22	(15,291)	(14,331)
Гадаад валют хөрвүүлгийн хэрэгжээгүй олз	23	(14,201)	(222,769)
Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн анхлан хүлээн зөвшөөрөлтийн алдагдал	3,12	17,895	-
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн элэгдэл	13	1,800	1,525
Данснаас хассан үндсэн хөрөнгө	13	8	4
Үнэ цэнийн бууралтын нөөц сангийн зардал/ (буцаалт)	24	88,616	(3,536)
Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгө	25	2,000	4,000
Хүүгийн орлого	21	(59,349)	(19,669)
Хүүгийн зардал	21	104,773	118,981
<b>Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		<b>(55,143)</b>	<b>43,837</b>
Алт ба үнэт металлын цэвэр өсөлт		(156,293)	(128,321)
Буцаан худалдан авах хэлцлүүдийн цэвэр өсөлт		(1,353,135)	(149,132)
Гадаадын банкуудад олгосон зээлийн цэвэр бууралт/ (өсөлт)		155	(70)
Дотоодын банкуудад олгосон зээлийн цэвэр бууралт/ (өсөлт)		(59,614)	(209,899)
Засгийн газрын үнэт цаасны цэвэр өсөлт		(1,320)	(98,161)
Бусад хөрөнгийн цэвэр бууралт		922	2,965
Төв банкны үнэт цаасны цэвэр бууралт		(138,009)	(230,656)
Гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөрийн цэвэр өсөлт		471,002	16,057
Төрийн байгууллагуудын харилцах, хадгаламжийн цэвэр өсөлт		1,956,137	15,192
Дотоодын банкуудын харилцах, хадгаламжийн цэвэр бууралт/ (өсөлт)		169,498	(68,632)
Бусад өр төлбөрийн цэвэр бууралт/ (өсөлт)		297	(12,494)
<b>Үйл ажиллагаанаас олсон (үйл ажиллагаанд зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ/ хүүгийн өмнөх</b>		<b>834,497</b>	<b>(819,314)</b>
Хүлээн авсан хүү		53,406	12,418
Төлсөн хүү		(92,493)	(109,680)
<b>Үйл ажиллагаанаас олсон (үйл ажиллагаанд зарцуулсан) нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>795,410</b>	<b>(916,576)</b>
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ</b>			
Үндсэн ба биет бус хөрөнгийн худалдан авалт		(2,574)	(1,966)
Үндсэн ба биет бус хөрөнгө борлуулалтаас хүлээн авсан		138	2
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслүүдийн худалдан авалт		(137,970)	(209,455)
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслүүдийн борлуултаас хүлээн авсан		203,371	1,096,047
Дусгавар хугацаа хүргэл эзэмших санхүүгийн хэрэгслүүдийн борлуултаас хүлээн авсан		-	72,702
<b>Хөрөнгө оруулалтаас олсон цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>62,965</b>	<b>957,330</b>

Хуудас 6-58-т хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайланийн салигүй хэсэг болно

<i>Сая төгрөгөөр</i>	<i>Тодруулга</i>	<i>2012</i>	<i>2011</i>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний өсөлт		115,099	193,659
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		(3,350)	128,828
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт</b>		<b>970,124</b>	<b>363,241</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6	784,074	420,833
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>6</b>	<b>1,754,198</b>	<b>784,074</b>

Хүудас 6-58-т хавсаргасан тодруулжүүд нь энэхүү санхүүгийн тайллангийн салшгүй хэсэг

## 1 Танилцуулга

Төв Банк нь Монгол Улсын Засгийн газрын 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тогтооолоор Монгол Улсын Төв Банк (цаашид “Банк” гэх) болон байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Төв банкны тухай хууль болон бусад хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

Банк нь бүхий л үйл ажиллагаагаа Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулдаг ба орон нутагт нийт 17 салбар болон Англи улсын Лондон хот дахь төлөөлөгчийн газраас өөр үйл ажиллагаагаа явуулдаг салбаргүй болно.

Төв банкны тухай хуульд зааснаар Банк үндсэн зорилгыг Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг хангах болон санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар тэнцвэртэй, тогтвортой үндэсний эдийн засгийн хөгжлийг дэмжих явдал юм.

Банк нь ашгийн төлөө ажилладаггүй. Төрөөс үүсгэн байгуулсан тусгай хуулийн этгээдийн хувьд Банк үйл ажиллагааны санхүүгийн үр дүн болон хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүтэц нь Банк үйл ажиллагаагаар тодорхойлогддог.

Төв банкны тухай хуулийн дагуу Банк нь дараах үндсэн үйл ажиллагаануудыг явуулдаг. Үүнд:

- Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, зохицуулах;
- Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх (“Засгийн газар” эсвэл “Төрийн”);
- Банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, зохицуулах;
- Бусад банкуудын хувьд үндсэн зээлдүүлэгч байх замаар дахин санхүүжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- Бусад орны Төв банкууд, олон улсын банкууд, бусад хамтран ажилладаг хуулийн байгууллагуудын өмнө Монгол улсыг төлөөлж ажиллах;
- Хуулинд заасны дагуу бусад санхүүгийн болон зээлийн үйл ажиллагааг явуулах.

Хуульд заасны дагуу Банк нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нь дэмжих зорилгоор банкуудад зээл олгох, хоёрдогч зах зээл дээр үнэт цаас худалдах ба худалдан авах, гадаад валют, үнэт металл худалдах болон худалдан авах, дотоодын ба гадаадын зах зээл дээр үнэт металл болон энгийн металлаар хийсэн дурсгалын зоосыг худалдах, Засгийн газрын үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах, Засгийн газар болон Сангийн яам (Монгол улсын Засгийн газрын санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага) гэх мэт бусад төрийн байгууллагуудын дансыг Банкинд байршуулах, Олон улсын байгууллагуудын дансыг байршуулан шаардлагатай тохиолдолд дэмжин ажиллах үүрэгтэй болно.

Хуульд заасны дагуу Захирлуудын зөвлөлийн үүрэг нь мөнгөний бодлогын үндсэн зарчмыг тодорхойлж, түүний хэрэгжилтэнд хяналт тавих юм. Үүнээс гадна, Захирлуудын зөвлөлийн Банкны ирэх оны жилийн төсөв болон тухайн жилийн санхүүгийн тайланг батлах, нийтэд тайлагнах болон хуульд заасан бусад үйл ажиллагааг гүйцэтгэдэг.

**Бүртгэгдсэн хаяг ба үйл ажиллагаа явуулжс буй байришил.** Банкны бүртгэгдсэн албан ёсны хаяг нь: Бага Тойруу 3, Улаанбаатар 46, Монгол Улс.

**Тайлагналын мөнгөн нэгж.** Энэхүү санхүүгийн тайлан нь Монгол улсын мөнгөн тэмдэгт болох “Төгрөг”-өөр, саячилсан дүнгээр илэрхийлэгдсэн болно.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

**Тайлан бэлтгэх үндсэлэл.** Эдгээр санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу, санхүүгийн хэрэгслүүдийг анхлан бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх, мөн борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийг дахин үнэлж бүртгэхээс бусад тохиолдолд түүхэн өргөөр бүртгэх зарчмыг баримтлан бэлтгэгдсэн. Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан nyaгтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг дор толилуулав. Өөрөөр заагаагүй бол тус бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үе бүрт туштай хэрэгжүүлсэн болно (Тодруулга 4-ийг харна уу).

**Санхүүгийн хэрэгслүүд – гол нэр томъёо.** Санхүүгийн хэрэгслүүдийн ангилалаас хамааран тэдгээрийг дор тайлбарласны дагуу бодит үнэ цэнэ, өргөөр эсвэл хорогдуулсан өргөөр бүртгэлд тусгадаг.

**Бодит үнэ цэнэ** нь мэдлэг бүхий холбоогүй талууд сайн дураараа хоорондоо хөрөнгө солилцох эсвэл өр төлбөр барагдуулахад бэлэн буй үнийг хэлнэ. Бодит үнэ цэнэ нь санхүүгийн хөрөнгийн хувьд идэвхитэй зах зээл дээр зарласан өнөөгийн худалдаж авах үнэ, санхүүгийн өр төлбөрийн хувьд өнөөгийн худалдах үнэ болно. Хоорондоо саармагжих зах зээлийн эрсдэл бүхий хөрөнгө болон өр төлбөрийн хувьд Банк бодит үнэ цэнийг тогтоохдоо хоорондоо хаагдах хэсэгт зах зээлийн дундаж үнийг ашиглаж цэвэр буюу нээлттэй позицийн хувьд худалдах эсвэл худалдан авах үнийг зохих ёсоор ашиглаж болно. Санхүүгийн хэрэгслүүдийн үнэ нь хөрөнгийн зах зээл эсвэл бусад байгууллагаас тогтмол нийтэд зарлагдах буюу бэлэн олдох боломжтой бөгөөд эдгээр үнээр зах зээл дээр холбоогүй этгээд хооронд бодит гүйлгээ тогтмол хийгддэг тохиолдолд санхүүгийн хэрэгслүүдийг идэвхитэй зах зээл дээр санал болгосон гэж үнэ.

Зах зээлийн үнийн талаар мэдээлэл олдохгүй тохиолдолд зарим санхүүгийн хэрэгслүүдийг тэдгээрийн бодит үнэ цэнийг санхүүжигч талын санхүүгийн мэдээлэл дээр үндэслэн хямдруулсан мөнгөн гүйлгээний үнэлгээний загвар эсвэл үнэлгээний бусад аргачлалыг ашиглаж тооцно. Үнэлгээний аргачлалуудад зах зээлийн нээлттэй мэдээлэлд тулгуурлах боломжгүй үед таамаглалыг ашигладаг. Хэрэв тус санхүүгийн тайлангуудад таамаглал ашигласан бөгөөд уг таамаглалыг зохистой хэмжээгээр өөрчилсөөр ашиг, орлого, нийт хөрөнгө эсвэл нийт өр төлбөрийн дүнгүүд мэдэгдэхүйц хэмжээгээр өөрчлөгдөх тохиолдолд холбогдох тодруулгыг хийсэн болно.

**Өртөг** нь хөрөнгийг худалдаж авахад төлсөн мөнгө болон түүнтэй адилтгах зүйл эсвэл тухайн хөрөнгийн зах зээлийн үнээр илэрхийлэгдэх бөгөөд үүнд гүйлгээний зардлуудыг багтааж тооцдог.

**Өртгийн** тооцоолол нь зах зээл дээр тодорхой жишиг үнэгүй буюу үнэ цэнийг нь бодитойгоор тодорхойлох боломжгүй хөрөнгөд хийсэн хөрөнгө оруулалтыг хэмжих үед ашиглагддаг. (дэлгэрэнгүй Тодруулга 8-аас үзнэ үү).

**Гүйлгээний зардлууд** нь санхүүгийн хэрэгслүүдийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулалттай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардлыг хэлнэ. Гүйлгээний зардалд зуучлагч, борлуулагч зуучлагч үүрэг гүйцэтгэж буй ажилтнууд, зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах агентлаг, хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөрүүд, мөн шилжүүлэлтэнд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт буюу урамшуулал, санхүүгийн зардлууд, дотоодын удирдлагын буюу хадгалалтын зардлууд орохгүй.

**Хорогдуулсан өртөг** гэдэг нь санхүүгийн хэрэгслүүдийг анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн төлбөрөөр эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анхлан хүлээн зөвшөөрсөн урамшууллын хойшлогдсон гүйлгээний зардал, мөн хөнгөлөлтийн дүнг үр ашигт хүүгийн аргаар тооцсон хямдруулалт орно. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан үүпон болон үнийн хямдруулсан урамшуулал буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн тайлан дахь тэнцэлд хамаарах хэсэгт бүртгэлийн үнээр тусгасан болно.

**Үр ашигт хүүгийн арга** нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үнээс тооцодох хүүгийн хувийг тогтмол байглахаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэгслүүдийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид хямдруулж санхүүгийн хэрэгслүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүгийн хувь болно. Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэгслүүдийн мөнгөн ургалын хүүг өөрчлөх дараагийн мөч хүргэл хямдруулах боловч хэрэгсэлд тусгагдсан хөвөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хөнгөлөлтийг хэрэгслүүдийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хямдруулна. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд төлөх эсвэл хүлээн авах бүх хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

**Санхүүгийн хэрэгслүүдийг анхлан хүлээн зөвшөөрөх.** Дериватив санхүүгийн хэрэгслүүд нь анх бодит үнэ цэнээр бүртгэгдэнэ. Бүх санхүүгийн хэрэгслүүд нь анх бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардал нэмсэн дүнгээр бүртгэгддэг. Гүйлгээ хийсэн үнэ нь анх бүртгэх бодит үнэ цэнийг баталгаажуулах нотолгоо болно. Анх бүртгэх үед үүсэх олз эсвэл гарзыг бодит үнэ цэнэ болон гүйлгээний үнийн хооронд зөрүү гарсан тохиолдолд л хүлээн зөвшөөрөх бөгөөд үүнийг зөвхөн гүйлгээний зардлыг тооцоохдоо ижил төрлийн хэрэгслүүдийг зах зээлийн нээлттэй мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн нээлттэй зах зээлээс авсан мэдээлэл дээр үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдлуудад хүлээн зөвшөөрнө.

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон (“хэвийн” худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л борлуулалт болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу Банк тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг Банк санхүүгийн хэрэгслүүдийн гэрээний тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах.** Банк санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ Банк бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцож (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй тохиолдолд. Холбогдох тал хөрөнгийн борлуулалтанд нэмэлт хязгаарлалт хийлгүйгээр холбоогүй гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

**Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.** Гадаад болон дотоод хөрвөх чадварын өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд тусгах зорилгоор тодорхой хэмжээний мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнэ алдах эрсдэл багатай зүйлийг багтаадаг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд богино хугацааны мэдэгдлээр зарцуулж болох гурван сараас бага хугацаатай байршуулсан хугацаатай хадгаламж болон хугацаагүй хадгаламжаар санхүүгийн хөрөнгө болон төгрөгөөр илэрхийлэгдсэн төрийн байгууллагууд, дотоодын банкуудын хугацаагүй хадгаламж орох ба үүнийг Тодруулга 6-аас харна уу. Зарцуулалтад хязгаарлалт хийснээс эсвэл хөрвөх чадвар муутайгаас шууд хөрвөдөгүй санхүүгийн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулаагүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн аргаар хямдруулсан өртгөөр бүртгэнэ.

**Алт болон үнэт металлууд.** Олон улсын стандартын дагуу алт болон үнэт металлыг гадаадын банкинд алтан болон мөнгөн гулдмай хэлбэрээр хадгалдаг. Байршуулсан алт нь олон улсын нөөцийн нэгээхэн хэсгийг илэрхийлнэ. Эдгээр металлууд нь трой үнцаар хэмжигдэн бүртгэгдэх ба Банкны албан ханшаар үнэлгэдэн төгрөгөөр илэрхийлэгдэнэ. Алтны арилжааны албан ханшигийг Лондонгийн Алтны Захын Холбооноос зарласан үнэт металлын ам долларын ханшид тулгуурлан, Банкны зарласан төгрөг-ам долларын харьцах ханшаар хөрүүлж төгрөгөөр илэрхийлдэг. Банк нь алтыг ийм байдлаар эзэмшихээс гадна Монгол дахь үйлдвэрлэгч, аж ахуй нэгжүүдээс цэвэршүүлээгүй алтыг худалдан авч, цэвэршүүлсний дараа гадаад зах зээлд худалддаг. (Тодруулга 10-ээс харна уу).

Алтыг бодит үнэ цэнээр нь санхүүгийн байдлын тайланд тусгах бөгөөд дахин үнэлгээг өдөр бүр хийдэг. Бодит үнэ цэнийг тогтоохдоо алтны зах зээлийн үнийг харгалzan үздэг. Дахин үнэлгээний олз гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бодит бус ашиг алдагдлыг жилийн эцэст хуримтлагдсан ашгаас өөрийн хөрөнгө дэх бусад нөөцийн “Үнэт металлын үнэлгээний нөөц” -рүү хаана.

Бусад үнэт металл (алт, бусад хольц металл болон гулдмай, мөнгөний хүдэр), зоос болон соёлын үнэт зүйлсийг Банк Эрдэнэсийн санд хадгалдаг. Бусад үнэт металлыг бараа материалаар бүртгэж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

**Гадаадын валютын ханиши хөрвүүлэг.** Банкны үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “Монгол төгрөг” юм. Мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг гүйлгээ хийсэн өдрийн ханшаар буюу Банкны албан ханшаар мөнгөн нэгж хөрвүүлж бүртгэх ба үүнээс хойш албан ханш өөрчлөгдхөх тухай бүр дахин үнэлнэ. Тайлант хугацааны эцэст гадаад валютаар мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тайлант хугацааны өдрийн албан ханшаар төгрөг рүү хөрвүүлэн бүртгэнэ.

Гадаад валютаар мөнгөн бус хөрөнгө нь түүхэн өртөг (тухайн хөрөнгийг худалдаж авсан өдрийн Монгол төгрөгийн гадаад валюттай харьцах ханшаар үнэлнэ) эсвэл хамгийн сүүлд хөрвүүлсэн бодит үнэ цэнийг тооцсон дахин үнэлгээгээр бүртгэгддэг.

Мөнгөөр илэрхийлэгдэх гадаад валютын тэнцлийн үлдэгдлийг төгрөгт хөрвүүлэхэд ашигласан албан ханшийг дор харуулав:

	2012.12.31 (Төг)	2011.12.31 (Төг)
1 ам.доллар	1,392.10	1,396.37
1 (SDR) Зээлжих тусгай эрх	2,145.90	2,137.00
1 евро	1,835.83	1,806.76

**Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө.** Банк харилцагч банк руу арилжааны бус зорилгоор мөнгө шилжүүлснээр хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдээгүй, дериватив бус, тусгайлан заасан буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх авлага үүсэх үед бусад банкуудад байршуулсан хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Эдгээр нь СТОУС-ын дагуу зээл ба авлага хэмээн ангилагддаг. Бусад банкуудад байршуулсан хөрөнгийг анх бүртгэхдээ бодит үнэ цэнэ дээр нь гүйлгээний өртгийг нэмэх ба түүнээс хойш үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

**Банкуудад олгосон зээл болон Засгийн газрын үнэт цаас.** Банк харилцагчдаасаа хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдээгүй, дериватив бус авлагыг тусгайлан заасан буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх, цааш нь арилжих зорилгогүйгээр мөнгө шилжүүлсэн үед, Банкууд болон бусад харилцагчдад (жишээ нь Сангийн яам) олгосон зээлийг хүлээн зөвшөөрнө. Эдгээр нь (Сангийн яамнаас гаргасан Засгийн газрын үнэт цаасыг багтаан) СТОУС-ын дагуу зээл ба авлага хэмээн ангилагддаг. Бусад банкуудад байршуулсан хөрөнгийг анх бүртгэхдээ бодит үнэ цэнэ дээр нь арилжааны өртгийг нэмж хүлээн зөвшөөрөх ба түүнээс хойш үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

**Зээлдүүлсэн үнэт цаас ба худалдах, буцаан худалдан авах хэлцлүүд.** Харилцагч этгээдэд зээлдэгч буцаан төлөхөөр олгогдог худалдах буцаан худалдан авах хэлцэл (“репо хэлцэл”)-ийг баталгаажсан санхүүгийн гүйлгээ гэж үздэг. “Репо”-ийн дор худалдсан үнэт цааснуудыг санхүүгийн байдлын тайлангаас хүлээн зөвшөөрдөггүй. Харин хөрөнгө хүлээн авагч гэрээний дагуу тус хөрөнгийг борлуулах болон барьцаанд тавих эрхтэй үед тус хөрөнгийг “Буцаан худалдан авах хэлцлүүд” гэж санхүүгийн байдлын тайланд бүртгэх ба эдгээрийг дахин ангилдагуй.

Зээлдэгчээс Банкинд эргэн төлөхөөр олгосон эргүүлэн худалдах хэлцлийн дагуу худалдан авсан үнэт цаас (“урвуу репо хэлцэл”)-ийг гадаад байгууллагаас авах авлага эсвэл дотоодын банкинд олгосон зээлийн аль тохиromжтойгоор нь бүртгэнэ. Худалдан авсан болон буцаан худалдах үнийн зөрүүг хүүгийн орлого гэж хүлээн зөвшөөрөх ба үр ашигт хүүгийн аргыг ашиглан “репо” гэрээний хугацааны турш хуримтлуулна.

**Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт.** Санхүүгийн хөрөнгийг анх бүртгэнээс хойш тохиосон нэг буюу олон үйл явдлын (“гарз учруулсан үйл явдлууд”) үр дүнд санхүүгийн дан ганц эсвэл бүлэг хөрөнгөөс ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын хэмжээ өөрчлөгдсөн бөгөөд үнэн зөв тооцох боломжтой тохиолдолд тайлант жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын бодит нотолгоог тодорхойлоход дараах гарз учруулах үйл явдлуудын мэдээлэл багтана:

- зээлдэгч санхүүгийн мэдэгдэхүйц хүндрэлд орсон;
- зээлдэгч нь гэрээгээ зөрчсөн;
- зээлдэгч дампуурлаа зарлах буюу бусад санхүүгийн бүтцийн өөрчлөлт хийх магадлалтай;
- зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй холбоотойгоор үйл ажиллагаа явуулж буй эсвэл тухайн хөрөнгийн зориулалтын зах зээлд тайлант болон ойрын хугацаанд байгууллагад сөрөг нөлөө учруулж болохуйц зах зээл, эдийн засаг, хууль эрх зүйн орчны ихээхэн хэмжээний өөрчлөлтүүд орох (жишээ нь, хүүгийн хувийг өөрчлөх эсвэл эргэн төлөгдөх хугацааг сунгах гэх мэт);
- анхлан хүлээн зөвшөөрөлтөөс хойш бүлэг санхүүгийн хөрөнгөөс орж ирээдүйн мөнгөн урсгал хэмжигдэхүйц буурсныг тодорхойлох мэдээлэл.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Банк харьцангуй цөөхөн зээлдэгчид (харилцагч болон бусад зээлдэгчидтэй)-тэй учир санхүүгийн хөрөнгийг нэг бүрчлэн үнэлдэг. Жишээ нь: Банк бүх авлага болон бусад санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг үнэлдэг.

Үнэ цэнийн бууралтын алдагдлыг хөрөнгийн анхны үр ашигт хүүгээр хямдруулан хүлээгдэж буй мөнгөн ургалын өнөөгийн үнэ цэнэ (зардлаар хүлээн зөвшөөрөгдөөгүй ирээдүйн зээлийн алдагдлыг оруулахгүй) хүртэл хасагдуулгын дансаар хүлээн зөвшөөрдөг. Үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа үнэ цэнийн бууралтын хэмжээ багасвал энэхүү бууралт нь үнэхээр дараа тайлант үед илэрсэн нь тогтоогдсоныг нягтлаж өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасагдуулгын дансаар орлого зарлагаар тайлант онд буцаалт хийж тохируулна.

Хэрэв үнэ цэнэ буурсан хөрөнгийн нөхцлийг өөрчлөн дахин тохиролцсон эсвэл нөхцлүүдийг зээлдэгч санхүүгийн байдал муудсанаас өөрчилсөн тохиолдолд үнэ цэнийн бууралтыг нөхцөл өөрчлөгдөхийн өмнөх үр ашигт хүүг ашиглан тооцно. Хөвөгч хүүтэй зээл гаргасан тохиолдолд үнэ цэнийн бууралтыг тухайн үеийн үр ашигт хүүг ашиглан тооцно.

Эргэн төлөгдөх боломжгүй болсон хөрөнгийг данснаас хасахдаа хөрөнгийг нөхөн төлүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авсны дараа үнэ цэнийн бууралтын санг хаана.

**Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас.** Банк тодорхой бус хугацаагаар эзэмшиж буй өрийн үнэт цаас, өмчөөрх хөрөнгө оруулалтыг (охин компани эсвэл хараат компани биш компанийн санд оруулсан хөрөнгө оруулалт) борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтад багтана. Өрийн үнэт цаасыг анх бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг оруулсан дунгээр хүлээн зөвшөөрдөг ба үүний дараа бодит үнэ цэнээр бүртгэнэ. Өрийн үнэт цаасыг борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн арга ашиглан тухайн тайлант хугацаанд орлогын тайланд тусгана. Бусад бүхий л бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Энэ нь хуримтлагдсан олз эсвэл гарзыг бусад дэлгэрэнгүй орлогын тайллангаас тухайн тайлант үеийн орлогын тайланд шилжүүлсэн үед данснаас хасах эсвэл үнэ цэнэ буурах хүртэл үргэлжилнэ.

Өмчөөрх хөрөнгө оруулалтыг анхны өртгөөр хүлээн зөвшөөрдөг ба түүний дараа өртгөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр тусгадаг. Энэ өртөг нь хөрөнгө оруулалтын дүнг хангалттай тодорхойлж чадахгүй болно. Тодруулга 8-аас харна уу.

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрсний дараа тохиосон нэг буюу олон үйл явдлын (“гарз учруулсан үйл явдлууд”) үр дүнд үүссэн үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрнө. Өмчийн хэрэгслийн бодит үнэ цэнэ түүний өртгөөс доош их хэмжээгээр буюу үргэлжлэн буурах нь тухайн хэрэгсэл үнэ цэнээ алдсаны шинж тэмдэг болно. Худалдан авах өртөг болон тухайн үеийн бодит үнэ цэнийн зөрүү болох хуримтлуулсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг бусад дэлгэрэнгүй орлогоос орлогын тайланд ашиг алдагдлаар тусгана.

**Дериватив санхүүгийн хэрэгслүүд.** Дериватив санхүүгийн хэрэгсэлд дотоодын банкуудтай хийсэн гадаад валютын форвард хэлцэл гэх мэт гадаад валютын хэлцлүүдийг голдуу оруулна. Бүх дериватив санхүүгийн хэрэгслүүд бодит үнэ цэнэ нь зөрөг бол хөрөнгөөр, сөрөг тохиолдолд өр төлбөрөөр тусгагдана. Бодит үнийн өөрчлөлтийг тухайн жилийн орлого, зарлагаар хүлээн зөвшөөрнө. Банк хеджийн нягтлан бodoх бүртгэлийг хөтөлдөггүй.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

**Бусад хөрөнгө.** Бусад хөрөнгө нь голдуу авлага болон урьдчилж төлсөн зардлаас бүрдэнэ. Авлага нь аккруэл сууриар хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Авлагыг гэрээний дагуу эрх үүссэн үед хүлээн зөвшөөрнө. Урьдчилж төлсөн зардлыг төлбөр хийгдсэн үед хүлээн зөвшөөрч тухайн ажил үйлчилгээ нь хийгдсэний дараа дэлгэрэнгүй орлогын тайландаа бүртгэнэ. Хэрэв Банкинд тухайн авлага нь төлөгдөхгүй гэдгийг батлах хангалттай нотолгоо бий бол, найдваргүй авлагын санг байгуулах ба авлагын дүнгээс эргэн төлөгдөхгүй хэмжээг тооцож, тус санг авлагын дүнг эргэн төлөгдөх боломжтой хэмжээ хүртэл нь бууруулна. Үнэ цэнийн бууралтыг орлогын тайландаа хүлээн зөвшөөрнө. Банк авлагын үнэ цэнийн бууралтыг хорогдуулсан өртгөөр бүртгэдэг бусад санхүүгийн хөрөнгийг үнэлдэг аргаар тодорхойлно.

**Байшин барилга болон үндсэн хөрөнгө.** Барилгыг дор дурдсанчлан дахин үнэлэгдсэн өртгөөс хуримтлагдсан элэгдлийг, мөн шаардлагатай бол үнэ цэнэ бууралтын зардлыг хассан дүнгээр тусгадаг.

Банк эзэмшиж буй барилгыг анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Барилга байгууламжийн дансны үнэ нь бодит үнээс материаллаг зөрүүтэй эсэхийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлнэ. Дансны үнэ дахин үнэлгээгээр нэмэгдсэн тохиолдолд нэмэгдсэн дүнгээр бусад дэлгэрэнгүй орлогыг болон өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний санг нэмэгдүүлнэ. Тухайн хөрөнгийн өмнө үүссэн нэмэгдлийг хааж буй дахин үнэлгээний бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөд өмнө хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нөөцийг бууруулна; харин бусад бүх бууралтыг (илүү гарсан бүхий) тухайн жилийн орлого зарлагад хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлгээгээр нэмэгдсэн дүн бодитоор хэрэгжих үед барилга байгууламжийн дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан алдагдал эсвэл хуримтлагдсан ашигт шууд хаана. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр барилга байгууламжийн дансны үнэ бодит үнэ цэнээс материаллаг зөрүүтэй байгаагүй гэж Удирдлага үзэж байна.

Банк эзэмшиж буй тоног төхөөрөмжийг үнэ цэнэ бууралтын алдагдал болон элэгдлийг өртгөөс хассан дүнгээр бүртгэнэ. Үргэлж засварын зардлыг гарсан тухайн үед зарлагадна. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн аль нэг бүрэлдэхүүн хэсгийг сольсон томоохон зардлыг капиталжуулж, сольсон хэсгийг ашиглалтаас хасна.

Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг удирдлага тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Ийм шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдлага хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль ихээр нь нөхөх өртгийг тооцож, дансны үнийг нөхөх өртөг хүртэл бууруулан гарзыг тухайн жилийн орлого, зарлагад бүртгэдэг (хэрэв тухайн өөрийн хөрөнгө дэх хөрөнгийн дахин үнэлгээний сангийн дүнгээс давсан тохиолдолд). Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ, бодит үнэ цэнэ эсвэл борлуулах өртгийн тооцоололд өөрчлөлт орсон бол өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах бичилт хийнэ.

Олз, гарзыг тодорхойлоходо борлуулалтаас олсон орлогыг бүртгэлийн дүнтэй харьцуулж тооцох ба олз, гарзыг тухайн жилийн орлого, зарлагад бүртгэнэ (бусад үйл ажиллагааны орлого, зардлын хэсэгт).

**Элэгдэл.** Дуусаагүй барилгыг элэгдүүлэхгүй. Үндсэн хөрөнгийн бусад зүйлүүдийн элэгдлийг тэдгээрийн өртгийг доор тооцоолсон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь элэгдүүлнэ:

### Ашиглалтын хугацаа, жилээр

Барилга	25 – 60 жил
Тавилга, оффисын тоног төхөөрөмж	8 – 10 жил
Компьютер, тоног төхөөрөмж	5 – 10 жил
Тээврийн хэрэгсэл	6 – 8 жил

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Ашиглалтын хугацаа нь дуусч байгаа хөрөнгийг Банк тухайн үед борлуултаас олох боломжтой үнээс борлуулалтын зардлыг хассан дүнгээр үлдэх өртгийг тооцдог. Хөрөнгийн үлдэгдэл өртөг, ашиглаглалтын хугацааг тайлант үе бүрийн эцэст дахин үнэлж шаардлагатай гэж үзвэл тохируулга хийнэ.

**Биет бус хөрөнгө.** Банк биет бус хөрөнгө нь тодорхой ашиглалтын хугацаатай ба капиталжуулсан компьютерын програм хангамжийн лицензүүд үүнд багтсан байна.

Худалдаж авсан компьютерийн програм хангамжийн лицензүүдийг авч ашиглахад бэлэн болгоход гарсан зардлаар бүртгэлд тусгасан.

Биет бус хөрөнгүүдийг тэдгээрийн ашиглаглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулна:

### Ашиглалтын хугацаа, жилээр

Компьютерийн програм хангамж (үндсэн банкны програм)

3 жил

**Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө.** Гүйлгээн дэх бэлэн мөнгө ба зоосны хэмжээ нь 1993 оны 9 дүгээр сард Банкнаас нэвтрүүлсэн төлбөр тооцоог гүйцэтгэхэд хэрэглэгдэж буй цаасан мөнгөн тэмдэгт болон зоосны нэрлэсэн үнэ цэнээр илэрхийлнэ. Банк бусад банкууд болон харилцагчиддаа бэлэн мөнгө олгох үед гүйлгээн дэх бэлэн мөнгө ба зоосыг нэрлэсэн үнээр өр төлбөр болон бүртгэгдэнэ. Банк бэлтгэл сан болон гүйлгээний касст буй төгрөгийн бэлэн мөнгийг гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөнд оруулж тооцохгүй.

**Төв Банкны үнэт цаас.** Банкны гаргасан үнэт цаас нь бодит үнэ цэнээрээ анх бүртгэгдэх ба түүнээс хойш хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо эдгээрийг гаргах эсвэл үүсэх үеийн хөнгөлөлт эсвэл урамшуулал, үр ашигт хүүг бүрдүүлж буй зардлуудыг авч үзнэ.

**Зээл.** Банк авсан зээлээ үр ашигт хүүгийн аргаар, хорогдуулсан өртгөөр нь бүртгэдэг ба эдгээр зээлүүд нь Герман Улсын Засгийн газар (KfW), Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтийн хөтөлбөртэй холбоотойгоор Сангийн яамнаас авсан урт хугацаат зээлүүдийн өр төлбөр хэсэгт Төрийн байгууллагад өгөх өглөг хэмээн бүртгэгдсэн болно (Тодруулга 16-аас харна уу). Мөн зээлд HSBC банкнаас авсан зээл хамаарах ба Гадаадын этгээдэд төлөх өр төлбөр (Тодруулга 18-аас харна уу).

**Гадаадын этгээдэд төлөх өр төлбөр.** Гадаадын этгээдэд төлөх өр төлбөр нь бодит үнэ цэнээрээ анх бүртгэгдэх ба түүнээс хойш үр ашигт хүүгийн аргаар, хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг (Тодруулга 18-аас харна уу).

**Төрийн байгууллагуудад өгөх өглөг.** Засгийн газар болон Бусад Төрийн байгууллагуудын дансанд нь Засгийн газар болон бусад харилцагчдад төлөх дериватив бус өр төлбөр ба хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

**Дотоодын банкнуудын хадгаламж.** Банкинд харилцагч банкуудаас мөнгө шилжин орж ирэхэд нь дотоодын банкнуудын хадгаламжийг хүлээн зөвшөөрдөг. Дериватив бус өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

**Өр төлбөр болон зардлын сан.** Энэ нь цаг хугацаа ба дун нь тодорхойгүй санхүүгийн бус өр төлбөр юм. Банкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн хууль зүйн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага байгаа бөгөөд энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн үр ашиг бүхий баялгийг зарцуулах нь тодорхой болсон үед санг байгуулах ба үүргийн дүнг бодитой ойролцоотойгоор тооцоолох боломжтой болно.

**Худалдааны болон бусад өглөг.** Харилцагч талаас үзүүлэх ажил үйлчилгээгээ гэрээний дагуу үзүүлсэн тохиолдолд худалдааны өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрнө.

**ОУВС-д оруулсан хувь хөрөнгө.** Хувь хөрөнгийн дун нь Монгол улс ОУВС-гийн гишүүн байгууллагын зүгээс хөрөнгө нийлүүлсний илтгэх онцгой төрлийн хөрөнгө юм. Хувь хөрөнгө нь тухайн орны эдийн засгийн цар хүрээнээс хамаараад янз бүр байх тул ОУВС-гийн Гүйцэтгэх Зөвлөлөөс энэхүү хувь хөрөнгийн хэмжээг тогтоодог. Квот нь тухайн гишүүн орны Санд өгөх саналын эрх, Сангийн санхүүгийн эх үүсвэрт тавигдах хязгаарлалт болон гишүүдийн ЗТЭ-ийн хуваарилалтын хэмжээг тодорхойлдог. Монгол улсын хувь хөрөнгийн дийлэнх хэсгийг Сангийн яам хүүгүй өрийн бичиг гарган төлсөн ба үлдсэн хэсэг нь ОУВС-гийн 1 ба 2-р дансуудад байгаа болно (Тодруулга 18 харна уу). 2012 оны 12 дугаар сарын 31-нээр ОУВС дахь Монгол улсын хувь хөрөнгийн үлдэгдэл нь 51.1 сая ЗТЭ (2011 онд 51.1 сая ЗТЭ). Энэхүү дүнд хэсэгчлэн төлөх нөхцөлд (tranche) нөөцийн 0.14 сая ЗТЭ (2011 онд 0.14 сая ЗТЭ) ба энэ нь Банкны хөрөнгө юм. Тус хөрөнгөд хүү тооцдоггүй. Сангийн яамнаас ОУВС-д оруулсан хувь хөрөнгийг төлөхөөр гаргасан хүүгүй өрийн бичиг нь Сангийн яамны хөрөнгө гэж бүртгэнэ.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

**ОУВС-аас гаргасан үнэт цаас.** Энэхүү дүн нь ОУВС-ийн төгрөгөөр ЗТЭ-ийн хуваарилалтыг илтгэх бөгөөд үүнд, дээр тайлбарласан хувь хөрөнгийг төлөхөд гаргасан өрийн бичиг (ЗТЭ-ийн хуваарилалт багтана. Жишээ нь “Стэндбай” хөтөлбөрийн санхүүжилтийг олж авахад гаргасан өрийн бичиг.

“Стэндбай” хөтөлбөр нь Монгол улсын эдийн засгийг тогтвортжуулах зорилгоор ОУВС-ын олгосон жилийн 1 хувийн хүү дээр ЗТЭ-ийн түвшинг нэмсэнтэй тэнцэх хэмжээний хүүтэй зээл юм. Уг зээлийг 18 сарын хэлцлээр олгосон ба хөтөлбөрийн гүйцэтгэл, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн хяналт зэргийг харгалzan үзнэ. Зээл болон түүний эргэн төлөлтийг ЗТЭ-ээр хийдэг.

Ядуурлыг бууруулж өсөлтийг хурдаасах хөтөлбөр (“ЯБӨХХ”) -ийн зээл нь ОУВС-аас 10 жилийн хугацаатай, жилийн 0.5 хувийн (2011 онд 0.5 хувь) хүүтэйгээр Монгол Улсын Засгийн газарт олгогдсон. Уг зээлийг 3 жилийн хэлцлээр олгосон бөгөөд хөтөлбөрийн гүйцэтгэл, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн хяналт зэргийг харгалzan үзнэ. Зээлийн эргэн төлөлт ЗТЭ-ээр хийгдэх ба Сангийн яам Засгийн газрын хэрэгжүүлэгч агентын хувьд энэхүү зээлд үүрэг хүлээж байгаа.

Тайллангийн хугацааны эцэст хөрөнгө болон өр төлбөрөөр илэрхийлэгдсэн ЗТЭ-ийг Банкны төгрөгийн албан ханшаар шилжүүлэн тайлагнана. ЗТЭ-ийн Банкны төгрөгийн албан ханшийг тооцоходо ОУВС-ийн ам долларыг төгрөгт шилжүүлэх мэдээлэл болон Банкны ам долларыг төгрөгөөр солилицох ханшаар хөрвүүлж тайлант хугацаанд тайлагнана.

ЗТЭ-ийг ашиглахтай холбогдон гарсан зээлийн хүүгийн зардлыг хүүгийн зардал болон ЗТЭ-ийг ашигласантай холбогдон олсон зээлийн хүүгийн орлогыг дэлгэрэнгүй орлогын тайланд холбогдох мөрийн дагуу тайлагнана.

**Дүрмийн сан.** Дүрмийн сан нь төрийн өмч гэж ангилагддаг. Тодруулга 20-оос харна уу.

**Ерөнхий нөөцийн сан.** Ерөнхий нөөцийн санд Банкны тодорхой хугацааны туршид хуримтлуулсан Банкны өөрөө зарцуулах бүрэн эрхтэй цэвэр ашгийг агуулдаг. Энэ санд Улсын төсөвт хуваарилсан ба цаашид хуваарилах дунг оруулдаггүй, учир нь эдгээр нь Засгийн газарт тухайн жилдээ багтаж шилждэг. Тодруулга 20-оос харна уу.

**Бусад нөөц.** Бусад нөөцдөд бодит бус ханшийн олз/гарз, мөнгөжсөн алт болон үнэт металлын (мөнгө) дахин үнэлгээний олз/гарз, нөөцийн дахин үнэлгээ (барилга байгууламжтай холбоотой) болон борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын нөөцийн санг оруулдаг. Тодруулга 20-оос харна уу. Банк өөрсдийн бодлогынхoo дагуу орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн бодит бус ханшийн олз, гарз болон мөнгөжсөн алт, үнэт металлын (мөнгө) дахин үнэлгээний олз/гарзыг бусад нөөцдөд жил бүрийн эцэст шилжүүлдэг.

**Цэвэршүүлэлт.** Цэвэр санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн цэвэр дүнгээр хөрөнгө ба өр төлбөрийн аль зохицтой талд бүртгэгдэх хууль зүйн эрх байгаа бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь хааж, үлдэх дүнг тайланд тусгана.

**Зээлтэй холбоотой үүрэг хариуцлага.** Банкинд зээлтэй холбоотой үүрэг хариуцлага байгаа бөгөөд үүнд аккредитив болон Хятадын Ардын банк (БНХАУ-ын Төв Банк, цаашид “ХАБ” гэх) –тай байгуулсан хэлэлцээр орно. Хэлэлцээр нь ХАБ-аас Банкинд юаниар олгосон зээлийн хэрэгсэл ба Банкнаас ХАБ-д төгрөгөөр олгосон зээлийн хэрэгсэл юм. (Тодруулга 26-г харна уу). Тайлант жилийн эцэст төлбөрийн үүрэг хариуцлагыг дуусгавар болгоход шаардагдах мөнгөний бодитой таамаглал хоёрын аль ихээр нь хэмжигддэг. Хэрэв дуусгавар болгоогүй төлбөрийн үүрэг хариуцлагын дунд хураамж төлдөг бол энэ нь тухайн үүргийн хүчинтэй хугацааны турш орлого болгон хүлээн зөвшөөрнө.

**Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт.** Хүүгийн орлого, зардлыг өрийн хэрэгсэл бүрийн хувьд аккруэл суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ арга нь талуудын хооронд гэрээний дагуу төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардал болгон бүртгэдэг.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг аккруэл суурь дээр үндэслэн тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт тохирсон үйлчилгээнээс бодитоор үзүүлсэн байгаа үйлчилгээний хувь хэмжээгээр тооцдог.

**Бэлэн мөнгө гаргахтай холбогдоон гарах зардлууд.** Банк нь Монгол улсын цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосыг гүйлгээнд гаргадаг. Цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосыг гүйлгээнд гаргахтай холбоотой урьдчилж гарсан зардал нь “Бусад хөрөнгө” хэсэгт бүртгэгдэх ба тэдгээр нь үйлдвэрлэлээс Банкны нөөц санд шилжих үед “Зардал” болгон бүртгэнэ.

**Ажилтны зардал болон холбогдох шимтгэлүүд.** Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг Банк ажилтнуудад холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд хүлээн зөвшөөрдөг. Цалинтай ээлжийн амралт, нөхөн олговортой бусад богино хугацаат чөлөө авалтыг, ажилтнуудад ирээдүйд нөхөн олговортой чөлөө авах эрхийг үүсгэх үйлчилгээг үзүүлсэн үед, харин нөхөн олговортой богино хугацаат (жишээ нь: өвчний улмаас чөлөө авах) чөлөө авах үед тус бүрд хүлээн зөвшөөрдөг.

**Удаан жил ажилласан ажилтан тэтгэвэр, тэтгэмж.** Банкны дотоод журамд үндэслэн Банк ажилтандaa тэтгэвэрт гарах үед нь (тэтгэвэрт гарахаас өмнө Банкинд хэр удаан ажилласнаас шалтгаалан) цалингийн тодорхой тогтоосон хэмжээг олгох үүрэгтэй. Зарим холбогдох төлбөрүүдийг Нийгмийн хөгжлийн санд оруулсан байдаг (Тодруулга 19-өөс харна уу). Удирдлага нь Нийгмийн хөгжлийн сан нь 2011 оны 12 дугаар сарын 31-нээс 2012 оны 12 дугаар сарын 31-ний хугацаанд богино болон урт хугацаат төлбөрүүдийг (Нийгмийн хөгжлийн сан нь үүнд зориулан байгуулагдсан болно) бүрэн төлөх боломжтой хэмээн үзэж байна. Мөн тэтгэвэрийн олгогдсон бодит хэмжээ нь тайланд тусгагдсан тэтгэвэр тэтгэмжийн төлвлөл зохих хэмжээнээс хүлээн зөвшөөрөгдөөгүй бодит олз/гарз болон гарсан үйлчилгээний зардлыг хассан дүнгээс материаллаг хэмжээгээр зөрөхгүй гэж итгэж байна.

**Орлогын албан татвар.** Монгол улсын эдийн засгийн байгууллагын тухай болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулинд зааснаар, Банк нь орлогын албан татвараас чөлөөлгэдсөн байдаг.

**Санхүүгийн позицийг хөрвөх чадварын дагуу тайлагнах нь.** Банк нь үйл ажиллагааны үе шатуудыг дэлгэрэнгүй тодорхойлгүй ба санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийг тусад нь тайлagnадагтүй. Харин, хөрөнгө өр төлбөрийг хөрвөх чадварын дагуу тайлagnадаг.

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Доорх хүснэгт нь санхүүгийн байдлын тайлагналын дараах 12 сарын хугацаанд төлөгдөх эсвэл хүлээн авах дүнг холбогдох мөрийн дагуу нэгтгэн хөрвөх чадварын үзүүлэлтийг харуулж байна.

	2012 оны 12 дугаар сарын 31			2011 оны 12 дугаар сарын 31		
	Төлөгдөх болон хүлээн авах дүн		Нийт	Төлөгдөх болон хүлээн авах дүн		Нийт
	Тайлагналын хугацаанд 12 сарын доторх	Тайлагналын хугацааны 12 сарын дараа		Тайлагналын хугацаанд 12 сарын доторх	Тайлагналын хугацааны 12 сарын дараа	
<i>Сая төгрөгөөр</i>						
Бэлэн мөнгө	28,317	-	28,317	44,505	-	44,505
Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө	3,179,637	93,342	3,272,979	2,147,427	97,153	2,244,580
Санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад бэлэн	-	142,553	142,553	209,456	3,084	212,540
Буцаан худалдан авах гэрээ	2,031,631	-	2,031,631	678,496	-	678,496
Алт ба үнэт металл	435,778	3,891	439,669	264,189	3,896	268,085
Засгийн газрын үнэт цаас	100,000	59,210	159,210	-	155,276	155,276
Дотоодын банкуудад олгосон зээл	286,847	7,963	294,810	229,469	111,112	340,581
Үндсэн болон биет бус хөрөнгө	-	26,631	26,631	-	26,003	26,003
<b>Бусад хөрөнгө</b>	<b>7,421</b>	<b>-</b>	<b>7,421</b>	<b>6,148</b>	<b>-</b>	<b>6,148</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>6,069,631</b>	<b>333,590</b>	<b>6,403,221</b>	<b>3,579,690</b>	<b>396,524</b>	<b>3,976,214</b>
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	-	828,450	828,450	-	713,351	713,351
Төв банкны үнэт цаас	752,151	-	752,151	879,113	-	879,113
Төрийн байгууллагуудад өгөх өр төлбөр	1,915,611	1,044,075	2,959,686	292,722	878,168	1,170,890
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	780,935	590,736	1,371,671	369,960	645,270	1,015,230
Гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр	471,387	105,027	576,414	-	105,412	105,412
<b>Бусад өр төлбөр</b>	<b>62,481</b>	<b>-</b>	<b>62,481</b>	<b>58,072</b>	<b>-</b>	<b>58,072</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,982,565</b>	<b>2,568,288</b>	<b>6,550,853</b>	<b>1,599,867</b>	<b>2,342,201</b>	<b>3,924,068</b>

## 3 НББ-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглагдсан шийдвэрлэх тооцоолол ба үнэлэлтүүд

Банк нь ирэх жилийн хөрөнгө, өр төлбөр болон санхүүгийн тайлангуудад тайлагнасан дүнгүүдэд нөлөө үзүүлэхүүц тооцоолол, таамаглал хийдэг. Тооцоолол болон үнэлэлтүүд нь үргэлж хянагддаг бөгөөд удирдлагын туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх нөхцөл байдалд зохистой гэж үзсэн хүлээлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүдэд суурилдаг. Удирдлага нь мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо хэрэгжүүлэхдээ тооцооллуудаас гадна тодорхой үнэлэлт хийдэг болно. Санхүүгийн тайланда хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд мэдэгдэхүүц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилд хөрөнгө болон өр төлбөрийн тайлагнасан дүнгүүдэд мэдэгдэхүүц залруулга хийх шаардлага үүсгэж болох тооцооллуудад дараах зүйлүүд хамаарна. **Сангийн яамнаас авсан зээлийн анхлан хүлээн зөвшөөрөлт болон дотоодын банкинд олгосон зээлийн анхны бүртгэл.** Банк 20,433 сая төгрөг (2011 онд 20,796 сая төгрөг) -ийн Сангийн яамнаас авсан зээлтэй ба энэхүү хөрөнгийн эх үүсвэр нь Германы Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт буюу Сангийн яаманд олгосон бус нутгийн хөгжлийг дэмжих

### **3 НББ-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглагдсан шийдвэрлэх тооцоолол ба үзлэлтүүд (Үргэлжлэл)**

Азийн Хөгжлийн Банк болон Германы Засгийн газрын санхүүжилт юм. Энэхүү санхүүжилт нь жилийн 0.75 хувиас 1 хувь хүртэл маш бага хүйтэй, эдийн засгийн зорилтот салбар эсвэл бусад тодорхой зорилгоор бага хүйтэйгээр олгогдох нөхцөлтэй болно. Удирдлага ийм төрлийн хэрэгслүүдийг анхлан хүлээн зөвшөөрхөд олз үүсэх эсэх талаар нягталж үзсэн. Энэхүү санхүүжилт нь бус нутаг болоод нийгмийн хөгжилд зориулагдсан учир энэхүү хөрөнгө нь ямар нэгэн ашиг олох зорилгоор нийтэд олгогдох ёсгүй хэмээн дүгнэжээ. Мөн түүнчлэн, эдгээр байгууллагуудаас Монголын банкуудад харьцангуй хүйтэй санхүүжилт олгосон. Тиймээс анхлан хүлээн зөвшөөрөлтийн олзыг бүртгээгүй болно.

Ийм төрлийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр Банк нь бусад банкуудад харьцангуй бага хүйтэй зээлийг олгох боломжтой болсон. Удирдлага ийм төрлийн хэрэгслүүдээс анхлан хүлээн зөвшөөрөлтийн гарз бүртгэх эсэхийг нягталж үзсэн бөгөөд ажил гүйлгээг холбоотой бус талуудтай зах зээлийн хүүгээр хийж байгаа тул гарз бүртгэхгүй байх нь зөв гэж үзсэн. Дээрх дүгнэлтийг хийхдээ удирдлага эдгээр хэрэгслүүдийг салангид зах зээлийн сегмент гэж тооцсон.

**Дотоодын банкуудад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт.** Банк зээлийн багцын үнэ цэнийн бууралтыг үзлэхээр тогтмол хяналт тавьдаг. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг тогтооходоо ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахүйц аливаа мэдээлэл байгаа эсэхийг нягталж үздэг. Тодруулга 12-д толилуулсан 2012 оны 12 дугаар сарын 31-нээр Анод банкинд олгосон 89,490 сая төгрөгийн (2011 онд 102,000 сая төгрөг) зээлийн бодит үнэ цэнэ болон үнэ цэнийн бууралтын санг тогтоох хангалттай зөв, бодитойгоор ирээдүйн мөнгөн урсгалыг тооцоолох боломжгүй байсан нь мэдэгдэхүйц тодорхой бус байдалдай холбоотой. Банкны удирдлага энэхүү зээлийг Монгол улсын Засгийн газар төлж барагдуулна гэж үзэж байна. Анод банкинд олгосон зээлийг барагдуулах зорилгоор Сангийн яам Засгийн газрын бонд гаргах үйл явц УИХ-аар батлагдаагүй байна. Одоогийн байдлаар аливаа таамаглалаар бонд гарч энэхүү авлагын ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын дүн болон цаг хугацаа нь тодорхойгүй байдалд Банкны удирдлага нь 100 хувийн алдагдлын сан байгуулах зүйтэй гэж үзсэн.

**Санхүүгийн хэрэгслэлийн анхлан хүлээн зөвшөөрөлт.** НББОУС 39 дагуу санхүүгийн хэрэгслүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтийг уг хэрэгслүүдийн бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө гэж заасан. Хэрэв идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэгслүүдийн хувьд бодит үнийг нь тохиромжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлж болно. Жишээ нь: холбоогүй талуудын хооронд ижил төсөөтэй өөр бусад санхүүгийн хэрэгслүүдийг үр ашигт хүүгийн аргаар үнийг тодорхойлдог. Тодруулга 12-д заасны дагуу, Банк нь 2012 оны 11 дүгээр сараас эхэлж шатахуун болон хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд 204,702 сая төгрөгийн зээлийг дотоодын банкуудад олгосон. Эдгээр дэд хөтөлбөр зээлүүдийн нөхцөл, төлбөрийн хугацааг Банк: Уул уурхайн яам, Зам тээвэрийн яам, YXAA яамны хамтарсан тушаалын дагуу дэд хөтөлбөрүүдийг батлан, хэрэгжүүлж эхлээд байна. Үүнээс гадна, Банкны санхүүжилтийн дагуу сонгогдсон аж ахуй нэгж байгууллагууд нь банкуудаар дамжуулан тус зээлийг авч байна. Засгийн газрын удирдамжийн дагуу банкуудад олгосон зээлийн хүүгийн түвшин нь зах зээлийн хүүгээс 0.89 хувиар доогуур байсан анхны хүлээн зөвшөөрөлтөөр бодит үнэ цэнэ нь 186,924 сая төгрөг байв. Эдгээр зээлийн нэрлэсэн үнэ болон бодит үнэ цэнийн зөрүү нь 17,895 сая төгрөг тооцогдсон ба дэлгэрэнгүй орлогын тайландаа тусгагдсан.

Тус дэд хөтөлбөрийн хүрээнд анхлан хүлээн зөвшөөрөлтийг хийхдээ банкны зээлийн хүүг хорогдуулсан мөнгөн гүйлгээний үндсэн дээр бодит үнийг тооцоолох шаардлагатай.

Үүнээс гадна, хөнгөлөлтийн хувийг +/- 1 хувиар ихсгэж, бууруулж тооцвол зээлийн анхлан хүлээн зөвшөөрөлтийн алдагдал нь 1,376 сая төгрөг эсвэл 1,399 сая төгрөгөөр бага байна.

**Эрх хүлээн авагч томилогдсон банкуудад тавих хяналт.** Банк Эрх хүлээн авагч томилсон банкуудад хяналт тавьж байгаа эсэх болон улмаар Банкны санхүүгийн тайландаа нэгтгэгдэх хэрэгтэй эсэхийг тодорхойлоходоо Банк болон тухайн банкуудын хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлэлт хийсэн. Уг үнэлэлтийг хийхдээ дараах байдлыг харгалзан үзсэн:

- Банк нь хуулийн шаардлагын дагуу Эрх хүлээн авагч томилсон;

### **3 НББ-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглагдсан шийдвэрлэх тооцоолол ба үнэлэлтүүд (Үргэлжлэл)**

- Эрх хүлээн авагч нь зөвхөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн байр сууринаас хандаж банкийг татан буулгах тодорхой зорилготой ба тухайн банкны ямар нэгэн стратегийн шийдвэрийг гаргадаггүй;
- Эрх хүлээн авагч нь хуулиар тодорхойлсон хүрээнд ажиллах ба өр барагдуулах дарааллыг мөн хуулиар тодорхойлсон. Иймд, Эрх хүлээн авагч нь Банкны үр өгөөжөнд нөлөөлөх зорилгоор тодорхой шийдвэр гаргах эрхгүй болно;
- Хэдийгээр Банк Эрх хүлээн авагчийн хүрээнд банкуудад зээл олгож болох боловч энэхүү зээлийг хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийг эргүүлэн төлөх баталгааны хуулийн дагуу Засгийн газрын үүргийг биелүүлэхийн тулд Засгийн газрын нэрийн өмнөөс олгох болно. Ийм учраас эдгээр зээлийн авлагын үр өгөөж нь Засгийн газрын бондын хэлбэртэй байна гэж Удирдлага үзэж байна.

Дээрх зүйлүүд дээр үндэслэн хэдийгээр Банк нь эрх хүлээн авсан банкнуудын үйл ажиллагааг удирдах эрхтэй боловч өөрийн эрхээ үр ашигт нөлөөлөх зорилгоор ашиглаж болохгүй ба тэдгээр үр ашиг нь эрх хүлээн авсан банкны гүйцэтгэлээс хамаардаггүй болно. Иймд удирдлага эдгээр банкуудыг санхүүгийн тайланд нэгтгэх шаардлага байхгүй гэж үзэж байна.

**Тасралтгүй байх зарчим.** Удирдлага нь эдгээр санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ханшны хөрвүүлэлтийн алдагдлаас шалтгаалан алдагдал хүлээсэн нь өөрийн хөрөнгийн дүн сөрөг гарсан (Тодруулга 12- г үзнэ үү). Удирдлагын үзэж буйгаар ирээдүйд ямар нэгэн үйл ажиллагаа үргэжлүүлэхгүй байх нь ямар нэгэн эрсдэл гарахгүй болно гэж үзэж байна. Банк нь үндэсний мөнгөн тэмдэгтийн гаргагч ба ямар нэгэн хөрөвөх чадварын эрсдэлд ороогүй болно. Тодруулга 2-д заасны дагуу Банкны өр төлбөрүүд нэг жилийн дотор төлөгдөх бөгөөд хөрөнгийн хувьд жилийн хугацаанд бүрэн тусгагдана гэж үзэж байна.

### **4 Шинэ буюу нэмэлт өөрчлөлт орсон стандартуудын тайлбар, хэрэгжилт**

2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Банкны мөрдөж буй болон шинээр батлагдсан стандартуудын тайлбар хэрэглээ:

**“Тодруулга – Санхүүгийн Хөрөнгийн шилжүүлэг” - СТОУС 7-д орсон нэмэлт өөрчлөлтүүд (2010 оны 10 дугаар сард батлагдаж, 2011 оны 7 дугаар сарын 01-ээс эхлэх тайлант жилүүдэд мөрдөнө).** Нэмэлт өөрчлөлт нь санхүүгийн хөрөнгийн шилжүүлгээс үүдэн гарч байгаа эрсдэлүүдийн талаар нэмэлт тодруулга хийхийг шаардсан. Энэхүү өөрчлөлтөөр санхүүгийн хөрөнгийг нөгөө этгээдэд шилжүүлсэн боловч санхүүгийн тайланд бүртгэгдсэн хэвээр үлдсэн тохиолдолд хөрөнгийн үндсэн шинж, үнэ болон санхүүгийн хөрөнгийн эрсдэл болон урамшууллын талаар тодорхой тодруулга хийх шаардлага тавигдсан. Түүнчлэн тайлбар тодруулга нь холбогдох өр төлбөрийн дүнг, мөн холбогдох өр төлбөр ба санхүүгийн хөрөнгө хоорондын уялдаа холбоог ойлгох боломжийг хэрэглэгчдэд олгоно. Компани санхүүгийн хөрөнгийг тэнцлээс хассан боловч шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой тодорхой эрсдэлүүд болон урамшуулалттай тулгардаг бөгөөд, энэхүү эрсдэлүүдээс үүсэх нөлөөллийн талаар нэмэлт тодруулга хийх шаардлагатай. Тус өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болно.

**Бусад шинэчилсэн стандарт болон зааврууд.** СТОУС 1, “СТОУС-ийг анх удаа хэрэгжүүлэгч”-ийн хэт инфляци мөн зарим онцлох зүйл болон чөлөөлөлтийн тухай өөрчлөлтүүд эдгээр санхүүгийн тайлангуудад ямар нэг нөлөө үзүүлэхгүй. НББОУС 12 “Орлогын албан татвар”-ийн бодит үнэ цэнээр хэмжигдэж буй хөрөнгө оруулалтын хөрөнгө зөвхөн борлуулалтаар эргэн нөхөгдөх тухай няцаах таамаглалын өөрчлөлт эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлэхгүй.

## 5 Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд

2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойшхи тайлант хугацаанд заавал мөрдөх стандартууд ба тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн ба эдгээрийг Банк хугацаанаас өмнө хэрэгжүүлж эхлээгүй.

**СТОУС 9, Санхүүгийн хэрэгслүүд: Ангилал ба хэмжилт.** 2009 оны 11 дүгээр сард гарсан СТОУС 9 нь НББОУС 39 дэх санхүүгийн хөрөнгийн ангилал ба хэмжилттэй холбоотой хэсгүүдийг орлох болсон. 2010 оны 10 дугаар сард СТОУС 9-д нэмэлт өөрчлөлт оруулж, санхүүгийн өр төлбөрийн ангилал, хэмжилтийн асуудлыг багтаасан. 2011 оны 12 дугаар сард дахин нэмэлт өөрчлөлт оруулж, (i) 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш эхлэх тайлант жилүүд хүргэл мөрдөгдөхөөр болж өөрчилсөн (ii) шилжилтийн үеийн тодруулгыг нэмж өгсөн. Тус стандартын гол агуулгаас дурдвал:

- Санхүүгийн хөрөнгүүдийг хэмжилтийн үүднээс хоёр хэсэгт ангилна: дараагийн тайлант үе бүрт бодит үнэ цэнээр нь хэмжих санхүүгийн хөрөнгүүд ба хороогдуулсан өртгөөр нь хэмжих санхүүгийн хөрөнгүүд. Санхүүгийн хөрөнгүүдийг анхлан хүлээн зөвшөөрөх үед шийдвэрийг гаргана. Ангилалыг шийдэхэд тухайн байгууллага өөрийн санхүүгийн хэрэгслүүдийг удирдахдаа ашигладаг бизнес загвар түүнчлэн гэрээний дунд тухайн хэрэгслүүдийн үүсгэх мөнгөн урсгалын шинж чанараас шалтгаална.
- Дараах хоёр нөхцлийг хангасан өрийн хэрэгслүүдийг дараагийн тайлант үе бүрт хороогдуулсан өртгөөр хэмжинэ: (i) байгууллагын бизнес загварын зорилго нь гэрээгээр үүсэх мөнгөн урсгалыг цуглуулахын тулд хөрөнгийг эзэмшихэд оршино, (ii) гэрээний дунд хөрөнгийн бий болгох мөнгөн урсгал нь зөвхөн зээлийн үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрөөс бүрдэнэ (өөрөөр хэлбэл зөвхөн энгийн зээлд байх шинжүүдийг агуулсан). Бусад бүх өрийн хэрэгслүүдийг бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зарлагын дансанд бүртгэнэ.
- Бүх өмчийн хэрэгслүүдийг дараагийн тайлант үе бүрт бодит үнэ цэнээр хэмжинэ. Борлуулах зорилгоор эзэмшиж буй өмчийн хэрэгслүүдийг бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зарлагын дансанд бүртгэнэ. Бусад бүх өмчийн хэрэгслүүдийн хувьд тэдгээрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийн хэрэгжээгүй болон хэрэгжсэн олз, гарзыг орлого, зарлагын дансанд бүртгэх бус бусад дэлгэрэнгүй орлого байдлаар хүлээн зөвшөөрөх буцалтгүй сонголтыг хийж болно. Бодит үнэ цэнийн олз, гарзыг дахин ангилж орлого, зарлагын дансанд бүртгэхгүй. Хэрэгсэл тус бүрээр энэ сонголтыг хийнэ. Харин хөрөнгө оруулалтын өгөөжийг төлөөлж байгаа тохиолдолд ногдол ашгийг орлогын тайландаа толилуулна.
- НББОУС 39-ийн санхүүгийн өр төлбөрийн ангилал, хэмжилттэй холбоотой ихэнхи шаардлагууд ямар нэг өөрчлөлтгүйгээр СТОУС 9-д орж ирсэн байгаа. Гол өөрчлөлт нь хэрэгслүүдийг бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зарлагын дансанд бүртгэдэг санхүүгийн өр төлбөрүүдийн зээлийн эрсдэлд гарсан.
- Өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт толилуулах шаардлага тавигдсан.

СТОУС 9-ийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн заавал мөрдөнө, энэ хугацаанаас өмнө хэрэгжүүлж болохыг зөвшөөрсөн. Банк нь энэхүү стандартын утга агуулга, Банкинд үзүүлэх нөлөө болон стандартыг хэрэгжүүлж эхлэх хугацааг судалж байна.

**СТОУС 10, нэгтгэсэн Санхүүгийн Тайлангүүд (2011 оны 5 дугаар сард гаргасан, 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө),** НББОУС 27, Нэгтгэсэн ба тусдаа санхүүгийн тайлан болон СТХ-12 “Нэгтгэл – тусгай зориулалттай аж ахуйн нэгж стандартад заасан нэгтгэл болон хяналтын заавруудыг өөрчилсөн. СТОУС 10 хяналтын тодорхойлолтыг өөрчилснөөр бүх аж ахуйн нэгжүүд хяналтыг тодорхойлоход нэгэн ижил тодорхойлолтыг хэрэглэх болсон. Тодорхойлолтыг өргөн хүрээний хэрэглээний заавраар хангасан. Энэхүү өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайлангүүдад материаллаг нөлөөл үзүүлэхгүй гэсэн хүлэлттэй байна.

**СТОУС 11, Хамтарсан хэлцэл, (2011 оны 5 дугаар сард гаргасан, 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө),** НББОУС 31, “Хамтарсан хөрөнгө оруулалт дахь хувь оролцооны тайлагнал” болон СТХ-13, “Хувь нийлүүлэгчдээс мөнгөн хөрөнгө нийлсэн хамтын хяналттай аж ахуйн нэгжүүд” стандартуудыг сольсон. Тодорхойлолтод өөрчлөлт оруулснаар хамтарсан хэлцлийн төрлийг 2 болгон бууруулсан: хамтарсан үйл ажиллагаа болон хамтарсан хөрөнгө оруулалт.

## 5 Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд (Үргэлжлэл)

Хамтран хянадаг байгууллагын пропорционалиар нэгтгэх журмыг халсан. Хамтарсан хэлцэлд оролцогчид бүртгэлийг заавал өмчийн аргаар хөтөлнө. Одоогоор эдгээр өөрчлөлтүүдийг Банкны санхүүгийн тайланда үзүүлэх нөлөөллийн хэмжээг удирдлага үнэлэх шатандаа байна.

**СТОУС 12, Бусад Аж Ахуйн Нэгжүүд дэх Хувь Оролцооны Тодруулга, (2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө),** охин компани, хамтарсан хэлцэл, хараат компани болон нэгтгэгдээгүй бүтцийн байгууллагад хувь оролцоо бүхий компаниудад хамаарна. Энэ стандарт нь НББОУС 28 “Хараат компани дахь хөрөнгө оруулалт” –д заасан тодруулгын шаардлагыг өөрчилсөн. СТОУС 12 аж ахуйн нэгжүүдийг охин, хараат компани, хамтарсан хэлцэл болон нэгтгэгдээгүй бүтцийн байгууллагад оруулсан хувь оролцоотой холбоотой гарах эрсдэл болон санхүүгийн нөлөөг үнэлэхэд тус болох мэдээллээр санхүүгийн тайлан хэрэглэгчдийг хангахаар заасан. Энэ шаардлагыг хангахын тулд шинэ стандартын дагуу компани хянадаг, хамтран хянадаг, өөр байгууллагын гол шийдвэрт ихээр нөлөөлдөг эсэхийг тодорхойлоход ихээхэн тооцоолол болон таамаглалуудыг ашигладаг. Бүлэг үйл ажиллагаа болон мөнгөн гүйлгээн дахь хяналтын бус эрхийн хувь оролцооны дэлгэрүүлсэн тодруулга нь материаллаг хяналтын бус оролцоо бүхий охин компаниудын санхүүгийн мэдээллийг цуглуулж, нэгтгэгдээгүй бүтцийн байгууллагад оруулсан хувь оролцооны тодруулгыг илүү нарийн болгож өгсөн. Одоогоор эдгээр өөрчлөлтүүдийг Банкны санхүүгийн тайланда үзүүлэх нөлөөллийн хэмжээг удирдлага үнэлэх шатандаа байна.

**СТОУС 13, Бодит үнэ цэнийн хэмжилт, (2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө),** бүх СТОУС-уудад ашиглах боломжтой болгон бодит үнэ цэнийн тодорхойлолтыг өөрчилсөнөөр, бодит үнэ цэнийн хэмжилт болон тодруулгын шаардлагуудын хүндрэлтэй байдлыг багасгаж зохицлыг нэмэх зорилготой. Одоогоор эдгээр өөрчлөлтүүдийг Банкны санхүүгийн тайланда үзүүлэх нөлөөллийн хэмжээг удирдлага үнэлэх шатандаа байна.

**НББОУС 27, Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан, (2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойши эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө),** хараат компани, хамтарсан компани болон охин компани дангаараа санхүүгийн тайлан бэлтгэж байхад, тэдгээрт оруулсан хөрөнгө оруулалтын бүртгэлийн болон тодруулгын шаардлагуудыг тодорхойлох зорилготой. Нэгтгэсэн санхүүгийн тайлан болон хяналтын талаарх зааврыг СТОУС 10, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан стандартаар орлуулсан. Энэхүү стандартын өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланда нөлөө үзүүлэхгүй хэмээн үзэж байна.

**НББОУС 28, Хараат компани болон хамтарсан хөрөнгө оруулалт, (2011 оны 5 дугаар сард сард гаргасан, 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойши эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө),** Зөвлөл энэ төслийг хэлэлцэж байхдаа хамтарсан хөрөнгө оруулалтыг өмчийн аргаар бүртгэхийг НББОУС 28-д оруулахаар шийдсэн, учир нь өмчийн арга хамтарсан хэлэлцээр болон хараат компанийн аль алинд хамаарна. Зааварт үүнээс өөр өөрчлөлт ороогүй. Банкны удирдлага энэхүү стандартын өөрчлөлт санхүүгийн тайланда нөлөө үзүүлэхгүй хэмээн үзэж байна.

**НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартад орсон нэмэлт өөрчлөлтүүд, (2011 оны 6 дугаар сард гарсан бөгөөд 2012 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хойшихи тайлант жилүүдэд мөрдлөг болгоно),** бусад дэлгэрэнгүй орлогод тусгасан зүйлсийн тодруулгын талаарх өөрчлөлтүүд. Энэхүү өөрчлөлт нь аж ахуйн нэгж бусад дэлгэрэнгүй орлогод тусгах зүйлсийг ирээдүйд ашиг, алдагдалд оруулж ангилах, ангилахгүйгээс хамааран бусад дэлгэрэнгүй орлогоо хоёр хэсэг болгон тайлагнахыг шаардсан. НББОУС 1-ийн санал болгосон нэр нь “ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын айлан” гэдэг нэрээр солигдсон. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг Банкны санхүүгийн тайланда үзүүлэх нөлөөллийг удирдлага судалж байна.

**Шинэчилсэн НББОУС 19, Ажилчдын Тэтгэвэр Тэтгэмж (2011 оны 6 дугаар сард батлагдсан, 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойши эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө),** тэтгэврийн сангийн зардал, ажлаас халагдсаны тэтгэмж болон бүхий л ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмжийн хүлээн зөвшөөрөлт, түүний хэмжилтэд ихээхэн өөрчлөлт оруулсан. Цэвэр тэтгэвэр, тэтгэмжийн өр төлбөрт (хөрөнгөд) гарсан өөрчлөлтүүдийг тухай бүр бүртгэхийг шаардсан: (i) үйлчилгээний өртөг болон цэвэр хүүг орлого зарлагын дансанд;

мөн (ii) бусад дэлгэрэнгүй орлогын дахин хэмжилт. Энэхүү өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайлангуудад материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

## **5 Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд (Үргэлжлэл)**

**СТОУС 7-д орсон нэмэлт өөрчлөлтүүд- Тодруулга-Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хаах (2011 оны 12 дугаар сард гарсан бөгөөд 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойшихи тайлант жилүүдэд мөрдлөг болгоно). Энэхүү өөрчлөлт нь санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж болох эсэх, ингэснээр үүсч болох нөлөөллийг үнэлэхийн тулд санхүүгийн тайланг хэрэглэдэг хүмүүст дэмжлэг болох зорилгоор тодруулга хийх шаардлагатай гэдгийг тодорхойлсон.**

**Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хаах - НББОУС 32-д орсон нэмэлт өөрчлөлтүүд (2011 оны 12 дугаар сард гарсан бөгөөд 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойших тайлант эжилүүдэд мөрдлөг болгоно). Зарим хаах шалгууруудыг хэрэгжүүлэх үед гардаг нийцэмжгүй зүйлүүдийг шийдвэрлэхийн тулд НББОУС 32-д зааварчилгаа нэмж оруулсан. Энэ өөрчлөлт нь “одоогийн байдлаар хооронд нь хаах хуулиар хүлээсэн эрхтэй байна” гэсэн утгыг тодорхой болгож өгөхийн зэрэгцээ зарим нийт тооцооны систем нь цэвэр тооцоотой тэнцүү байж болно гэсэн тодорхойлолтыг мөн тайлбарласан. Одоогоор эдгэр өөрчлөлтүүдийг Банкны санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлийг удирдлага үнэлэх шатандаа байна.**

**НББОУС 1-ийн өөрчлөлт, Санхүүгийн Тайлангуудын Толилуулга (2011 оны 3 дугаар сарын 13 батлагдсан, 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойши эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө), Энэхүү өөрчлөлт нь СТОУС-ыг анх удаа хэрэгжүүлэгч шилжилтийн явцад зах зээлийн хүүгээс доогуур олгож буй Засгийн газрын зээлийг тодруулна. Заасан хугацаанаас өмнө хэрэгжүүлж болно. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг судалж байна.**

**Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартуудад оруулсан сайжруулалтууд (2012 оны 5 дугаар сард гарсан бөгөөд 2013 оны 01 дүгээр сарын 01-ний одроос хойших тайллант жилүүдэд мөрдлөг болгоно).** Эдгээр сайжруулалтууд нь нийт таван стандартын өөрчлөлтүүдээс бүрдсэн. СТОУС 1-д дараах өөрчлөлтүүд орсон: (i) СТОУС санхүүгийн тайллагаа гаргаж буй аж ахуйн нэгж нь СТОУС 1-ийг дахин дахин ашиглах эсвэл байнга ашиглаж байсан мэт СТОУС-уудыг өнгөрсөн үедээ ашиглах; (ii) өнгөрсөн үедээ анхлан хэрэгжүүлэгч нарт СТОУС 23 “Зээлийн зардал”-ыг ашиглахаас чөлөөлөх нөхцлийг нэмсэн. НББОУС 1-д орсон өөрчлөлтүүд нь өнгөрсөн үеэ дахин тайлгнах, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон эсвэл толилуулгын зорилгоор дахин ангилсан зэргээс материаллаг нөлөөлөл үүсэх тул өмнөх хугацааны эхэнд өгсөн гурав дахь тайланд тайлбар тодруулга ирүүлэх шаардлагагүй, харин сайн дураараа харьцуулсан тайлан хүргүүлэх сонирхолтой аж ахуйн нэгжүүд тайлбар тодруулгыг ирүүлэх зайлшгүй шаардлагатай гэдгийг тодотгосон. НББОУС 16-д орсон өөрчлөлт нь нэгээс дээш тайлангийн хугацаанд ашигласан үйлчилгээний тоног төхөөрөмжийг бараа материал бус үндсэн хөрөнгөөр бүртгэхийг тодотгожээ. НББОУС 32-т орсон өөрчлөлт нь НББОУС 12-т шаарддаг байсны адил эзэмшигчдэд хуваарилсан хөрөнгийн татварын нөлөөллийг орлогын тайландаа тусгаж байхыг тодотгосон байна. НББОУС 34-ийн шаардлагуудыг СТОУС 8-тай адилтгахаар өөрчилжээ. НББОУС 34 нь үйл ажиллагаа эрхэлсэн удирдах ажилтанд тогтмол мэдээлдэг бөгөөд өмнөх жилийн санхүүгийн тайлан дахь тооцооллоос материаллаг өөрчлөлт гарсан бол нийт хөрөнгө болон өр төлбөр тооцдог аргачлалыг үйл ажиллагааны хэсэгт нээлттэй болгохыг шаарддаг болсон.

**СТОУС 10, СТОУС 11 болон СТОУС 12-т орсон Шилжилтийн зааварчилгааны өөрчлөлтүүд (2012 оны 6 дугаар сард гаргасан бөгөөд 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант жилүүдэд мөрдлөг болгоно). Эдгээр өөрчлөлтүүд нь СТОУС 10 “Нэгдсэн санхүүгийн тайлангууд” дахь шилжих зааварчилгааг тодотгосон. СТОУС 10-ыг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүд СТОУС 10-ыг хэрэгжүүлж эхэлсэн тайлант жилийнхээ эхний өдөр хяналтыг үнэлэх шаардлагатай бөгөөд хэрэв СТОУС 10-ын дагуу гаргасан нэгдсэн дүгнэлт нь НББОУС 27 болон YCA 12-ыхоос ялгаатай байвал огт биелэшгүй биш бол харьцуулалт хийх өмнөх тайлангийн жилийг дахин тайлагнана (СТОУС 10-ыг 2013 онд хэрэгжүүлж эхэлсэн аж ахуйн нэгжийн хувьд энэ нь 2012 он байх болно). Эдгээр өөрчлөлтүүд нь мөн харьцуулалт хийх мэдээллийг зөвхөн өмнөх тайлант жилд гаргаж өгөхөөр шаардлагыг хязгаарлах замаар СТОУС 10, СТОУС 11 “Хамтарсан хэлцэл” болон СТОУС 12 “Бусад аж ахуйн нэгжүүд дэх хувь оролцооны тодруулга”-уудад шилжилтийн нэмэлт хөнгөлөлтийг гаргаж өгч байгаа. Үүнээс гадна, эдгээр өөрчлөлтүүд нь СТОУС 12-ыг хэрэгжүүлж эхэлснээс өмнөх тайлант жилүүдэд нэгдсэн бус аж ахуйн нэгжүүдийн харьцуулалт хийх мэдээллийг гаргаж өгөх шаардлагыг хэрэгсэхгүй болгосон. Одоогийн байдлаар эдгээр өөрчлөлтүүдийн талаар Банкны санхүүгийн тайландаа үзүүлэх нөлөөг Банкны удирдлага үнэлэх шатандaa байна.**

## 5 Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд (Үргэлжлэл)

**СТОУС 10, СТОУС 12 болон НББОУС 27-д орсон нэмэлт өөрчлөлтүүд – Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжүүд (2012 оны 10 дугаар сарын 31-ний өдөр гарсан бөгөөд 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойшхи тайланы эсилүүдэд мөрдлөг болгоно).** Өөрчлөлт нь хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийг дараах байдлаар тодорхойлсон: (i) хөрөнгө оруулалтын удирдлагын үйлчилгээ үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татсан, (ii) үйл ажиллагааны зорилго нь зөвхөн хөрөнгийг өсгөх болон хөрөнгө оруулалтын ашиг олох зорилгоор хөрөнгийг зарцуулахад оршдог гэсэн хариуцлагыг хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн (iii) хөрөнгө оруулалтаа бодит үнэ цэнээр тооцож, үнэлдэг. Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж нь ашиг, алдагдлаа өөрийн охин компаниудыг бодит үнэ цэнээр бүртгэхээс гадна аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай хамааралтай үйлчилгээг үзүүлдэг охин компаниудынхаа тайланг зөвхөн нэгтгэхийг шаарддаг. СТОУС 12 нь аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж мөн эсэхийг тодруулахад гаргасан чухал дүгнэлт болон нэгтгээгүй охин компанидаа санхүүгийн болон бусад төрлийн дэмжлэгийг санаатайгаар үзүүлж байсан эсвэл үзүүлэхийг завдсан талаарх мэдээлэл зэрэг шинэ тодруулгыг ирүүлэх өөрчлөлтийг тусгасан. Одоогоор эдгээр өөрчлөлтүүдийн Банкны санхүүгийн тайландаа үзүүлэх нөлөөг үнэлэх шатандaa байна.

Дээр өөрөөр заагаагүй бол эдгээр шинэ стандартууд болон тайлбарууд нь Банкны санхүүгийн тайландаа ноцтой нөлөөлөхгүй.

## 6 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

<i>Сая төгрөгөөр</i>	<i>Тодруулга</i>	<b>2012.12.31</b>	<b>2011.12.31</b>
Бэлэн мөнгө		28,317	44,505
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө:			
- Гадаад валютаар богино хугацаат хадгаламж-	7	2,789,889	2,059,287
- Хугацаагүй хадгаламж	7	387,748	87,290
-Зээлжих тусгай эрхийн хадгаламж	7	94,647	97,153
Төрийн байгууллагуудад төлөх өр төлбөр (ТӨГ)		(703,445)	(858,660)
Банкуудын харилцах (ТӨГ)	17	(842,958)	(645,501)
<b>Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>		<b>1,754,198</b>	<b>784,074</b>

Дээрх дүнгүүд нь Мөнгөн гүйлгэний тайлан мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө гэж тайлагнасан. 2012 оны 12 дугаар сарын 31-нээр мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд тооцогдох санхүүгийн хөрөнгийн үлдэгдлийн зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт энд Пүүрс, Мүүдийс болон Фичийн өгсөн зэрэглэлийн хамгийн багаар нь нэгтгэн харуулж болно:

<i>Сая төгрөгөөр</i>	<i>Хугацаагүй хадгаламж</i>	<b>Богино хугацаат хадгаламж гадаад валютаар</b>
<i>Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй</i>		
- AAA зэрэглэлтэй	30,820	334,145
- AA- с AA+ зэрэглэлтэй	270,930	2,455,744
- A- с A+ зэрэглэлтэй	85,998	-
<b>Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд багтсан гадаадын байгууллагад байршуулсан хөрөнгө, Зээлжих Тусгай Эрхийн хадгаламжийг оруулахгүйгээр</b>	<b>387,748</b>	<b>2,789,889</b>

## 6 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө (Үргэлжслэл)

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн тэнцлийн үлдэгдлийн зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт ба Пүүрсийн зэрэглэл эсвэл Мүүдийс болон Фичийн зэрэглэл дээр үндэслэн 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн эрсдэлийн чанарыг нэгтгэн үзүүлбэл :

Сая төгрөгөөр	Хугацаагүй хадгаламж	Богино хугацаат хадгаламж валютаар илэрхийлэгдсэн
<i>Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй</i>		
- AAA рейтингтэй	37,364	58,720
- AA- с AA+ рейтингтэй	49,926	2,000,567
<b>Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд багтсан гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө; Зээлжих Тусгай Эрхийн оруулахгүйгээр</b>	<b>87,290</b>	<b>2,059,287</b>

Хэрэв Төв банк эсвэл түншлэгч олон улсын санхүүгийн байгууллагын хувьд зэрэглэл байхгүй бол (Жишээ нь Английн банк) тэдгээрийн зэрэглэлийг холбогдох улсын зээлжих эрхийн дагуу үнэлнэ. Бэлэн мөнгө болон ОУВС дахь ЗТЭ-ийн хадгаламжийн хувьд Банк зээлийн эрсдэл хүлээгээгүй болно.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн газарзүйн болон мөнгөн тэмдэгтийн эрсдэлийн шинжилгээ, хүүгийн эрсдэлийн шинжилгээ, болон дуусгавар хугацааны шинжилгээг Тодруулга 27-с үзнэ үү.

## 7 Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө

Сая төгрөгөөр	2012.12.31	2011.12.31
Богино хугацаат хадгаламж–гадаад валютаар	2,789,889	2,059,287
Хугацаагүй хадгаламж	387,748	87,290
Хязгаарлагдсан бэлэн мөнгө	604	590
Зээлжих тусгай эрхийн хадгаламж	94,647	97,153
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	87	256
Бусад хувь хөрөнгө	4	4
<b>Нийт гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө</b>	<b>3,272,979</b>	<b>2,244,580</b>

**Гадаад валютын богино хугацаат хадгаламж.** Үүнд гадаадын Төв банкуудад болон бусад санхүүгийн байгууллагуудад ам.доллар ба еврогоор 90 хүртэлх хоногийн хугацаатай (2011 онд 90 хоног), богино хугацаат хадгаламжууд багтана.

**Хугацаагүй хадгаламж.** Үүнд гадаадын Төв банкуудад болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан хүү тооцдоггүй харилцах дансууд багтана.

**Хязгаарлагдсан бэлэн мөнгө.** Үүнд гуравдагч талын хүсэлтээр Цюрикийн харья Шүүхээс хязгаарлалт тогтоосон 397,703 щвейцар франкаар буюу 604 сая төгрөг (2011 онд 590 сая төгрөг). Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 26-аас харна уу.

**Зээлжих тусгай эрхийн хадгаламж.** Энэ үлдэгдэл нь Банкнаас ОУВС-д оруулсан хувь хөрөнгөтэй холбоотой зээлжих тусгай эрхийн хадгаламжийг илэрхийлнэ. 2012 оны 12 дугаар сарын 31-нд 44.1 сая төгрөгийн зээлжих тусгай эрх (2011 онд 45.5 сая зээлжих тусгай эрх) -ээр илэрхийлэгдсэн ба тус дүнд хүү тооцдог.

**Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө.** Энэ нь Дэлхийн банкны группийн гишүүн болох шаардлагын дагуу Дэлхийн банкинд байршуулсан хадгаламж болон түүнд оруулсан хувь хөрөнгө юм. Энэ дун нь харгалзах өр төлбөрийн дүнтэй таарч байгаа (Тодруулга 18-аас харна уу) ба түүнд хүү тооцдоггүй.

Бүх үлдэгдэл дүнгүүд хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй бөгөөд удирдлагын зүгээс энэхүү хөрөнгө нь эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагууд болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан тул бүрэн эргэн төлөгдөнө гэж үзэж байна. Эдгээрийн

## 7 Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршиулсан хөрөнгө (Үргэлжлэл)

ихэнх нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө бөгөөд олон улсын зэрэглэл тогтоох агентлагын тогтоосон зэрэглэлд үндэслэн зээлийн чанарыг Тодруулга 6-д толилуулсан. Үлдсэн хэсэг нь ОУВС болон Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгүүд болон материаллаг бус хязгаарлагдсан бэлэн мөнгө бөгөөд эдгээр нь зээлийн эрсдэлгүй гэж удирдлага үзэж байна.

Эдгээрийн алж нь ч барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй. Удирдлага энэхүү хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны дүнтэйгээ ойролцоо гэж итгэж байна. Газарзүйн болон зээлийн эрсдэлийн чанарын шинжилгээ, валютын ханш, хүү болон дуусгавар хугацааны шинжилгээг Тодруулга 27-с үзнэ үү.

## 8 Санхүүгийн хөрөнгө оруулалт - Борлуулахад бэлэн

Сая төгрөгөөр	2012.12.31	2011 .12.31
<b>Өрийн үнэт цаас - борлуулахад бэлэн</b>		
ОУ-ын Төлбөр Тооцооны Банкны Бонд (ам.доллараар)	-	209,456
Рамп Хөрөнгө оруулалтын данс	139,469	-
<b>Өмчийн үнэт цаас - борлуулахад бэлэн</b>	3,084	3,084
Өмчийн хөрөнгө оруулалт, өртгөөр		
<b>Нийт санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад бэлэн</b>	<b>142,553</b>	<b>212,540</b>

**“Ramp” Хөрөнгө оруулалтын данс.** Хөрөнгө оруулалтын удирдлага болон зөвлөх үйлчилгээний хүрээнд Банк нь Дэлхийн банкны Сэргээн босголт, хөгжлийн олон улсын банк (СБХОУБ)-тай 2011 оны 5 дугаар сард гэрээ байгуулсан. Зөвлөх үйлчилгээний хүрээнд Банк нь СБХОУБ-ийг хөрөнгө оруулалтын үйл ажиллаагааны хүрээнд хөрөнгө оруулалтын дансыг удирдан чиглүүлэх зорилгийгоор итгэмжлэгдсэн төлөөлгөөр томилсон. Хөрөнгө оруулалтын гэрээ ёсоор анхны хөрөнгө оруулалтын хэмжээг 2012 оны 01 дүгээр сард 100 сая ам доллараар тогтсон.

2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хөрөнгө оруулалт дахь дансны үлдэгдэл нь 9.7 сая ам доллар буюу (13,484 сая төгрөг)-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, тогтмол байршаагүй үнэт цаасны өглөг 0.04 сая ам доллар буюу (56 сая төгрөг) байна. Хөрөнгө оруулалтын дансыг АНУ-ын Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан.

Хөрөнгө оруулалтын данс дахь үнэт цаасны дийлэнх хэсгийг АНУ-ын бонд болон бусад Засгийн газрын байгууллагаас гарсан үнэт цаас бүрдэж байна.

Хөрөнгө оруулалтын данс дахь өрийн үнэт цаасны зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт ба Пүүрсийн рейтинг эсвэл Мүүдийс болон Фичийн рейтингийн алж багаар үнэлэхэд AA-AAA зэрэглэлтэй байсан.

Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй энгийн хувьцаа нь Монголын ипотекийн корпораци, Олон улсын хөрөнгө оруулалтын банк, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банкинд оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ. Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй зах зээлийн үнэ байхгүйн улмаас эдгээр хөрөнгө оруулалтыг өртгөөр нь бүртгэдэг. Эдгээр хөрөнгө оруулалтуудад зах зээл байхгүй ба Банк урт хугацаагаар эзэмших төлөвтэй байна.

Удирдлага энэхүү хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-нээр бүртгэлийн дүнгээс материаллаг хэмжээгээр зөрөхгүй хэмээн үзэж байна.

## 9 Буцаан худалдан авах гэрээ

Сая төгрөгөөр	2012.12.31	2011 .12.31
Буцаан худалдан авах гэрээ	2,031,631	678,496
<b>Нийт буцаан худалдан авах гэрээ</b>	<b>2,031,631</b>	<b>678,496</b>

Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан хадгаламжаараа Автомат Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу 100,000 ам.доллараас давсан дун

## 9 Буцаан худалдан авах гэрээ (Үргэлжлэл)

Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкны буцаан худалдан авах гэрээнд (“буцаан худалдан авах репо”) хөрөнгө оруулагддаг. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар буцаан худалдан авах репо гэрээнд оруулсан хөрөнгө оруулалт нь 1459.4 сая ам.доллар (2,031,631 сая төгрөгтэй тэнцүү) байсан. Энэхүү хөрөнгө оруулалт нь нэг сар хүртэлх хугацаатай, жилийн 0.17 хувийн хүйтэй. Холбогдох хөрөнгө оруулалт нь ихэнхдээ барьцаагаар баталгааждаг боловч тус хөтөлбөрийн дагуу үнэт цасанд хөрөнгө оруулалт хийснийг тодорхойлоход бэрхшээлтэй байна. Дэлгэрэнгүйг Тодруулга 27-оос харна уу.

2011 оны 12 дугаар сарын 31-ний болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар буцаан худалдан авах гэрээгээр зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт ба Пүүрсийн рейтинг эсвэл Мүүдийс болон Фичийн рейтингийн аль багаар үнэлэхэд AA+ байсан ба хөрөнгө оруулалт нь хугацаа хэтрээгүй, үнэ цэнэ нь буураагүй гэж үзсэн.

## 10 Алт, үнэт метал

Сая төгрөгөөр	2012.12.31	2011 .12.31
<strong>Үнэлгээгээр</strong>		
Мөнгөжсөн алт	271,909	245,564
Мөнгөжсөн мөнгө	42	383
<strong>Өртгөөр</strong>		
Мөнгөжөөгүй алт, мөнгө	165,574	19,289
Зоос, түүх соёлын үнэт зүйл	2,144	2,849
<strong>Нийт алт болон үнэт метал</strong>	<strong>439,669</strong>	<strong>268,085</strong>

Банк нь холбогдох байгууллагуудад мөнгөжсөн алт байршуулдаг ба бусад үнэт металл (алт, бусад хольц металл болон гулдмай, мөнгөний худэр) зоос болон соёлын үнэт зүйлсийг Банкны Эрдэнэсийн санд хадгалдаг. Эдгээрт цэвэршүүлэхээс өмнөх алт олборлогчдоос худалдан авсан алт мөн хадгалагдаж байдаг. Алтыг цэвэршүүлсний дараа холбогдох байгууллагууд руу шилжүүлдэг.

## 11 Засгийн газрын үнэт цаас

Сая төгрөгөөр	2012.12.31	2011.12.31
Сангийн Яамны үнэт цаас, хямдруулсан өртгөөр	159,210	155,276
<strong>Засгийн газрын нийт үнэт цаас</strong>	<strong>159,210</strong>	<strong>155,276</strong>

2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк Сангийн яамнаас гаргасан дараах үнэт цаасыг эзэмшиж байсан:

- 26,595 сая төгрөгийн үлдэгдэлтэй (2011 онд 24,182 сая төгрөг) Зоос банктай холбоотойгоор гаргасан бонд.
- 30,000 сая төгрөгийн үлдэгдэлтэй (2011 онд 30,000 сая төгрөг) Засгийн газраас төрийн албан хаагчдын орон сууцны санхүүжилтэнд гаргасан бонд.
- 100,000 сая төгрөгийн үлдэгдэлтэй (2011 онд 100,000 сая төгрөгийн үлдэгдэлтэй) Засгийн газраас ноолуур болон жижиг дунд үйлдвэрлэлийн салбарыг дэмжих зорилгоор гаргасан бонд.

2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үлдсэн дүн нь хурийтлагдсан хүү болно.

2010 оны 3 дугаар сарын 26-ны өдөр эрх хүлээн авагч томилогдсон банкинд (Зоос банк)-д өмнө нь олгосон зээлийг хаах зорилгоор Монгол улсын Сангийн яам 33,0 тэрбум төгрөгийн Засгийн газрын бондыг гаргасан. Энэ бонд нь жилийн 0.1 хувийн нэрлэсэн хүйтэй, 4-6 жилийн хугацаатай бол Зоос банкинд олгогдсон зээл нь жилийн 10 хувийн хүйтэй байсан. 2010 оны 3 дугаар сарын 26-нд бондыг 10 хувийн үр ашигт хүүгийн аргыг ашиглан бодит үнэ цэнээр бүртгэсэн ба хүүгийн хувь тухайн үеийн Засгийн газрын бондын хүйтэй ойролцоо байсан. 2011 оны 12 дугаар сарын 31-ний ба 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бонд нь хямдруулсан өртгөөр санхүүгийн байдлын тайланд тусгагдсан.

## 11 Засгийн газрын үнэт цаас (Үргэлжлэл)

Төрийн албан хаагчдын орон сууцны санхүүжилтэнд зориулан гаргасан Засгийн газрын бонд нь 5 жилийн хугацаатай, жилийн 7.8 хувийн хүйтэй.

Засгийн газраас ноолуур болон жижиг дунд үйлдвэрлэлийн салбарыг дэмжих зорилгоор гаргасан бонд нь дараах нөхцлүүдтэй: 2 жилийн хугацаатай, жилийн 12.25 хувийн хүйтэй.

Эдгээр үнэт цаас нь хямдруулсан өртгөөр бүртгэдэг ба үнэт цаасны хугацаа хэтрээгүй, үнэ цэнэ нь буураагүй. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Стандарт ба Пүурс, Мүүдийс болон Фичийн гаргасан рейтингийн хамгийн багаар үнэлэхэд ВВ- зэрэглэлтэй байсан. Засгийн газрын аль ч үнэт цаас нь барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй байна. Холбоотой талуудын ажил гүйлгээтэй холбоотой мэдээллийг Тодруулга 31-ээс харна уу. Эдгээр үнэт цаасны бодит үнэ цэнийн Тодруулгыг 29-өөс харна уу.

## 12 Дотоодын банкуудад олгосон зээл

	2012.12.31	2011.12.31
<b>Сая төгрөгөөр</b>		
Үнэ тогтвортжуулалтын хөтөлбөр	188,360	-
Урвуу репо хэлцэл	92,322	223,244
Анод банкинд хамаарах зээл	89,490	102,000
Төгрөгийн зээл	8,070	11,029
Гадаад валютын зээл	6,058	5,233
<b>Дотоодын банкуудад олгосон нийт зээл</b>	<b>384,300</b>	<b>341,506</b>
<b>Үнэ цэнийн бууралтаас өмнө</b>		
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(89,490)	(925)
<b>Дотоодын банкуудад олгосон нийт зээл</b>	<b>294,810</b>	<b>340,581</b>

**Үнэ тогтвортжуулалтын дэд хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл.** Банк нь 2012 оны 11 дүгээр сараас эхлэн шатахуун болон хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд 204,702 сая төгрөгийн зээлийг дотоодын банкуудад олгосон. Эдгээр дэд хөтөлбөр зээлийн нөхцөл, төлбөрийн хугацааг Засгийн газрын хамтарсан тушаалын дагуу тодорхойлсон ба Банк бие даан зээлийн нөхцлийг тодорхойлохгүй. Үүнээс гадна, Банкны санхүүжилтийн дагуу сонгогдсон аж ахуй нэгж байгууллагууд нь бусад банкуудаар дамжуулан тус зээлийг авч байна.

Засгийн газрын удирдамжийн дагуу бусад банкуудад олгосон зээлийн хүүгийн түвшин нь 0.89 хувь байгаа нь зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур байна. Анхны хүлээн зөвшөөрөлтын бодит үнэ цэнэ нь 186,924 сая төгрөг байв. Эдгээр зээлийн нэрлэсэн үнэ болон бодит үнэ цэнийн зөрүү нь 17,895 сая төгрөг тооцогдсон ба дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдсан. Тодруулга 3-аас харна уу.

**Буцаан худалдан авах гэрээ.** Буцаан худалдан авах хэлцэл нь бусад банкуудад олгосон богино хугацаатай болон тогтсон үнээр, тодорхой нэг өдөр буцаан худалдах нөхцөл бүхий Банкны үнэт цаасаар баталгаажсан (Тодруулга 15-аас харна уу) хөрөнгө оруулалтууд байдаг. Эдгээр үнэт цаасны дуусгавар хугацаа нь нэг хүртэлх сар бөгөөд жилийн 17.3 хувийн хүйтэй байдаг. Эдгээрийн дүн нь хугацаа хэтрээгүй ба үнэ цэнийн бууралтанд ороогүй болно.

**Анод банктай холбоотой зээл.** 2008 оны 12 дугаар сарын 12-нд Анод банкны богино хугацаанд төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор Банк Анод банк дахь Бүрэн эрхт төлөөлөгчидтэй зээлийн гэрээнд гарын үсэг зурсан. Зээлийн гол зорилго нь харилцагчдын хадгаламжийг “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай” хуулийн дагуу эргэн төлөх байсан бөгөөд дээрх хуулинд хэрэв өөр бусад банк нь дампуурсан тохиолдолд Монгол улсын Засгийн газар нь уг банкинд байршсан ард иргэдийн харилцах-хадгаламжийн дансны мөнгөнд буцаан төлөгдөх баталгааг өгнө хэмээн заажээ.

## 12 Дотоодын банкуудад олгосон зээл (Үргэлжлэл)

Зээлийн гэрээнд 147.9 тэрбум төгрөгийг зээлийн шугам тусгасан ба гэрээний нийт дүнгийн хязгаараас хэтрэхгүйгээр Анод банк нь хэсэгчлэн зээл авч болно. Хэсэгчилэн авсан зээл тус бүр нь анх олгогдсон өдрөөсөө 6 сарын дотор буцаан төлөгдөхөөр заасан. Зээлийн хүү нь 7 хоногийн Банкны үнэт цаасны хүйтэй тэнцүү ба зээл олгох уед Банкны долоо хоногийн хугацаатай үнэт цаасны хүү жилийн 9.75 хувьтай тэнцүү байв. Гэрээний дагуу хүүг 90 хоног бүр хуримтлуулж, Анод банкны харилцах данснаас шууд хасахаар заасан байна. Анод банкинд олгосон энэхүү зээл нь Анод банкны харилцагчиддаа олгосон 186.3 тэрбум төгрөгийн зээлээр баталгаажсан. Зээлийн анхны олголт нь гэрээнд гарын үсэг зурсан өдөр буюу 2008 оны 12 дугаар сарын 12-ны өдөр байсан.

Уг зээлийг эргэн төлөхөд хүндрэл учирсан тул, 2009 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн гэрээний хавсралтанд заасны дагуу зээлийн хугацааг 6 сараас 12 сар хүртэл болгон сунгасан. Мөн, 2009 оноос хойш хүүг хуримтлуулахыг зогсоосон ба 2010 ба 2011 онуудад зээлийн эргэн төлөлт муу байсан. Тиймээс 2010 ба 2011 онд шинээр ямар ч зээл олгогдоогүй бөгөөд Банк Монгол Улсын Засгийн газар болон Сангийн яамтай энэхүү зээлийг нөхөн төлүүлэх талаар тохиролцоо хийсээр ирсэн байна.

Өнгөрсөн тайлант хугацаанд (2011 онд) Банкны удирдлага нь Анод банкнаас авах зээлийн авлагыг Сангийн яамнаас гаргах Засгийн газрын бондоос эргүүлэн төлүүлэх замаар Монгол Улсын Засгийн газраас барагдуулна гэсэн дүгнэлттэй байсан тул 2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үнэ цэнийн бууралтын нөөц санг байгуулаагүй байсан. Гэсэн хэдий ч, Засгийн газрын бонд гаргалт нь Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэгдэн батлагдаагүй байна. Иймд тухайн зээлтэй холбогдон бий болох ирээдүйн мөнгөн ургалын дүн болон цаг хугацааны талаарх тодорхой бус байдлаас шалтгаалан Банк нь Анод банкны зээлийн үлдэгдэл үнэ цэнийн бууралтын нөөц санг 100 хувиар нөхөж байгуулсан байна. (Тодруулга 3-аас үзнэ үү)

**Төгрөгөөр олгосон зээл.** Төгрөгөөр олгосон зээлийн ихэнхи хувь буюу дотоодын банкуудад олгосон зээл нь нийт 6,100 сая төгрөг бөгөөд хүүгийн түвшин жилийн 22.25 хувь (2011 онд 5,000 сая төгрөг), Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ний дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон зээл нь 1,406 сая төгрөг (2011 онд 1,362 сая төгрөг) байна. Мөн түүнчлэн 2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дотоодын банкинд олгосон 4,667 сая төгрөгийн зээл байсан бөгөөд 2012 онд бүрэн төлөгдөж дууссан болно. Үлдсэн дүн нь хуримтлагдсан хүү юм.

Анод банкинд олгосон барьцаат зээлээс дотоодын банкинд олгосон зээлд шилжүүлж жилийн 12.25 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатайгаар олгогджээ. Уг зээл нь барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй бөгөөд эргэн төлөлтөд ямар нэгэн хүндрэл учраагүй байна.

2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк нь дотоодын банкуудтай жилийн 22.25 хувийн хүүтэй нийт 6,100 сая төгрөгийн овернайт зээл байршуулсан.

АХБ-тай холбоотой зээл нь Монголын хэд хэдэн дотоодын банкуудад олгогдсон бөгөөд 2 өөр хөтөлбөрийн дор дотоодын банкуудад үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ ажлын байрыг бий болгох, мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх зорилгоор олгогдсон. Нэгдүгээр хөтөлбөрийн дагуу зээл нь жилийн 10 хувийн (2011 онд 10 хувь) хүүтэй ба эргэн төлөлтийн хугацаа нь олгосон өдрөөс хамааран ялгаатай байна. Дараах хөтөлбөрийн зээл нь жилийн 5.5 хувийн (2011 онд 5.5 хувь) хүүтэй ба 1 жил хүртэлх хугацаанд эргэн төлөгдөх бөгөөд олгогдсон өдрөөс хамаараад ялгаатай байна. Банкны зээлийн эрсдэл нь зээлдэгчдийн эргэн төлөлтөөс хамаарахгүй бөгөөд Банк зээлийн төлөх хугацаа болмогц, тухайн дотоодын банкны данснаас хөрөнгө шууд татах эрхтэй. Удирдлагын уг зээлтэй холбоотой дүгнэлтийг Тодруулга 3-аас харна уу.

**Гадаад валютын зээл.** Валютаар олгосон зээлийн дийлэх хувийг жижиг болон дунд хэмжээний аж ахуй нэгжүүдийг дэмжих зорилгоор дотоодын банкуудад олгосон 5,435 сая төгрөгийн (2011 онд 4,525 сая төгрөг) зээл, банкуудын мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, банкны системийг сайжруулах зорилгоор олгосон 623 сая төгрөгийн (2011 онд 657 сая төгрөг) зээл бүрдүүлж байна. Үлдсэн дүн нь хуримтлагдсан хүү болно.

Герман Улсын Засгийн газраас Монгол Улсын жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор дотоодын банкуудад олгосон зээл нь бие даасан хоёр дахь санхүүжилтийн хөтөлбөр нь “KfW”-аар дамжин хэрэгжиж байна. Энэхүү зээлийн хөтөлбөртэй холбоотой болон Банк Сангийн яамд төлөх бусад өглөгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 15-аас харна уу. Эдгээр зээл нь дунджаар жилийн 1.25-1.75 хувийн (2011 онд 1.25-1.75 хувь) хүүтэй бөгөөд ямар нэгэн үнэт цаасаар баталгаажаагүй байна. Эдгээр зээл нь Германы Засгийн газрын шалгуурт нийцсэн дотоодын гурван банкаар дамжин зээлдэгчдэд хүрч байгаа юм.

## 12 Дотоодын банкуудад олгосон зээл (Үргэлжлэл)

Банкны зээлийн эрсдэл нь зээлдэгчдийн энхүү зээлийг эргэн төлөхөөс хамааралгүй, учир нь Банк зээлийн төлөх хугацаа болмогц, шууд тухайн дотоодын банкны харилцах данснаас хөрөнгө татах чадвартай. Удирдлагын энхүү зээлтэй холбоотой дүгнэлтийг Тодруулга 3-аас харна уу. Дотоодын банкны ажилтнуудын ур чадварыг дээшлүүлж, банкны системийг сайжруулах зорилготой зээл нь Монгол улс ба Азийн Хөгжлийн Банкны хооронд байгуулагдсан гэрээний дагуу “Ди-Эй-Ай” (Тайланд) лимитед компаний “Банкны Сургалтын Төв” дээр банкны ажилтнуудад явуулсан сургалтыг санхүүжүүлэх зорилгоор олгогдсон зээл бөгөөд эргэн төлөгдөх хугацаа нь 14 жил.

2012 оны хэмжээнд зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг доор харуулав:

Сая төгрөгөөр	Төгрөгөөр олгосон Зээл	Анод Банктай холбоотой зээл	Нийт
<b>2012.01.01-ний байдлаар</b>	<b>925</b>	-	<b>925</b>
<b>Зээлийн найдваргүй авлагын сан</b>			
(Өөрчлөлт) Найдваргүй авлагын сан (Тодруулга 24)	(925)	89,490	<b>88,565</b>
<b>2012.12.31-ний байдлаар найдваргүй авлагын сан</b>	-	<b>89,490</b>	<b>89,490</b>

2011 он болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Үнэ тогтвортжуулалтын дэд хөтөлбөр, буцаан худалдан авах болон Гадаад валют дахь зээлүүдийн хувьд үнэ цэнэ буурах шинж тэмдэг илрээгүй тул үнэ цэнийн алдагдлын сан байгуулаагүй болно. Тодруулга- 3-аас үзнэ үү.

Мөн 2011 оны туршид зээлийн үнэ цэнийн санд ямар нэгэн хөдөлгөөн гараагүй болно. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн чанарын үзүүлэлтийг дор үзүүлэв:

Сая төгрөгөөр	Үнэ тогтвортжуулалтын төслийн зээл	Урвуу репо хэлцэл	Анод Банктай холбоотой зээл	Төгрөгөөр олгосон зээл	Гадаад валютаар олгосон зээл	Нийт
<i>Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй</i>						
-В	103,927	62,959	-	396	5,638	<b>172,920</b>
-Зэрэглэлгүй	84,433	29,363	-	7,674	420	<b>121,890</b>
<b>Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй</b>	<b>188,360</b>	<b>92,322</b>	-	<b>8,070</b>	<b>6,058</b>	<b>294,810</b>
<i>Дангаараа үнэ цэнэ буурсан зээлүүд</i>						
- 360-аас дээш хоногоор хугацаа нь хэтэрсэн	-	-	89,490	-	-	<b>89,490</b>
<b>Нийт дангаараа үнэ цэнэ буурсан зээлүүд</b>	-	-	<b>89,490</b>	-	-	<b>89,490</b>
<i>Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан</i>						
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан	-	-	(89,490)	-	-	<b>(89,490)</b>
<b>Нийт дотоодын банкуудад олгосон нийт зээлийн дүн</b>	<b>188,360</b>	<b>92,322</b>	-	<b>8,070</b>	<b>6,058</b>	<b>294,810</b>

## 12 Дотоодын банкуудад олгосон зээл (Үргэлжлэл)

2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн эрсдэлийн үзүүлэлтийг дор үзүүлэв:

Сая төгрөгөөр	Урвуу репо	Анод	Төгрөг-	Гадаад	Нийт
	хэлцэл	банктай	өөр	Валютаар	
		холбоотой	олгосон	олгосон	
		зээл	зээл	зээл	
<i>Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй</i>					
BB- зэрэглэлтэй	200,486	-	5,000	3,711	<b>209,197</b>
B+ зэрэглэлтэй	-	-	5,020	-	<b>5,020</b>
Зэрэглэлгүй	22,758	-	1,009	1,522	<b>25,289</b>
<b>Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй</b>	<b>223,244</b>	-	<b>11,029</b>	<b>5,233</b>	<b>239,506</b>
<i>Дангаараа үнэ цэнэ нь буурсан зээлүүд</i>					
- 360-аас дээш хоногоор хугацаа нь хэтэрсэн	-	102,000	-	-	<b>102,000</b>
<b>Нийт дангаараа үнэ цэнэ буурсан зээлүүд</b>	<b>-</b>	<b>102,000</b>	-	-	<b>102,000</b>
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан	-	-	(925)	-	(925)
<b>Нийт дотоодын банкуудад олгосон зээл</b>	<b>223,244</b>	<b>102,000</b>	<b>10,104</b>	<b>5,233</b>	<b>340,581</b>

Тодруулга 27-д дурдсанчлан, Монголын томоохон дотоодын банкууд нь олон улсын үнэлгээний байгууллагуудаар зэрэглэлээ тогтоолгодог. Дээрх шинжилгээ нь олон улсын үнэлгээний байгууллагад тогтоосон хамгийн бага зэрэглэлд сууринлас болно. Зэрэглэлгүй дотоодын банкуудыг, Банк тэдгээр банкуудын сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэл, зохицой харьцааны шинжилгээ болон холбогдох зээлийн эрсдэлийг тодорхойлоход хэрэглэдэг бусад олдоцтой мэдээлэлд тулгуурлан санхүүгийн байдалд дүгнэлт гаргадаг.

2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх барьцаа хөрөнгийн талаарх мэдээлэл:

Сая төгрөгөөр	Үнийн	Урвуу	Анод	Гадаад	Нийт
	тогтворжуулал- тын зээл	репо	банкинд	Төгрөгөөр	
	хэлцэл	хамаарах	олгосон	олгосон	
	зээл	зээл	зээл	зээл	
Баталгаажаагүй	188,360	-	-	8,070	6,058 <b>202,488</b>
Барьцаа хөрөнгөөр баталгаажсан зээл:					
- Төв банкнаас гаргасан үнэт цаас	-	92,322	-	-	- <b>92,322</b>
- Арилжааны зээл	-	-	89,490	-	- <b>89,490</b>
<b>Барьцаа хөрөнгөөр баталгаажсан зээл</b>	<b>-</b>	<b>92,322</b>	<b>89,490</b>	-	<b>- 181,812</b>
<b>Найдваргүй авлагын санг хасаж тооцоохос өмнөх нийт зээлийн дүн</b>	<b>188,360</b>	<b>92,322</b>	<b>89,490</b>	<b>8,070</b>	<b>6,058 384,300</b>

## 12 Дотоодын банкуудад олгосон зээл (Үргэлжлэл)

Буцаан худалдах болон буцаан худалдан авах гэрээнд Тодруулга 15-д толилуулсны дагуу холбогдох банкнуудад олгосон Банкны үнэт цаасаар баталгаажсан зээл багтана. Энэ санхүүгийн хэрэгслүүд нь барьцаа өндөртэй гэж тооцогддог. Банкны журмын дагуу 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Банкны үнэт цаасны дансны үнэ нь буцаан худалдах болон буцаан худалдан авах гэрээнд заагдсан дүнтэйгээ ойролцоо байсан. Анод банктай холбоотой зээлийн барьцаат хөрөнгийн мэдээллийг доор толилуулав.

2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар барьцаат хөрөнгийн талаарх мэдээлэл:

Cая төгрөгөөр	Урвуу репо хэлцэл	Анод Банктай холбоотой зээл	Төгрөгөөр олгосон зээл	Гадаад Валютаар олгосон зээл	Нийт
Баталгаажаагүй	-	-	11,029	5,233	<b>16,262</b>
Барьцаа хөрөнгөөр баталгаажсан зээл:					
-Төв банкнаас гаргасан үнэт цаас	223,244	-	-	-	<b>223,244</b>
- Арилжааны зээл	-	102,000	-	-	<b>102,000</b>
 <b>Барьцаа хөрөнгөөр баталгаажсан зээл</b>	<b>223,244</b>	<b>102,000</b>		-	<b>325,244</b>
 <b>Найдваргүй авлагын санг хасаж тооцохоос өмнөх нийт зээлийн дүн</b>	<b>223,244</b>	<b>102,000</b>	<b>11,029</b>	<b>5,233</b>	<b>341,506</b>

Анод банкны Бүрэн эрхт төлөөлөгчтэй хийсэн зээлийн гэрээнд зааснаар Анод банкны зээлийн багц энэхүү зээлийн баталгаа болж байгаа бөгөөд дээр дурдсанчлан энэхүү зээлийн эргэн төлөлтийг Засгийн газрын бонд гарган төлөхөөр хүлээгдэж байгаа бөгөөд Улсын Их Хурал бонд гаргах зөвшөөрөл олгоно. Гэхдээ ямар нэгэн албан ёсны гэрээ хийгдээгүй байна. Анод банк одоогоор татан буугдах үе шатандаа байгаа бөгөөд Банкны удирдлага Анод банкны харилцагчиддаа олгосон зээлийн нөхөн төлөгдөх хэмжээг тодорхойлох ба барьцаа хөрөнгийн хэмжээ нь хангалттай эсэх талаарх мэдээллийг гаргах боломжгүй байна.

### 13 Үндсэн хөрөнгө ба Биет бус хөрөнгө

<i>Сая төгрөгөөр</i>	<i>Барилга байгууламж</i>	<i>Дуусаагүй барилга</i>	<i>Тавилга, компьютер тоног төхөөрөмж</i>	<i>Нийт үндсэн хөрөнгө</i>	<i>Биет бус хөрөнгө</i>	<i>Нийт</i>
2011 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар өртөг Хуримтлагдсан элэгдэл/хорогдол	23,516	137	8,339	31,992	2,077	34,069
(3,002)	-	(4,402)	(7,404)	(1,097)	(8,501)	
<b>2011 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар дансны үнэ</b>	<b>20,514</b>	<b>137</b>	<b>3,937</b>	<b>24,588</b>	<b>980</b>	<b>25,568</b>
Нэмэгдсэн	404	396	987	1,787	179	1,966
Хасагдсан	-	-	(2)	(2)	-	(2)
Акталсан	-	-	(4)	(4)	-	(4)
Элэгдэл/хорогдол (Тодруулга 25)	(384)	-	(986)	(1,370)	(155)	(1,525)
<b>2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дансны үнэ</b>	<b>20,534</b>	<b>533</b>	<b>3,932</b>	<b>24,999</b>	<b>1,004</b>	<b>26,003</b>
2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өртөг эсвэл үнэлгээ Хуримтлагдсан элэгдэл/хорогдол	23,920	533	9,320	33,773	2,256	36,029
(3,386)	-	(5,388)	(8,774)	(1,252)	(10,026)	
<b>2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дансны үнэ</b>	<b>20,534</b>	<b>533</b>	<b>3,932</b>	<b>24,999</b>	<b>1,004</b>	<b>26,003</b>
Нэмэгдсэн	814	-	1,652	2,466	108	2,574
Хасагдсан	-	-	(138)	(138)	-	(138)
Шилжүүлсэн	499	(499)	-	-	-	-
Данснаас хассан	-	-	(8)	(8)	-	(8)
Элэгдэл/хорогдол (Тодруулга 25)	(389)	-	(1,140)	(1,529)	(271)	(1,800)
<b>2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дансны үнэ</b>	<b>21,458</b>	<b>34</b>	<b>4,298</b>	<b>25,790</b>	<b>841</b>	<b>26,631</b>
2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өртөг Хуримтлагдсан элэгдэл	25,233	34	10,826	36,093	2,364	38,457
(3,775)	-	(6,528)	(10,303)	(1,523)	(11,826)	
<b>2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дансны үнэ</b>	<b>21,458</b>	<b>34</b>	<b>4,298</b>	<b>25,790</b>	<b>841</b>	<b>26,631</b>

### 13 Үндсэн хөрөнгө ба Биет бус хөрөнгө (Үргэлжлэл)

Монгол улсад мөрдөгдөж буй хуулийн дагуу Банк нь 5 жилд нэг удаа барилгаа дахин үнэлэх үүрэгтэй. Хамгийн сүүлд Хөрөнгө Үнэлгээний Төв ХХК-ны хөндлөнгийн үнэлгээчдээр 2008 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дахин үнэлгээг хийлгэсэн.

Банк 2012 онд нягтлан бodoх бүртгэлийн бодлогоо өөрчилсөн ба жил бүр бодит үнэ цэнийн үнэлгээ хийх бөгөөд дансны үнэ болон тухайн үеийн зах зээлийн үнэ хоорондын зөрүү үлэмж их байвал дансны үнийг залруулна хэмээн нэмсэн. Удирдлага 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ны байдлаарх барилгын үлдэх өртөг нь барилгын бодит үнэ цэнэтэй ойролцоо байгаа гэж үзэж байна.

Хэрэв дундаж үнэ нь одоогийн бүртгэлийн үлдэгдлээс 20 хувиар илүү байвал барилгын үлдэх өртөг болон бусад нөөцийн сангийн дахин үнэлгээний нөөц 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дунджаар 4,292 тэрбум (2011 оны 12 сарын 31-ний байдлаар 4,106 тэрбум төгрөг)-өөр өснө. Дундаж үнэ нь одоогийн үлдэгдэлтэй харьцуулбал 20 хувиар бага байвал барилгын үлдэгдэл өртөг болон банкны дахин үнэлгээний нөөц 2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дунджаар 4,292 тэрбум (2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 4,103 тэрбум төгрөг)-өөр хорогдоно. Удирдлага банкны барилгын үнэ цэнийн бууралт нь одоогийн зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан гажуудаж байгаа гэж үзэж байгаа тул санхүүгийн тайланг ашиглагчдын хувьд барилгын үнэ цэнэ аливаа өсөлт нь санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж итгэж байна.

Дахин үнэлгэдсэн барилга нь түүхэн өртгөөрөө бүртгэгдсэн бол 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Санхүүгийн тайланд энхүү барилгын дансны үнэ 14,899 сая (2011 онд 13,848 сая) төгрөг байх байсан.

Барилгын үлдэх өртөг нь 1,641 сая (2011 онд 1,666 сая) төгрөгөөр дансанд бүртгэгдсэн ба Тодруулга 18 -д харуулснаар зээлийн баталгаа болон бүртгэгдсэн байна.

### 14 Бусад хөрөнгө

Сая төгрөгөөр	Тодруулга	2012.12.31	2011.12.31
<b>Бусад санхүүгийн хөрөнгө</b>			
Аж ахуйн нэгжүүдээс авах авлага		43,896	43,946
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах авлага		12,169	12,208
Санхүүгийн хэрэгсэл дериватив		834	2,002
Сангийн яамнаас авах хуримтлагдсан хүүгийн авлага	28	-	3,177
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан		(56,065)	(56,154)
<b>Бусад санхүүгийн бус хөрөнгө</b>			
Урьдчилж төлсөн зардал		6,217	870
Бусад		370	99
<b>Нийт бусад хөрөнгө</b>		<b>7,421</b>	<b>6,148</b>

Аж ахуйн нэгжүүдээс авах авлагад өмнөх жилд Банктай хийсэн алтны опцион хэлцлийнхээ үүргийг биелүүлээгүй алт олборлогч компаниудаас авах 26,632 сая төгрөг (2011 онд 26,769 сая төгрөг)-ийн авлага орж байгаа ба эдгээр авлага найдваргүйд тооцон үнэ цэнийн бууралтын санг бүрэн байгуулсан. Банк үүнээс хойш ямар нэгэн алтны опцион хэлцэл хийгээгүй байна. Мөн 2011 оны 12 дугаар сарын 31-ний ба 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Аж ахуйн нэгжүүдээс авах авлагын үлдэгдэл дунг найдваргүйд тооцсон байна.

Эдгээр үлдэгдлүүд нь 2005-2007 онуудад хамаарах ба Банк нь Төв банкны тухай хуулийн 23-р зүйлийн “Засгийн газар болон банкнаас бусад хуулийн этгээд, иргэний мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалах, төлбөр тооцоо хийх, зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байсан. Банкны удирдлага нь үүнтэй холбогдуулан “Үнэт металл олборлогч, арилжаалагчдын хүснэлтээр арилжаа хийхэд мөрдөх журам” -ыг 2003 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Банкны Ерөнхийлөгчийн 99 дүгээр тушаалаар баталсан. Уг журмын дагуу Банк нь өөрсдийн дотоод үйл ажиллагаанд шалгالت хийж, дээрхийг тогтоосон.

## 14 Бусад хөрөнгө (Үргэлжлэл)

Гадаадын санхүүгийн байгууллагаас авах заргыг бүхэлд нь найдвартай авлагад тооцсоны шалтгаан нь тэдгээр байгууллагуудын үйл ажиллагаа зогсонтой холбоотой байна.

Бусад санхүүгийн бус хөрөнгө үндсэндээ урьдчилгаа төлбөр, ажилтнуудад олгосон урьдчилгаа, хангамжийн материал болон бичиг хэргийн материалаас бүрдэнэ. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар урьдчилж төлсөн зардал нь 2012 онд гаргаж төлөгдсөн бөгөөд 2013 онд хүргэгдэхээр хүлээгдэж буй банкны өрийн бичигтэй холбоотой.

2011 ба 2012 оны санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг дор харуулав:

Сая төгрөгөөр	2012.12.31	2011.12.31
01 дүгээр сарын 01-ний байдлаар	56,154	54,917
Гадаад валютаарх сангийн ханшийн хөрвүүлэг	(140)	4,773
Үнэ цэнийн бууралтын сангийн алдагдал (Тодруулга 24)	218	-
Үнэ цэнийн бууралтын сангины буцаалт (Тодруулга 24)	(167)	(3,536)
<b>12 дугаар сарын 31-ний байдлаар</b>	<b>56,065</b>	<b>56,154</b>

## 15 Төв банкны үнэт цаас

Сая төгрөгөөр	2012.12.31	2011.12.31
Төв Банкны Үнэт Цаас	752,151	879,113
<b>Нийт Төв Банкны Үнэт Цаас</b>	<b>752,151</b>	<b>879,113</b>

Энэхүү үлдэгдэл нь Банкнаас дотоодын банкуудад гаргасан үнэт цаас юм. Эдгээр үнэт цаасны дуусах хугацаа нь 7- 28 долоо хоног (2011 онд 7- 24 долоо хоног) бөгөөд 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хүүгийн түвшин нь 13.25 хувь -17.25 хувь (2011 онд 10.4 хувь - 16.25 хувь) байв. Банк нь үнэт цаасыг инфляцийн түвшинг хянах, илүүдэл мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтээс гаргах зорилгоор ашигладаг.

## 16 Төрийн байгууллагуудад төлөх өр төлбөр

Сая төгрөгөөр	2012.12.31	2011.12.31
Сангийн яамд төлөх зээлийн өр төлбөр		
- Германы Засгийн газар (ГУЗГ)	13,443	13,741
- Азийн Хөгжлийн Банк (АХБ)	6,990	7,055
Сангийн яамны харилцах, хадгаламж	2,939,253	1,150,094
<b>Төрийн Байгууллагуудад төлөх Нийт Өр Төлбөр</b>	<b>2,959,686</b>	<b>1,170,890</b>

**Сангийн яамны дансууд.** Эдгээр харилцах дансууд нь Банкинд байршуулсан Сангийн яамны харилцах дансууд юм.

Олон улсын байгууллагуудаас авсан зээллэгтэй холбоотойгоор Сангийн яамд төлөх өр төлбөр.

Эдгээр нь Монгол улсын Засгийн газраас “KfW” (Герман улсын Засгийн газрыг төлөөлж) болон Азийн Хөгжлийн Банктай (цаашид “АХБ” гэх) байгуулсан зээлийн гэрээтэй холбоотой. Энэхүү зээлд Монгол улсын Сангийн яам хэрэгжүүлэгч агентаар, Банк нь энэ төслийг хэрэгжүүлэгчээр ажиллаж байна.

KfW газраас авсан зээл нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилготой 1995 он болон 2003 оны хөтөлбөрийн дагуу олгогдсон. Эдгээр зээлүүд нь Еврогоор олгогдсон бөгөөд жилийн 0.75 хувийн хүүтэй, 40 жилийн хугацаатай (2011 онд жилийн хүү 0.75 хувь). 2012 оноос эхлэн зээлийн үндсэн төлбөр төлөгджээхэлсэн.

## 16 Торийн байгууллагуудад толох өр толбөр (Үргэлжлэл)

АХБ-аас авсан зээл нь Монголд ядуурлыг бууруулах, хувийн бизнесийн салбарыг хөгжүүлэх, Засгийн газарт болон төрийн бус байгууллагууд, банкуудад зөвлөгөө өгөх, сургалт явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгогджээ. Зээлийн гэрээнүүд нь 1994, 1997 онуудад байгуулагдсан ба жилийн хүү нь 1-1.5 хувь (2011 онд жилийн хүү нь 1- 1.5 хувь), дуусгавар хугацаа нь 30- 40 жил байна.

Сангийн яам нь Монгол улсын Засгийн газрыг төлөөлөн хэрэгжүүлэгч агентийн үүрэг гүйцэтгэдэг учир Банк KfW болон АХБ-д төлбөр тооцоонд шууд хариуцлага хүлээхгүй. Гэхдээ эдгээр зээлийн төслүүдийг хэрэгжүүлэгчийн хувьд Банк нь зээлийн хөрөнгийг дотоодын банкуудад оновчтой хуваарилах үүрэгтэй бөгөөд тэдгээр дотоодын банкууд нь KfW болон АХБ-ны шалгуурт тэнцсэн зээлийн эцсийн хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагааг хариуцна. Сангийн яам ба Банк хоорондын гэрээний дагуу Банк нь Сангийн яамнаас KfW болон АХБ-ны гэрээний ижил нөхцөлтэйгээр эдгээр зээлүүдийг авсан байна. Банк нь эдгээр зээлийн хөрөнгийг өөрийн дансанд байршуулж буйн хувьд, KfW ба Сангийн яамны хоорондын төлбөр тоог зохицуулах үүрэгтэй. Энэхүү зээлийн хөрөнгөөс дотоодын банкуудад олгосон зээлийн талаар Тодруулга 12-д харуулав. Энэхүү Сангийн яамд төлөх өглөг болон дотоодын банкуудад олгосон зээлийн талаарх Банкны удирдлагын дүгнэлтийг Тодруулга 3-аас харна уу.

Холбоотой талуудын ажил гүйлгээ, тэдгээрийн үлдэгдлийг Тодруулга 31-д харуулав.

## 17 Дотоодын банкны хадгаламж

Сая төгрөгөөр	2012.12.31	2011.12.31
Харилцах дансууд:		
- төгрөгөөр	842,958	645,501
- валютаар	528,713	369,729
<b>Нийт дотоодын банкны хадгаламж</b>	<b>1,371,671</b>	<b>1,015,230</b>

Эдгээр дансны дүн нь дотоодын банкуудаас Банкинд зайлшгүй байлгах нөөц болон бусад төрлийн хадгаламжуудаас бүрдэнэ. Зайлшгүй байлгах нөөцийг банкууд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тодорхой хувиар тооцож тогтооно.

## 18 Гадаад өр толбөр

Сая төгрөгөөр	2012.12.31	2011.12.31
<b>Барьцаатай</b>		
Лондонгийн HSBC-ээс авсан зээл	389	565
<b>Барьцаагүй</b>		
БНХАУ-ын Ардын банк	470,788	-
Олон Улсын Валютын Сан ("ОУВС"):		
- ОУВС дахь данс No.1	272	272
- ОУВС дахь данс No.2	6	6
- ЗТЭ-ийн хуваарилалт	104,628	104,197
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	87	256
ОУХА-д оруулсан хувь хөрөнгө	34	34
Дэлхийн банкны харилцах данс	210	77
АХБ-ны харилцах данс	-	5
<b>Нийт Гадаад өр толбөр</b>	<b>576,414</b>	<b>105,412</b>

**Лондонгийн HSBC-ээс авсан зээл.** Энэ нь үндсэн хөрөнгийн худалдан авалтыг санхүүжүүлэх зорилгоор Лондонгийн HSBC банкнаас 10 жилийн хугацаатайгаар авсан зээл юм. Үндсэн зээлийн эргэн төлөлт нь 2005 онд эхэлсэн бөгөөд хүүгийн түвшинг HSBC банкны жилийн үндсэн хүүн дээр

## 18 Гадаад өр төлбөр (Үргэлжлэл)

1.75 хувийг нэмж тооцдог. Зээлийн барьцаанд Тодруулга 13-д танилцуулсан барилгыг тавьсан.

**Хятадын Ардын банкнаас авсан зээл.** Энэхүү үлдэгдэл нь Хятадын Ардын банкнаас дотоодын банкуудад хятадын юанийг төгрөгөөр худалдах зорилгоор авсан сарын хугацаатай хятадын юанийн зээл юм. Хятадын Ардын банкнаас авсан зээлийн хуримтлагдсан хүүгийн тооцоолол нь “200 bps” суурь дээр Шанхай-Интер банкны санал болгосон түвшинг (“SHIBOR”) нэмсэн хүүгийн түвшинд суурилсан ба ашигласан хятадын юаньтай холбоотой хүүгийн зардлыг харуулна. Тодруулга 26-г харна уу.

**Зээлжих тусгай эрхийн хуваарилалт.** ОУВС-ын гишүүн орнуудад ОУВС-д оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн ЗТЭ хуваарилсан. Энэ хуваарилалт нь Банкны ОУВС-нд өгөх өр төлбөрийг илэрхийлэх ба үүний оронд ОУВС-аас ЗТЭ-ийн авсан. Тодруулга 7-г харна уу. Энэ хуваарилалтын цэвэр хуримтлал нь 104,628 сая төгрөг (2011 онд 104,197 сая төгрөг) буюу 48,757 сая ЗТЭ (2011 онд 48,757 сая ЗТЭ) –тэй тэнцүү болоод байна.

**Дэлхийн банк ба Олон улсын хөгжлийн агентлагт оруулсан хувь хөрөнгө.** Энэ үлдэгдэл нь Банкнаас Дэлхийн Банк болон Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-т оруулсан хувь хөрөнгө юм.

## 19 Бусад өр төлбөр

Сая төгрөгөөр	Тодруулга	2012.12.31	2011.12.31
<b>Бусад санхүүгийн өр төлбөр</b>			
Дотоодын банкны дүрмийн санд анх оруулсан хөрөнгийн хэмжээ		2,000	3,000
Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж		7,030	4,061
Санхүүгийн хэрэгсэл дериватив	28	1,233	-
Бусад өр төлбөр		6,545	6,653
<b>Бусад өр төлбөр</b>			
Нийгмийн хөгжлийн сан		9,209	8,740
Аkkreditivийн заргатай холбоотой байгуулсан сан		36,464	35,618
<b>Нийт бусад өр төлбөр</b>		<b>62,481</b>	<b>58,072</b>

Дотоодын банкны дүрмийн санд анх оруулсан хөрөнгийн хэмжээ нь Монгол Улсын дотоодын банкны дүрмийн санг нэмэгдүүлсэнтэй холбоотой нээсэн тусгайлсан дансууд юм. Эдгээр дансуудыг тухайн дотоодын банкууд хөрөнгө оруулалт хийх гэх мэт зорилгоор хэрэглэхээс бусад тохиолдолд хязгаарлалттай. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дүрмийн санд анх оруулсан хөрөнгийн хэмжээ нь Кредит банкны дүрмийн сангийн нэмэгдэлтэй холбоотой (2011 онд Хадгаламж Банк).

Банк дотоод журмынхаа дагуу тодорхой хэмжээний хөрөнгийг өөрсдийн ажилтнуудын ажлын нөхцөл болон амьжирааны нөхцлийг сайжруулах зорилгоор Нийгмийн хөгжлийн санд хуваарилдаг. Энэхүү хөрөнгө Банкны ажилтнуудын тэтгэвэр тэтгэмжийг олгох, Банкны ажилтнуудад зориулан барилж буй орон сууцыг санхүүжүүлэх болон хэрэгцээтэй үед нь ажилтнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зориулагдсан байна. Банкны удирдлага 2011 оны 12 дугаар сарын 31 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгийг хүлээгдэж буй үүргээ биелүүлэхэд хангалттай байсан гэж үзсэн. Холбогдох зардлуудыг Тодруулга 25-аас харна уу.

2013 онд хугацаа нь дусах дотоодын банкуудтай байгуулсан дериватив санхүүгийн хэрэгслүүд нь шатахууны үнийг тогтвортжуулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд байгуулсан своп, форвард хэлцэлийн зээлийг зайлшгүй баталгаажсан тохиолдолд тайллагнах шаардлагатай. Тодруулга 28-аас харна уу.

Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж нь төрийн байгууллага болох Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн хадгаламжтай холбоотой.

## **19 Бусад өр төлбөр (Үргэлжлэл)**

Аkkредитивийн заргатай холбоотой байгуулсан сан нь 2008 онд үүссэн шийдэгдээгүй хэрэгтэй холбоотой үүссэн. Удирдлага энэхүү заргаас алдагдал хүлээх магадлалтай гэж тооцсон тул холбогдох төлбөрийн санг 2009 онд байгуулсан юм. 2010 болон 2011 оны туршид гадаад валютын ханшийн хэлбэлзлийн нөлөөнөөс гадна нөөцийн санд өөрчлөлт ороогүй. Дэлгэрэнгүйг Тодруулга 26-оос харна уу. Аkkредитивтай холбоотой хэсэг нь тодруулга 26-д дурдсан экспортийн аккредитивийн хэмжээнд багтаж байгаа.

## **20 Дүрмийн сан болон бусад нөөц**

<i>Сая төгрөгөөр</i>	<b>2012.12.31</b>	<b>2011.12.31</b>
<b>Дүрмийн Сан</b>	5,000	5,000

Банкны 100 хувийг Төрийн өмч эзэлдэг. Дүрмийн сан нь Банкны өөрийн хөрөнгө юм. Монгол Улсын Төв Банкны тухай хуулийн дагуу тухайн жилийн цэвэр ашгийн 40 хувиас доошгүй хувийг Ерөнхий нөөцийн санд хуваарилж, үлдэх хэсгийг (хамгийн ихдээ 60%) Улсын төсөвт шилжүүлдэг. Тиймээс Ерөнхий нөөцийн сан нь хуримтлуулсан цэвэр ашгийн 40 хувиас доошгүй хуваарилдаг ба үүнийгээ Банк бүрэн захиран зарцуулах эрхтэй. Энэхүү нөөцийн санд Улсын төсөвт өмнө нь шилжүүлсэн болон ирээдүйд шилжүүлэх дүнг оруулахгүй. Учир нь эдгээр нь тухайн жилдээ Засгийн газарт шилжүүлдэг. Банк нь 2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тухайн жилд үүссэн их хэмжэний алдагдлыг авч үзсний үндсэн дээр ерөнхий нөөцийн дүнг хуримтлагдсан ашигт шилжүүлэхээр шийдвэрлэсэн. 2011 болон 2012 онуудад ерөнхий нөөц рүү шилжүүлэг хийгээгүй нь 2011 оны ашиг нь ихэвчлэн холбогдох бусад нөөцөд шилжүүлсэн байсан ба гадаад валютын ханшийн тэгшигтгэлийн бодит бус ашиг болон үнэт металын дахин үнэлгээний бодит бус ашгаас үүссэн болон 2012 онд алдагдалтай ажилласантай холбоотой.

Бусад нөөцийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

<i>Сая төгрөгөөр</i>	<b>2012.12.31</b>	<b>2011.12.31</b>
Валютын дахин үнэлгээний сан	106,527	92,326
Үнэт металын дахин үнэлгээний сан	36,080	20,789
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сан	7,788	7,788
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний сан	(342)	42
<b>Нийт бусад нөөц</b>	<b>150,053</b>	<b>120,945</b>

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 2-оос харна уу.

## **21 Хүүгийн Орлого ба Зардал**

<i>Сая төгрөгөөр</i>	<b>2012</b>	<b>2011</b>
<b>Хүүгийн орлого</b>		
Дотоодын банкуудад олгосон зээл	20,022	2,356
Засгийн газрын үнэт цаас – хямдруулсан өртгөөр	17,279	4,975
Төрийн байгууллагуудад олгосон зээл	15,753	3,177
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	3,489	6,796
Санхүүгийн хэрэгсэл – борлуулахад бэлэн	1,157	2,152
Бусад хүүгийн орлого	1,649	213
<b>Нийт хүүгийн орлого</b>	<b>59,349</b>	<b>19,669</b>
<b>Хүүгийн зардал</b>		
Төв банкны үнэт цаас	(84,351)	(114,938)
БНХАУ Ардын Банк	(10,042)	-
Төрийн байгууллагуудад төлөх өр төлбөр	(9,778)	(3,841)
Бусад хүүгийн зардал	(602)	(202)
<b>Нийт хүүгийн зардал</b>	<b>(104,773)</b>	<b>(118,981)</b>
<b>Цэвэр хүүгийн зардал</b>	<b>(45,424)</b>	<b>(99,312)</b>

## 22 Алт ба үнэт металын арилжааны цэвэр орлого

<i>Сая төгрөгөөр</i>	<b>2012</b>	<b>2011</b>
Алтны дахин үнэлгээний бодит бус ашиг	15,291	14,331
Алтны арилжааны орлого	3,604	22,503
Бусад үнэт металын арилжаа	1,858	6,827
Тээвэрлэлт ба цэвэршүүлэлтийн зардал	(304)	(231)
<b>Алт ба үнэт металын арилжааны цэвэр орлого</b>	<b>20,449</b>	<b>43,430</b>

## 23 Валютын ханшийн зөрүүний ашиг алдагдал

<i>Сая төгрөгөөр</i>	<b>2012</b>	<b>2011</b>
Валютын ханшийн зөрүүний бодит бус ашиг/(алдагдал)	14,201	222,769
Валютын ханшийн зөрүү болон арилжааны бодит ашиг/(алдагдал)	(37,937)	29,416
Валютын зөрүүний бусад ашиг/(алдагдал)	42	121
<b>Валютын ханшийн зөрүүнээс олсон Ашиг - Алдагдал</b>	<b>(23,694)</b>	<b>252,306</b>

## 24 Үнэ цэнийн бууралтын сангийн буцаалт (нөөц)

<i>Сая төгрөгөөр</i>	<i>Тодруулга</i>	<b>2012</b>	<b>2011</b>
Бусад хөрөнгө	14	51	3,536
Дотоодын банкуудад олгосон зээл	12	(88,565)	-
<b>Найдваргүй авлагаас нөхөн төлөгдсөн нийт дүн</b>		<b>(88,616)</b>	<b>3,536</b>

## 25 Удирдлагын ба үйл ажиллагааны бусад зардал

<i>Сая төгрөг</i>	<i>Тодруулга</i>	<b>2012</b>	<b>2011</b>
Хүний нөөцийн зардал		7,788	8,268
Мөнгөн дэвсгэрт хэвлүүлэх зардал		3,274	6,203
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн элэгдэл/хорогдол	13	1,800	1,525
Хуулийн болон мэргэжлийн үйлчилгээний хөлс		928	3,060
Харилцаа холбооны зардал		794	900
Харуул хамгаалалтын зардал		787	605
Тээврийн болон албан томилолтын зардал		459	384
Ашиглалтын зардал		409	384
Гишүүнчлэл болон мэргэжлийн үйлчилгээний зардал		390	497
Зар сурталчилгааны зардал		335	155
Сургалтын зардал		256	339
Акталсан үндсэн хөрөнгө		117	46
Үйл ажиллагааны бусад зардал		1,454	567
<b>Нийт удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардал</b>		<b>18,791</b>	<b>22,933</b>

Хүний нөөцийн зардал нь Нийгмийн хөгжлийн сангийн 2,000 сая төгрөг (2011 онд 4,000 сая төгрөг)-ийн зардал, 2012 оны цалин ба урамшууллын 5,192 сая төгрөг (2011 онд 3,581 сая төгрөг), нийгмийн даатгалын 596 сая төгрөг (2011 онд 652 сая төгрөг)-ийн зардлуудаас бүрдэнэ. Нийгмийн даатгал болон тэтгэвэрийн сангийн зардалд 379 сая төгрөг (2011 онд 415 сая төгрөг) зарцуулсан.

## 26 Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага

**Шийдвэрээгүй хэрэг.** Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Банкны эсрэг зарга мэдүүлэх явдал гарч болох юм. Щвейцарь болон Герман улсуудад үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллагатай 2008 оноос хойш хийсэн аккредитивийн гэрээтэй холбоотойгоор шүүхэд нэхэмжилж, шүүх үйл ажиллагаа нь үргэлжилж байгаа. Гэсэн хэдий ч Банк энэ шүүхэд аккредитивийн гэрээний дагуу өөрийн хүлээсэн үүргийн хүрээнд байр сууриа баттай хамгаалж байгаа.

Үүнтэй холбогдуулан Банк 2009 онд нийт дүнгээр (хүүг оруулан) нь эрсдэлийн сан байгуулсан. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар уг сан 36,464 сая төгрөг (2011 онд 35,618 сая төгрөг) байсан. Тодруулга 19-ийг харна уу.

Эдгээр аккредитивтэй холбогдуулан Америкийн нэгдсэн улсын өмнөд Флоридагийн дүүргийн шүүхэд Банк залилан, гэрээний зөрчил гэх мэт хууль зөрчсөн үндэслэлээр тодорхой хувь хүн болон байгууллагуудыг шүүхэд дуудан зарга үүсгээд байгаа. Уг хувь хүн болон байгууллагаас нэхэмжилж буй дун нь Банкны төлж болзошгүй дээр дурдсан өр төлбөрөөс мэдэгдэхүйц хэмжээгээр давж байгаа юм. Хэрэг Банкны хувьд нааштай шийдэгдэх хандлагатай байгаа хэдий ч хариуцагчид авлагыг бүрэн хэмжээгээр барагдуулна гэсэн хангалттай баталгаа байхгүй байна. Тиймээс Банк санхүүгийн тайланда авлагах хүлээн зөвшөөрөөгүй боловч нэхэмжилсэн төлбөрөө барагдуулахаар туштай ажиллаж байна.

Удирдлага нь 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дээрх заргуудаас өөр ямар нэгэн материаллаг гарз учруулах нэхэмжлэгчээр дуудагдсан шүүн таслах хуулийн хэргийн талаар мэдээлэл байхгүй. Иймд дээрх аккредитивтэй холбоотой болзошгүй алдагдлын сангаас өөр ямар нэг санг санхүүгийн тайланда хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн.

**Зээлтэй холбоотой Төлбөрийн Хариуцлага.** Банк нь Монгол Улсын Засгийн газар эсвэл тэдгээрийн харьяа байгууллагуудын хүснэгтээр Монгол улсын хувьд чухал ач холбогдол бүхий салбарт (бараа үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлийн үүрэг хүлээдэг. Эдгээр хэрэгслүүдийн гол зорилго нь Засгийн газар болон холбогдох талуудыг шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино.

Аkkредитивүүд нь зээл болон аккредитивын хэмжээнээс ашиглагдаагүй үлдсэн хэсгийг илэрхийлнэ. Доорх мэдээллийг харна уу. Банк ийм зээлтэй холбоотой төлбөрийн хариуцлагын хувьд уг зээлээс ашиглагдаагүй үлдсэн хэмжээгээр алдагдал хүлээх эрсдэлтэй юм. Гэвч ихэнх зээл нь зээлийн эрсдэл багатай харилцагчдад олгогддог тул энэхүү болзошгүй алдагдын хэмжээ нь нийт ашиглагдаагүй байгаа төлбөрийн хариуцлагын хэжээнээс бага байна.

Зээлтэй холбоотой төлбөрийн хариуцлагын хэмжээг дор харуулав:

Сая төгрөгөөр	2012.12.31	2011.12.31
Ашиглагдаагүй зээлийн шугам - Хятадын Ардын Банк	89,356	554,075
Экспортын аккредитивүүд	61,856	73,688
<b>Нийт Зээлтэй холбоотой Төлбөрийн Хариуцлага</b>	<b>151,212</b>	<b>627,763</b>

**Банк, Хятадын Ардын банк хооронд Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцэлийн гэрээ.** Банк нь 2011 оны 5 дугаар сард “Хятадын Ардын Банк (БНХАУ-ын Төв Банк, цаашид “Хятадын ардын банк” гэх) болон Банк Хятадын юань/Монгол төгрөг (үндэсний мөнгөн тэмдэгт) солилцох своп хэлцэл”-ийн гэрээнд гарын үсэг зурсан. Энэхүү гэрээ нь хоёр улсын Төв банк хоорондын хамтын ажиллагаанд чухал алхам болоод зогсохгүй хоёр улсын банк, санхүү, эдийн засгийн харилцааны цаашдын хөгжлийг эрчимжүүлэх, дэмжихэд гол хөшүүрэг болох юм.

Банк хоорондын гэрээний дагуу Хятадын Ардын банк болон Банк нь юань болон төгрөг солилцох хэлцэлийг цаашид хийх зорилгоор эдгээр хоёр Төв банк тус бүрийнхээ мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн, хүү тооцдоггүй тусгай дансдыг нээсэн. Хятадын Ардын банк нь юаний дансыг Банкинд, Банк нь төгрөгийн дансыг Хятадын Ардын банкинд зориулан тус тус нээсэн.

Төв банкууд энэхүү мөнгөн хөрөнгийг санхүүгийн зах зээлийг тогтвортжуулах зорилгоор богино хугацаанд хөрвөх чадварыг хангах, хоёр орны хоорондын худалдааг санхүүгүүлэхэд болон гэрээнд заасан бусад зорилгоор ашиглана. Гэрээнд зааснаар энэхүү хөрөнгийн ашиглах хугацаа нь 3 - 6 сар байна. Хөрөнгө ашиглах зөвшөөрлийг нэг тал нь нөгөө талаас авах ёстой ба тухайн ашиглах хөрөнгийн хэмжээ нь Банкны хувьд гэрээний дун болох 10 тэрбум юань, Хятадын ардын

## 26 Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага (Үргэлжлэл)

банкны хувьд 2 их наяд төгрөгөөр хязгаарлагдана. Банк ашиглаж буй хөрөнгийн хэмжээндээ хүү тооцон төлөх ёстой бөгөөд энэ нь гэрээнд заагдсан байна. Банк юань ашигласан тохиолдолд, хүүгийн түвшин нь 200 суурь оноон дээр Шанхай-Интер Банк Санал болгосон түвшинг (“ШИБОР”) нэмсэнтэй тэнцэх ба ашиглах хугацааны турш тооцно. Харин Хятадын Ардын банк төгрөг ашиглсан тохиолдолд, хүүгийн түвшин нь банк хоорондын төгрөгийн жигнэсэн дундаж хүүгийн түвшингтэй тэнцүү байна.

2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк 2.5 тэрбум юаний анхны худалдан авалт хийсэн бөгөөд энэ дүнтэй тэнцэх хэмжээний төгрөгийг Хятадын Ардын банкинд худалдсан байна. Ингэснээр Хятадын Ардын банкин дахь хадгаламжийн хэмжээ өсч цаашид Хятадын Ардын банкнаас зөвшөөрөл авсны дагуу ашиглах эрх үүссэн байна. 2012 оны эхний улиралд Банк нь энэхүү хөрөнгийг ашиглах анхны хүсэлтээ гаргаснаас гадна гэрээнд тусгагдсан зээлийн хязгаарыг нэмсэн байна. Энэхүү хөрөнгийн харилцан ашиглах гэрээний анхны дүн болох 2.1 тэрбум юань (2011 онд тэг) нь хөрөнгийг ашиглах хүсэлтийн хязгаар болох ба энэ хэмжээ нь 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк зээлтэй холбоотой төлбөрийн хариуцлагын хэмжээг илтгэнэ.

Зээлийн анхны худалдан авалт нь зээлийн эрхийг нээж байгаа бөгөөд цаашид уг дүнг хүсэлтийн дагуу нэмэгдүүлэх боломжтой, тус зээлд хамаарах ашиглагдаагүй зээлийн үлдэгдэл болох 0.4 тэрбум хятадын юань (89,356 сая төгрөг) нь 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар (2011 онд 2,5 тэрбум хятадын юань буюу 554,075 сая төгрөгтэй тэнцүү) Банк уг зээлтэй холбоотой төлбөрийн хариуцлагыг харуулж байна.

**Экспортын аккредитив.** Экспортын аккредитив нь Монголын засгийн газарт экспортын гэрээ хэлцэлтэй холбоотойгоор олгогдоно. Экспортын аккредитивийн дагуу Банк Монгол улсын Засгийн газрын эсвэл төрийн байгууллагуудын өмнөөс Засгийн газрын эсвэл төрийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлсэн буюу бараа бүтээгдхүүн борлуулсан гадаадын байгууллага эсвэл Засгийн газрын хүссэн бусад байгууллагад төлбөр шилжүүлэх үүрэг хүлээнэ. Энэхүү тайланд тусгагдсан экспортын аккредитивын дүн нь АНУ, Швейцарь болон ХБНГУ-ийн шүүхэд шийдэгдээгүй байгаа заргатай холбоотойгоор үүссэн. Банк эдгээр хууль зүйн болзошгүй төлбөрүүдийн дунд найдваргүй авлагын санг байгуулсан ба Тодруулга 19-өөс харна уу.

Банкны удирдлага 2011 он болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар аккредитивийн шийдэгдээгүй хэрэгт байгуулсан сангаас бусад аккредитив, зээлийн шугамаарх үүрэг хариуцлагын бодит үнэ цэнийг материаллаг бус хэмээн дүгнэсэн байна. Ашиглагдаагүй байгаа зээлийн шугам болон аккредитивийн гэрээт үлдэгдэл нь ирээдүйн бэлэн мөнгөний шаардлагыг бий болгохгүй. Учир нь эдгээр санхүүгийн хэрэгслүүд нь ямар нэгэн санхүүжилтгүйгээр хугацаа нь дуусах буюу цуцлагддаг.

## 27 Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Банк үйл ажиллагаа нь ямагт эрсдэлтэй байдаг тиймээс ч эдгээр эрсдэлийг тогтмол хянаж зөв зохистой бодлого баримтлах нь банкны гол зорилго. Эдгээр эрсдэлийг зохистой удирдах нь Монголын банкуудын үйл ажиллагааг хэвийн явуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж инфляцийг зохистой түвшинд барих зөв мөнгөний бодлого явуулахад чухал шаардлагатай. Эдгээр эрсдэлүүд нь банкны тэргүүний зорилгодоо хүрэх чадварыг хязгаарлах үр дагавартай байж болно. Энэ нь Банкинд илүүтэй илрэх бөгөөд гадаад валютын ханшийн зөрүүнээс хүлээх санхүүгийн гэнэтийн алдагдал нь үүний нэг жишээ болно. Эдгээр санхүүгийн алдагдал нь бүхий л төрлийн санхүүгийн эрсдэлээс хамааралтай үүсдэг.

Банкинд тулгарах эрсдэлүүд нь санхүүгийн (зээлийн, хөрвөх чадварын, зах зээлийн), үйл ажиллагааны, нэр хүндээ хадгалах мөн эрх зүйн эрсдэлүүдээс бүрдэнэ. Одоогийн банкны эрсдэлийн удирдлага нь төвлөрсөн бус бөгөөд газар тус бүр тэдгээрийн үйл ажиллагаанд учирсан аливаа эрсдэлээс сэргийлэх бодлого баримталдаг. Банк нь Монгол улсын Төв банк учраас түүний эрсдэлүүд онцгой байdag ба тэдгээр эрсдэлүүдийг Банк стратеги төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан хянаж, илрүүлж байdag. Үүнээс гадна Банк нь эрсдэлийн хяналтын стратегийг боловсруулах ба зарчим, хүрээ, бодлого хязгааруудыг хэрэгжүүлэх ажлыг ерөнхийлөн хариуцах “Эрсдэлийн хороо”-г байгуулах боломжийг идэвхитэй хайж байна. Одоогоор Хөрөнгө оруулалтын хороо нь эрсдэлийн стратегийг боловсруулж, шаардлагатай хязгаарыг тогтоох үүрэгтэй байхад Эрсдэлийн удирдлагын алба болон Валют, эдийн засгийн газар нь үүнтэй холбоотой зарчмууд, үйлчлэх хүрээ, бодлого, хязгаарыг хэрэгжүүлдэг.

## 27 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

**Эрсдэлийн Удирдлагын бүтэц.** Захирлуудын зөвлөл нь эрсдэлүүдийг тодорхойлж хянахад эцсийн хариуцлага хүлээнэ. Гэхдээ эрсдэлийг удирдах, хянах үүрэг бүхий бие даасан нэгжүүд байдаг.

Захирлуудын Зөвлөл. Захирлуудын Зөвлөл ерөнхий эрсдэлийн удирдлага болон эрсдэлийн стратеги, бодлогыг батлахаас гадна эрсдэлтэй холбоотой асуудлаар Банкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгчид зөвлөмж өгдөг.

**Хяналтын Зөвлөл.** Хяналтын зөвлөл нь Банкны дотоод бүтэц, зохион байгуулалтад харьялагддаггүй бөгөөд бие даасан хяналт тавьж, Банк үйл ажиллагааны эрсдэлийг ерөнхийд нь хянах үүрэгтэй.

**Хөрөнгө оруулалтын хороо.** Хөрөнгө оруулалтын хороо нь банкны эрсдэлийг удирдах үүрэгтэй хамгийн гол хэсэг бөгөөд Захирлуудын Зөвлөл, Ерөнхийлөгчид эрсдэлийн удирдлагын бодлого дээр зөвлөмж өгдөг. Хөрөнгө оруулалтын хорооны бүрэлдэхүүнд Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Валют, эдийн засгийн газрын захирал, Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын захирал, Эрсдэлийн удирдлагын албаны захирал нар багтдаг.

Хөрөнгө оруулалтын хороо нь тайлант оны “хөрөнгө оруулалтын бодлого”-ыг баталж, зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинг тодорхойлдог. Энэхүү зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинд үндэслэн Улсын гадаад валютын нөөцийн бүтцийг гарган ерөнхийлөгчид барина. Үүнд гадаад валютын нөөцийн бүтэц, түүний зохистой хэлбэлзэл, хөрөнгийн хуваарилалт, түүний зохистой хэлбэлзэл, хөрөнгө оруулалтын хугацаа, боломжит хэрэгсэл, харилцагч байгууллагад тавьсан хязгаарлалт зэргийг тусгана. Ерөнхийлөгч гадаад валютын нөөцтэй холбоотой хэмжээг улирал тутамд батлах бөгөөд энэ нь гадаад валют, зээл, хөрвөх чадвар, хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол арга юм.

Банкны гадаад валютын нөөцийн эрсдэл нь хамгийн чухал ба үүнийг Банкны нийт хөрөнгөд гадаад валютын хөрөнгийн эзлэх хувиар тооцоолно. Тиймээс Хөрөнгө оруулалтын хороо болон холбогдох газруудын явуулдаг үйл ажиллагаа нь гадаад валютын нөөцтэй холбоотой эрсдэлийг удирдан хяналт тавихад тулхүү чиглэгдэнэ. Хөрөнгө оруулалтын хорооны өөр нэгэн үүрэг бол Эрсдэлийн удирдлагын алба болон бусад холбогдох газруудад хяналт тавих бөгөөд тэдгээр нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн эрсдэл болон хэрэгжилт бодлоготой нийтэй байгаа эсэхэд ерөнхийлөн анхаарч ажилладаг.

**Эрсдэлийн Удирдлагын Алба.** Эрсдэлийн удирдлагын алба ("ЭУА") нь гадаад валютын нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, бусад эрсдэлтэй холбоотой үйл ажиллагаа, хараат бус хяналтын үүрэг гүйцэтгэдэг. Мөн гадаад валютын нөөцийн удирдлага, эрсдэлийн бодлого, хязгааруудын хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг хариуцдаг.

Гадаад Валютын Улсын Нөөцийн Удирдлагын журамд зааснаар, нөөцийн удирдлагын зорилго нь Банк мөнгөний болон гадаад валютын бодлогыг хослуулахад оршино. Гадаад валютын нөөцийн гол зорилго нь:

- Мөнгөний бодлогыг дэмжих
- Зах зээлийн валютын ханшийн хэт хэлбэлзлийг зохицуулах
- Засгийн газрын Валютын өр төлбөрт баталгаа гаргах
- Улс орны хэмжээнд тохиолдсон гамшиг болон онцгой байдлын үед мөнгөний эх үүсвэр болгон хэрэглэгдэх

Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг бодлоготойгоор удирдах, хянаснаар гадаад валютын нөөцийн эрсдэлийн удирдлага дээрх зорилгод дэмжлэг болно. Гадаад эрсдэлийг хянах зорилгоор Банк нь хөрөнгийн сонголт болон хуваарилалтыг хийдэг. Ингэхдээ төлбөр бололцоот хөрвөх чадварыг хангах зорилгоор шаардлагатай гадаад валютын бүтэц, үнэт цаас хөрөнгө, хөрвөх чадварын шаардлагад нийцэх хөрөнгө оруулалтын хэрэгсэлт хязгаарлалт тавих, хүүгийн түвшний эрсдэлийг хязгаарлах зорилгоор хугацаанд параметр тогтоодог.

**Валют, эдийн засгийн газар.** Валют, эдийн засгийн газар нь холбогдох тусгай албууудаараа дамжуулан хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Валют, эдийн засгийн газрын захирал нь хөрөнгийн бүрдэл, хэрэгслүүд, харилцагч талууд, дуусгавар хугацаа, гадаад валютын хөрөнгийн хэмжээ зэрэг хөрөнгийн асуудлуудыг удирдан хянах үүрэгтэй.

**Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар.** Эрсдэлийн удирдлагын системийн үр бүтээлтэй, шаардлага хангахуйц байдлыг үнэлж дүгнэн шалгах нь Банкны дотоод хяналтын гол зорилго ба 2012 оны 10 дугаар сард Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газрыг шинэчлэн байгуулсан. Банкны үйл ажиллагааг зүй зохистой хууль журамд нийцүүлэн явуулах,

## 27 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Зохион байгуулах зохицуулах, хэрэгжүүлэх, бүх шатны эрсдэлийн удирдлагын үр бүтээлтэй байдлыг хянах нь Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газрын гол зорилт билээ. Дотоод хяналт нь эрсдэлүүдээ хэмжихдээ ерөнхий ба нарийвчилсан түвшинд хуваан авч үздэг. Ерөнхий эрсдэлийн үнэлэлт нь урт хугацааны болон жилийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дор явагдаж, эрсдэл бүрийн хэмжээнээс хамааран хяналт шалгалтын ажлыг зохистой хуваарилахад чиглэсэн бол нарийвчилсан түвшний эрсдэлийн үнэлгээ нь ямар нэгэн тулгарсан асуудлыг үргэлжлүүлэн нарийвчлан судлах үед хийгдэг байна. Банкны дотоод хяналт нь 2012 оны жилийн хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулж, үйл ажилгааны нэгж бүрт эрсдэлийг үнэлэхийн тулд тэдгээрт шалгуур тавин ажиллаж байна. Тодорхой шалгууруудыг боловсруулж тэдгээрийг жигнэсэн дундаж онооны аргаар эрсдэл учирч болох бүх үйл ажиллагааны нэгжид хуваарилан, нийт эрсдэлийн хэмжээг ерөнхийд нь гаргаж, өндөр, дунд, бага хэмээн ангилсан байна.

Банкны салбар, нэгжүүдийн үйл ажиллагааны хяналтын системийг үнэлж дүгнэх нь дотоод хяналтын ажлын чухал нэг хэсэг юм. Энэхүү үнэлгээ нь санхүүгийн тайлангийн системийн найдвартай байдал болон холбогдох хууль журмыг даган мөрдөж байгаа эсэхийг шалгахад чиглэсэн.

Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар нь шалгалтын бүх дүгнэлтийг Ерөнхийлөгчид болон Захирлуудын зөвлөлд тайлагнадаг. Шалгалт бүрийн эцэст холбогдох газар, хэлтсийн удирдлагатай шалгалтын үр дүнг хэлэлцэж, шалгалтын дагуу өгсөн үүрэг даалгаврыг эдгээр газар, хэлтэс, салбар биелүүлсэн байдалд хяналт тавина.

**Зээлийн Эрсдэл.** Зээлийн эрсдэл нь гэрээ байгуулсан хэрэглэгч, үйлчлүүлэгч, гуравдагч талууд үүргээ биелүүлж чадахгүйд хүрснээс үүдэн алдагдал хүлээж болох нэг төрлийн эрсдэл юм.

Санхүүгийн хөрөнгө нэмэгдүүлэх зорилгоор гуравдагч талуудтай хийсэн ажил гүйлгээ болон банкны зээл олголтоос үүдэн зээлийн эрсдэл бий болдог. Зээлийн эрсдэлийг удирдахаа хөрөнгө оруулалт хийх хөрөнгөө зөв сонгох, нэг төрлийн хөрөнгөнд хийх хөрөнгө оруулалтын хэмжээнд хязгаар тогтоох арга замаар удирддаг. Хөрөнгө оруулалтын төрөл, гуравдагч талуудаас хамааралтай үүдэх зээлийн эрсдэлийн түвшний хязгаарыг удирдлагаас ойр ойрхон тогтоож жил тутам тогтмол хяналт тавьдаг. Банк санхүүгийн хөрөнгийн зээлийх чанарыг олон улсын үнэлгээний байгууллагаас тогтоосон жишигт тулгуурладаг бол тухайн гадны байгууллагад (Жишээ нь Төв банк) тусгайлан тогтоосон үнэлгээ байхгүй тохиолдолд тухайн орны үнэлгээнд тулгуурлана. Банк нь хэрвээ олон улсын зах зээлийн байдал тогтвортгуй байвал системийн эрсдэлд орохоос зайлсхийж тухайн байгууллагуудын үнэлгээг үл харгалзан үйл ажиллагаагаа зогсоо шаардлагатай.

Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд гадаад валютын нөөцийг AAA рейтингтэй Засгийн газар (эсвэл Төв банк)-ын болон олон улсын байгууллагаудын үнэт цаасанд хөрөнгө оруулдаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хадгаламж болон мөнгөний зах зээлийн хэрэгслүүдэд учрах зээлийн эрсдэл нь олон улсын үнэлгээний байгууллагаудаас AA болон түүнээс дээш рейтинг авсан харилцагчидтай ажил болон гүйлгээ явуулах замаар хязгаарлагдаж байна. Хэрэв харилцагч нь нэгээс дээш үнэлгээний байгууллагаас үнэлгээ (рейтинг) авсан хамгийн бага үнэлгээнд нь үндэслэдэг.

Дотоодын мөнгөний бодлогын үйл ажиллагааны хувьд Банк зээлийн эрсдэлээ бууруулахын тулд барьцаа хөрөнгийг түлхүү хэрэглэдэг. Төв банкнаас санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгийн жагсаалтад заасан үндсэн төрлийн барьцаа хөрөнгүүдийг дор дурдав:

1. Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)
2. Богино хугацаат Засгийн газрын үнэт цаас
3. Банкны хүлээн зөвшөөрсөн, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны гишүүн орнуудын (ОУЭЗХАГО) Засгийн газраас гаргасан үнэт цаас
4. Гадаадын томоохон санхүүгийн байгууллагад эзэмшилтэй, AAA рейтингтэй эргэн төлөгдөх чадвар өндөртэй үнэт цаас
5. Банкны хүлээн зөвшөөрсөн санхүүгийн байгууллагуудын өрийн бичгүүд
6. Банкинд болон гадаадын банкинд байршуулсан хугацаат хадгаламжууд.

Банк тогтоосон зохистой харьцаануудын шалгуурыг бүх зээлдэгч банкууд хангах ёстой. Хэрэв дотоодын зээлдэгч банкууд энэхүү харьцаануудаас нэгийг л биелүүлээгүй тохиолдолд Банк тухайн банкинд олгох буюу олгосон зээлийн үйл ажиллагаагаа цуцалдаг.

Монголын томоохон банкууд нь олон улсын үнэлгээний байгууллагаудаар зэрэглэлээ тогтоолгодог учир

## 27 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

дотоодын банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийг энэхүү үнэлгээн дээр тулгуурлан хянана. Ретингтүй банкуудын хувьд, Банк тэдгээр банкуудын сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэл, санхүүгийн харьцааны шинжилгээ болон хамааралтай хөрөнгийн зээлийн эрсдэлийг тодорхойлоход хэрэглэдэг Банкны Хяналт шалгалтын газраас гаргаж буй болон бусад олдоцтой мэдээлэлд тулгуурлан дүгнэлт гаргадаг. Одоогоор Банк нь өөрийн боловсруулсан зээлийн үнэлгээний системийг банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлийг үнэлэхдээ ашиглаагүй байна.

Цаашилбал, бүх харилцагчдад зээлийн хязгаар байдаг бөгөөд энэ нь тэдний зээлийн үнэлгээ, хувь нийлүүлсэн хөрөнгө болон бусад хүчин зүйлд үндэслэгдэнэ. Хөрөнгө оруулалтын хороо нь зээлийн хязгаарыг улирал бүр тогтоох бөгөөд зээл нь тухайн хязгаартаа байгаа эсэхийг өдөр тутам хянана. Банк өөрийн зээлийн эрсдэлийг хянахын тулд санхүүгийн хөрөнгийнхөө, ялангуяа банкуудад олгосон зээл болон бусад санхүүгийн хөрөнгө (Тодруулга 12 болон 14) -ийн наскилтын шинжилгээг хийдэг байна. Зээлээ эргэн төлөх чадвар нь муудаж буй харилцагчдын талаарх мэдээлэл Захирлуудын Зөвлөлд хүргэгдэх ба тэд хэлэлцэн үзэж шаардлагатай шийдвэрийг гаргана.

